| **Ажилласан туршлага:** | ▪ 1987-1990 онд БЦУГ-ын Засвар механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер<br>▪ 1990-1993 онд Автомашины салхины шилний Төслийн удирдагч, тус төслийн үр дүнд Автомашины салхины шилний үйлдвэр “Чин” ХХК байгуулагдсан.<br>▪ 1995-1999 онд Монгаз төслийг санаачлагч, төслийн удирдагчаар ажиллаж, “НИК ГАЗ” ХХК компани байгуулагдсан.<br>▪ 1999-2012 онд “Монголшил” төслийн удирдагч, төслийн үр дүнд шилэн лонхны үйлдвэрийн төсөл хийгдэж байна.<br>▪ 2005 оноос чулуун хөвөн чулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, төслийн удирдагч, “Монгол базальт”, BASALTWOOL, ROCKWOOL компанийн Ерөнхий захирал, ТУЗ-н даргаар ажиллаж байна. |

*Хүснэгт 16 Гүйцэтгэх удирдлагын танилцуулга*

| Албан тушаал: | Ерөнхий удирдлага, үйлдвэрлэл, судалгаа хөгжил эрхэлсэн захирал |
|---|---|
| **Овог нэр** | П. Батмөнх |
| **Мэргэжил** | Эрх зүйч |
| **Төрсөн огноо** | 1974 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1992-2003 онд “Чин” ХХК-д Ерөнхий менежер<br>▪ 2003-2006 онд “Жи Би Эл” ХХК-д Ерөнхий менежер<br>▪ 2006-“Монгол базальт” ХК-д Ерөнхий удирдлага эрхэлсэн захирал |

*Хүснэгт 17 Ерөнхий удирдлага эрхэлсэн захирлын танилцуулга*

| Албан тушаал: | Санхүү эрхэлсэн захирал |
|---|---|
| **Овог нэр** | П. Сайнбилэг |
| **Мэргэжил** | Банк, Санхүүч |
| **Төрсөн огноо** | 1964 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1997-2001 онд Сайн Сан ХХК-д Захирал<br>▪ 2001-2005 онд Жи Ви Эл ХХК-д гүйцэтгэх захирал<br>▪ 2005- “Монгол базальт” компанид санхүү эрхэлсэн захирал |

*Хүснэгт 18 Санхүү эрхэлсэн захирлын танилцуулга*

| Албан тушаал: | Худалдаа эрхэлсэн захирал |
|---|---|
| Овог нэр | Д. Сайнбаатар |
| Мэргэжил | Инженер - Эдийн Засагч |
| Төрсөн огноо | 1981 |
| Иргэншил | Монгол |
| Боловсрол | Дээд |
| Ажилласан туршлага: | ▪ 2003-2005 Инженер Эдийн засагч Монгол базальт ХК<br>▪ 2005-2012 Төсөл хариуцсан захирал Монгол базальт ХК<br>▪ 2012- "Монгол базальт" компанид худалдаа эрхэлсэн захирал |

*Хүснэгт 19 Худалдаа эрхэлсэн захирлын танилцуулга*

### 1.1.7 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 3.1-д зааснаар хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,949,190,000 төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцаанаас бүрдэх ба нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 39,491,900 ширхэг хувьцаанаас бүрдэж байна. Үүнээс 51.0% буюу 2,014,086,900 төгрөгийг Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч Л.Ариунболд, 19.0% буюу 750,346,100 төгрөгийг П.Сайнбилэг, 10.0% буюу 394,919,000 төгрөгийг А.Энхгэрэл, 10.0% буюу 394,919,000 төгрөгийг А.Энхмаа, 10.0% буюу 394,919,000 төгрөгийг А.Энхжин хувь нийлүүлсэн байна.

| Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр | Эзэмших хувьцааны тоо (ш) | Эзэмших дүрмийн сангийн хэмжээ (₮) | Эзэмшлийн хувь (%) |
|---|---|---|---|
| Лхагважавын Ариунболд | 20,140,869 | 2,014,086,900 | 51.0 |
| Пүрэвбанзрагчийн Сайнбилэг | 7,503,461 | 750,346,100 | 19.0 |
| Ариунболдын Энхгэрэл | 3,949,190 | 394,919,000 | 10.0 |
| Ариунболдын Энхмаа | 3,949,190 | 394,919,000 | 10.0 |
| Ариунболдын Энхжин | 3,949,190 | 394,919,000 | 10.0 |
| **Нийт** | **39,491,900** | **3,949,190,000** | **100** |

*Хүснэгт 20 Хувь нийлүүлсэн хөрөнгө*

### 1.1.8 Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө

Аудитын "Бэст Фортуна Аудит" ХХК-ийн гүйцэтгэсэн аудитын тайланд тусгаснаар 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 21.7 тэрбум төгрөг байна. Үүнээс хувь нийлүүлсэн хөрөнгө 3.9 тэрбум төгрөг, хуримтлагдсан ашиг 613.6 сая төгрөг, нэмж төлөгдсөн капитал 17.1 тэрбум төгрөг байна. Мөн энэхүү тайланд тусгаснаар Үнэт цаас гаргагч нь 22.2 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй ба үүнээс үндсэн хөрөнгө 19.4 тэрбум, биет бус хөрөнгө 2.8 тэрбум байна.

Үнэт цаас гаргагч нь 2015 оны 08 сарын 07-нд батлагдсан "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулийн хүрээнд 2014 оны санхүүгийн тайланд биет болон биет бус хөрөнгөө дахин үнэлж тусгахдаа гарсан хөрөнгийн үнэлгээний зөрүү 18.6 тэрбум төгрөгийг "Нэмж төлөгдсөн капитал" дансанд тусгаж санхүүгийн тайлангаа эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна. Мөн үндсэн хөрөнгө 20.2 тэрбум, биет бус хөрөнгө 2.8 тэрбум болж тус тус нэмэгдсэн бөгөөд биет бус хөрөнгө нь MY-017426 дугаартай Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт байрлах Ногоон уулын базальтан чулуун орд юм. 2013 оны санхүүгийн тайланд 6.8 сая төгрөгөөр тусгагдсан байсан уг ордыг 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дахин үнэлгээ хийж 2.8 тэрбум төгрөгөөр тусгасан байна.

Үнэлгээний "Мөнх Оргил Трэйд ХХК"-ийн гүйцэтгэсэн 2017 оны 12 сарын 22-ны байдлаар үнэлсэн "Хөрөнгийн үнэлгээний тайлан"-д тусгаснаар Үнэт цаас гаргагч нь нийт 22,409.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна. Үүнд компанийн балансад байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө, эзэмшил газар, базальтын орд зэрэг 7 төрлийн үндсэн хөрөнгүүд орсон ба уг үнэлгээг "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон Олон улсын үнэлгээний стандартад заасны дагуу гүйцэтгэсэн болно. Энэхүү үнэлгээний тайланд Үнэт цаас

гаргагчийн эзэмшлийн 16 нэрийн барилга байгууламж, 32 нэрийн тоног төхөөрөмж, 14 нэрийн тээврийн хэрэгсэл, машин, механизм, 73 нэрийн тавилга, эд хогшил, 3 эзэмшил газар, компанийн эзэмшилд байгаа базальт орд болон биет бус хөрөнгийг тооцсон байна.

| Хөрөнгийн нэр | Эцсийн үнэлгээ (сая төгрөг) |
|---|---|
| Барилга байгууламж | 3,452.5 |
| Тоног төхөөрөмж | 9,051.3 |
| Тээврийн хэрэгсэл, машин, механизм | 117.1 |
| Тавилга, эд хогшил | 31.7 |
| Биет бус хөрөнгө | 2.0 |
| Эзэмшил газар | 6,628.3 |
| Базальтын орд | 3,066.9 |
| **Нийт дүн** | **22,409.8** |

*Хүснэгт 21 Үндсэн хөрөнгийн үнэлгээ*

Үнэлгээний “Мөнх Оргил Трэйд ХХК”-ийн гүйцэтгэсэн хөрөнгийн үнэлгээний тайланд Үнэт цаас гаргагчийн дараах үл хөдлөх хөрөнгүүд хамрагдсан байна. *Үнэт цаас гаргагчийн Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон газар эзэмших эрхийн гэрчилгээг Хавсралт 13-15-аас харна уу.*

| | Барилга, байгууламж | Ашиглалтад орсон | Нийт талбай ($м^2$) |
|---|---|---|---|
| 1 | Конторын барилга | 2012 | 172.8 |
| 2 | Үйлдвэрийн барилга | 1986 | 1,944.0 |
| 3 | Ажилчдын цайны газар, караоке, офисын барилга | 2009 | 148.7 |
| 4 | Хөөсөнцрийн үйлдвэрийн барилга | 2012 | 579.6 |
| 5 | Бэлэн бүтээгдэхүүний складын барилга | 2012 | 405.7 |
| 6 | Вагранк зуухны барилга | 2007 | 94.9 |
| 7 | Цавууны цехийн барилга | 2007 | 89.7 |
| 8 | Химийн бодисын агуулах | 2012 | 109.2 |
| 9 | Цилиндр шугам хоолойн үйлдвэрийн барилга | 2012 | 262.5 |
| 10 | Метан зуухны байгууламж | 2007 | - |
| 11 | Усан сан | 2007 | 50.0 $м^3$ |
| 12 | Гадна цэвэр усны шугам | 2007 | - |
| 13 | 400 квт трансформатор | 2007 | 1 ш |
| 14 | 140 м цахилгааны гадна шугам | 2007 | 140 м |
| 15 | Үйлдвэрийн бетонон хашаа | 2007 | 59 ш |
| 16 | Цэвэрлэх байгууламж | 2007 | 11.25 |

*Хүснэгт 22 Барилга байгууламж*

| | Эзэмшил газар | Гэрчилгээний дугаар | Нийт талбай ($м^2$) | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | БГД, 20-р хороо | № 0232516 2011.12.22 | 9,462.0 | Агуулах, аж ахуйн зориулалттай |
| 2 | БГД, 20-р хороо, Моннаб ХХК-ний зүүн урд | № 0293323 2012.05.23 | 4,203.0 | Агуулах, аж ахуйн зориулалттай |
| 3 | Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг | № 000300476 2014.04.14 | 10,000.0 | Үйлдвэрийн зориулалттай |

*Хүснэгт 23 Эзэмшил газар*

Үнэт цаас гаргагчийн эзэмших MY-017426 дугаартай Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт байрлах Ногоон уулын базальтан чулуун орд нь 2,116.6 мян.тн нөөцтэй, уурхайн хүчин чадал 58.3 мян.тн бөгөөд ордыг ашиглаж дуусах хугацаа нь 36 жил болж байна. Төв аймгийн Баяндэлгэр сумын трахибазальтийн илрэлд эрэл, хайгуулын ажил хийж, нөөцийг тогтоон, эрдсийн хөвөнгийн түүхий эд болгон ашиглах зорилгоор Улаанбаатар хотын

Сүхбаатар дүүрэгт бүртгэлтэй "Монголтрахибазальт" ХХК хайгуул хийх 13235X тоот тусгай зөвшөөрлийг 2008 оны 02 сарын 06-нд авсан юм. Хайгуулын үр дүнд 2,116.6 мян.тн нөөцтэй "Ногоон уул" нэртэй трахибазальтын ордыг илрүүлж үнэт цаас гаргагч нь MY-017426 дугаарт Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг авсан байна. *Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг Хавсралт 12-оос харна уу.*

| Базальт чулуун ордын мэдээлэл | Тайлбар |
|---|---|
| **Ордын эзэмшигч** | "Монгол базальт" ХК |
| **Байршил** | Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт орших "Ногоон уул" нэртэй трахибазальтын орд |
| **Талбайн хэмжээ** | 32.39 га |
| **Газарзүйн солбилцол** | "Ногоон уул"-ын талбай L-48-96, MY-017426<br>1. 108°10'16.57" 47°29'53.73"<br>2. 108° 9'51.57" 47°29'53.73"<br>3. 108° 9'51.48" 47°30'13.77"<br>4. 108° 9'16.48" 47°30'13.77" |
| **Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл** | Дугаар: MY-017426, Олгосон огноо:2013.12.10 |
| **Ордын геологийн бодит /B/ нөөц** | Трахибазальт 2,031.3 мян.тн |
| **Ордын үйлдвэрлэлийн нөөц** | Трахибазальт 2,116.6 мян.тн |
| **Уурхайн жилийн хүчин чадал** | Трахибазальт 58.3 мян.тн |
| **Ордын ашиглалтын хугацаа** | 10 жил |
| **Эхний жилийн нийт хөрөнгө оруулалт** | 820 сая төгрөг |

*Хүснэгт 24 Эзэмшлийн ордын товч тодорхойлолт*

"Ногоон уул" нэртэй трахибазальтын орд нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт Хар толгойн орчим, Улаанбаатараас 158 км, Архуст сумаас 40 км, Баяндэлгэрийн 3-р бригадаас 16 км, Багануурын нүүрсний уурхайгаас 35 км зайтай оршино. Ордын зуун хойно 8 км зайд Чулуут-Интернэшнл компанийн хайлуур жоншны уурхай ажиллаж байгаа.




*Зураг 5 Трахибазальтын ордын байршил*

СЗХ БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

## 1.1.9 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь базальт чулуун хөвөнгийн үйлдвэрлэл болон худалдаа бөгөөд Монгол Улсын базальт чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал үйлдвэрлэгч цорын ганц компани юм.

Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт орших “Ногоон уул” нэртэй трахибазальтын ордноос ил уурхайн аргаар үйлдвэрлэлийн гол түүхий эд болох базальт чулууг олборлодог бөгөөд ингэснээр гол түүхий эдийг бусдаас хамааралгүйгээр чанарын өндөр төвшинд найдвартай бэлтгэн нийлүүлдэг давуу талтай. Энэхүү байгалийн цэвэр бүтээгдэхүүн базальт чулууг компани Улаанбаатар хот дахь өөрийн үйлдвэрт өндөр температурт хайлуулж чулуун хөвөн гаргаж авдаг ба хөвөнг нягтруулж төрөл бүрийн хавтан үйлдвэрлэдэг байна.



*Зураг 8 Базальт чулуу*



*Зураг 8 Базальт хөвөн*




*Зураг 8 Базальт хөвөн*

Чулуун хөвөн дулаалгын материал нь дулаан хадгалах чадвар өндөр, олон төрлийн хэлбэрт оруулахад хялбар, галд тэсвэртэй гэх мэт шинжүүдийг агуулдгаараа дулаалгын хамгийн сайн чанартай бүтээгдэхүүн болдог. Анх Европ, цаашлаад АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудад 20 дугаар зууны эхэн үед танигдсан энэ бүтээгдэхүүн, удаан хугацаанд тасралтгүй хөгжиж чанар нь сайжирсаар өнөө үетэй золгоод байна.

### Гол бүтээгдэхүүнүүд болон бүтээгдэхүүний хэрэглээ

Компани өөрийн уурхайгаас олборлосон түүхий эд болох базальт чулууг ашиглан жилд 5,000 тн буюу 50,000 м$^3$ чулуун хөвөн материал үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд одоогийн байгаа хүчин чадал, тоног төхөөрөмжийн хүрээнд 50-250 кг/м$^3$ эзлэхүүний масстай, 0.036-0.048 вт/м дулаан дамжуулалтын илтгэлцүүр бүхий чулуун хөвөн, чулуун хөвөн хавтанцар, уян хатан чулуун хөвөн хөнжил, чулуун хөвөн хоолой, шүршдэг чулуун хөвөн зэрэг 5 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Чулуун хөвөн хавтан нь компанийн гол бүтээгдэхүүн бөгөөд нийт борлуулалтыг бүхэлд нь энэхүү бүтээгдэхүүн эзэлж байгаа боловч бусад бүтээгдэхүүний хэрэгцээ ч мөн цаашид өсөн нэмэгдэх боломж өндөр байна.

**Бүтээгдэхүүн 1 - Basaltwool Batts (Хавтан)**

**Нягт**: 60 кг/м$^3$-120 кг/м$^3$ **Урт**: 1000мм
**Зузаан**: 50-100мм **Өргөн**: 600мм








*Зураг 9 Базальт хавтан*

Хэрэглээ:

Буцаг Алтай 2087103 ПЮН0230
BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК ДУЛААН ТУСГААРЛАГЧ МАТЕРИАЛ ҮЙЛДВЭР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

- Барилгын дотор, гадна хана, агааржуулалттай фасадны байгууламжийн дулаан тусгаарлагч,
- Бетонон шал, таазны дээрх дулаан тусгаарлагч.




*Зураг 10 Базальт хавтан бүтээгдэхүүний хэрэглээ*

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР

**Бүтээгдэхүүн 2 - Basaltwool Flexible (Уян хатан хөвсгөр хавтан)**

Нягт: 60кг/м3-120 кг/м3
Зузаан: 50-100мм
Урт: 1000мм
Өргөн: 600мм
Хэрэглээ:

- Амины орон сууц, Зуслангийн байшин, Канада Хаус зэрэг байшингуудын хана, тааз, дээвэр шалны дулаан тусгаарлагч.

**Базальт чулуун хөвөн хавтангийн үнэ**

Компани өөрийн үндсэн бүтээгдэхүүн болох чулуун хөвөн хавтанг харилцагчийн хэрэгцээ, шаардлагаас хамааран олон төрлийн өргөн, зузаан, нягтшилтайгаар үйлдвэрлэдэг. Барилгын дулаалгад хамгийн өргөн хэрэглэдэг базальт хавтан нь 3-н төрлийн зузаантай 4-н төрлийн маркаар үйлдвэрлэгдэн зах зээлд нийлүүлэгдэж байна.

| Чулуун хөвөн хавтан | Марк | Хэмжээс | Үнэ /төгрөг/ | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1ш 0.6 м$^2$ | 1 м$^2$ | 1 бдл 3.6м$^2$ | 1 бдл 2.4 м$^2$ | 1 м$^3$ |
| 5см зузаан | M60 | 1x0.6x0.05 | 4,800 | 8,000 | 28,800 | | 160,000 |
| | M75 | | 5,450 | 9,098 | 32,760 | | 181,915 |
| | M100 | | 7,095 | 11,825 | 42,570 | | 236,500 |
| | M125 | | 9,075 | 15,125 | 54,450 | | 302,500 |
| 8см зузаан | M75 | 1x0.6x0.08 | 8,736 | 14,553 | | 34,923 | 181,915 |
| | M100 | | 11,352 | 15,600 | | 45,408 | 236,500 |
| | M125 | | 14,520 | 18,920 | | 58,080 | 302,500 |
| 10 см зузаан | M60 | 1x0.6x0.10 | 9,600 | 16,000 | | 38,400 | 160,000 |
| | M75 | | 10,915 | 18,191 | | 46,800 | 181,915 |
| | M100 | | 14,190 | 23,650 | | 56,760 | 236,500 |

*Хүснэгт 25 Бүтээгдэхүүний үнэ*

**Өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үнэ**

Үнэт цаас гаргагчийн базальт чулуун хөвөн хавтан нь өрсөлдөгч бүтээгдэхүүн болох хөөсөнцөр дулаалгын материалын үнээс харьцангуй өндөр буюу 1 м$^2$ хавтангийн үнэ 70-120 хувиар өндөр үнэтэй байна. Харин дотоодын бусад төрлийн дулаалгын материал үйлдвэрлэгч компаниудын бүтээгдэхүүнтэй харьцуулахад 30-50% хямд байна.

| Компани | Дулаалгын материалын төрөл | Зузаан | Зориулалт | 1 М$^2$ үнэ /НӨАТ орсон/ |
|---|---|---|---|---|
| **Монгол базальт ХК** | Чулуун хөвөн хавтан | 15 см<br>20 см | Гадна хана, адрын дулаалга | ₮31,200<br>₮52,275 |
| Эконоос ХХК | Хонины ноосон дулаалга | 15 см<br>20 см | Гадна хана, адрын дулаалга | ₮36,000<br>₮57,000 |
| Росторг ХХК | Кнауф дом хавтан, төмөр өнгөлгөөтэй | 5 см<br>15 см<br>20 см | Суурийн гадна, гадна хана, адрын дулаалга | ₮15,800<br>₮19,300<br>₮56,600 |
| ЭБМАТ ХХК | Тоосгон өнгөлгөөтэй полиуретан хавтан | 11.3 см | Гадна ханын дулаалга | ₮66,400 |
| Пирамид индустри | Чулуун өнгөлгөөтэй хөөсөнцөр хавтан | 15 см | Гадна ханын дулаалга | ₮41,086 |
| Гүрэн Өргөө ХХК | Чулуун өнгөлгөөтэй хөөсөнцөр хавтан | 15 см | Гадна ханын дулаалга | ₮40,030<br>₮53,334 |

*Хүснэгт 26 Дулаалгын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үнийн харьцуулалт*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

## Бүтээгдэхүүн 3 - Thermobasalt Pipe (Уян болон шулуун хоолой)

Үнэт цаас гаргагч нь 2013 онд Термобазальт эрдэст чулуун хөвөн шугам хоолойн дулаан тусгаарлагч үйлдвэрийг өөрийн үйлдвэрийн байранд нэмж байгуулсан бөгөөд уг дулаан тусгаарлагч нь Улаанбаатар хотын дулааны шугам хоолойн дулаалгыг шинэчилж, дулаан алдагдлыг багасгахад маш үр дүнтэй шийдэл болох нь туршилтаар батлагдсан юм. Улаанбаатар хотын дулааны сүлжээнд нийт 510 км шугам хоолой байдаг ба үүний 64% нь 50 гаруй жилийн настай байна. Ялангуяа ил шугам хоолойн дулаан алдагдал их байдаг тул сайн чанарын бүтээгдэхүүнээр дулаалснаар их хэмжээний дулааны зардлыг хэмнэх боломж бүрдэх юм.

Нягт: 60кг/м3-110 кг/м3
Зузаан: 50-100мм
Урт: 1000мм
Диаметр: 300-2000мм

Хэрэглээ:

- Цилиндр шугам хоолойн дулаалга, дулаан тусгаарлагч



*Зураг 11 Термобазальт бүтээгдэхүүн*




*Зураг 12 Шугам хоолойн дулаалгын туршилт*

Үнэт цаас гаргагч нь 2015 онд Улаанбаатар хотын Энхтайвны гүүрний зүүн талд 700-н шугам дээр 100м шугам хоолойн дулаалгыг Москва хотын шугам хоолойг дулаалсан ОХУ-ын СТУ компанитай хамтран хийж амжилттай туршилт явуулсан байна. Үүний үр дүнд ил шугам хоолойн гадаргуу дээрх дулааны алдагдал 50%-с дээш байсныг 0% хүртэл бууруулах боломжтойг харуулжээ.

## Бүтээгдэхүүн 4 – Шүршдэг базальтвүүл

Үнэт цаас гаргагч нь 2016 онд бас нэгэн шинэ бүтээгдэхүүн болох шүршдэг базальт технологийг Япон улсын дэвшилтэт технологи ашиглан нэвтрүүлсэн бөгөөд анхныхаа хэрэглэгчид нийлүүлээд байна. Барилгын тааз, булан тохой зэрэг энгийн хавтангаар дулаалахад бэрхшээлтэй талбайг шүршдэг базальт технологийн дагуу базальт хөвөнг цавуутай хольж дулаалах талбай цацаж

тогтоосноор ажлыг хөнгөвчлөөд зогсохгүй олон хүн хүч шаардахгүй, түргэн хийж гүйцэтгэх боломжтой зэрэг давуу талуудтай.

Загвар: G-1500
Шүрших машины хэмжээ: 1150*600*1150мм
Загвар: VFD-M
Шүрших машины хэмжээ: 1550*850*950мм

Хэрэглээ:

- Модон барилга, орон сууцны барилга, зочид буудал, бүх төрлийн цэнгэлдэх хүрээлэн, спорт зал, төмөр замын буудал, кино театр, музей, үзэсгэлэнгийн төв, их дэлгүүр, үйлдвэр, нисэх онгоцны буудлын барилгууд гэх мэт том байгууламжид дулааны болон дуу чимээ, галаас хамгаалах тусгаарлагч.



*Зураг 13 Шүршдэг базальтвүүл*

Энэхүү бүтээгдэхүүнээ 2016 оны 9 сард барилга угсралтын шатандаа явж буй Зайсан Hill Complex-ийн тааз болон дотор заалны хананд дулаан тусгаарлах, дуу чимээ тусгаарлах зорилгоор шүршдэг базальтийг амжилттай нэвтрүүлсэн байна.

## Бүтээгдэхүүн худалдан авалтын санхүүгийн боломж

2017 онд ХААН Банкны зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах иргэдийн эко хэрэглээг дэмжих зорилгоор олгогдох Ногоон зээлийг нэвтрүүлсэн. Уг зээл нь ХААН Банктай хамтран ажиллах гэрээтэй бэлтгэн нийлүүлэгчээс бүтээгдэхүүн, үйлчилгээг авах хүсэлтэй иргэдэд олгогдох бөгөөд Монгол базальт ХК-ны бүтээгдэхүүн уг жагсаалтад багтаж буй юм. Хэрэглэгчид сайн чанарын дулаалгын материалыг хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээр худалдан авах нөхцөл бүрдсэн нь Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүний эрэлтэд эерэгээр нөлөөлөх боломжийг бий болгож байна.

Ногоон зээл нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

| Зээлийн дээд хэмжээ | Зээлийн хугацаа | Хүүгийн хүү /жил/ | Урьдчилгаа төлбөр |
|---|---|---|---|
| 15 сая хүртэл төгрөг | 12 хүртэл сар | 17.40% | Барааны үнийн дүн 3 сая хүртэл төгрөг бол 0%,<br>3 сая төгрөгөөс дээш бол барааны үнийн дүнгийн 10% |
| | 13-24 сар | 18.00% | |
| | 25-36 сар | 18.60% | |
| | 37-48 сар | 19.20% | |

*Хүснэгт 27 Ногоон зээлийн нөхцөл*

СЗХ
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

## Томоохон хэрэглэгчид

Гэгээнтэн Цогцолбор,
Жигүүр Гранд



Бэст Вэстэрн Примиер Инн, Туушин



Шангри Ла,
MCS



Улаанбаатар Их Дэлгүүр



Гранд Плаза



Зайсан Виллаж
Жигүүр Гранд



Regency Residence Mongolian
Properties



Романа Ресиденс
Жигүүр Гранд



Апартмент Х
Хурд Групп




Цонжин Болдог



Ханбумбат, Оюу Толгой



Өргөө Кино театр




*Зураг 14 Томоохон хэрэглэгчид*

Бумбат Алтай
2087103
ПЮН0220
BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ
БАЗАЛЬТ
ХК
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР
ДУГААРЫН ТУСГААРЛАГЧ

## Бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч Л.Ариунболд нь 2007 онд өөрийн үйлдвэрийг байгуулахдаа бусад улсын туршлагыг судалсны үндсэн дээр өөрсдийн загвараар байгуулсан бөгөөд чулуун хөвөн үйлдвэрлэх технологийн "ноу-хау"-гаараа оюуны өмчийн патент авсан байна. Мөн Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Basaltwool бүтээгдэхүүний гэрчилгээтэйгээр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. *Rockwool барааны тэмдгийн гэрчилгээ, ашигтай загварын гэрчилгээ, базальт чулуун мяндсаар арматур үйлдвэрлэх арга ашигтай загварын гэрчилгээ, Basaltwool тэмдэгний олон улсын нэршлийн гэрчилгээний хуулбарыг Хавсралт 6-11-с харна уу.*

Базальт чулуун хөвөн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх түүхий эд нь базальт чулуу, шохойн чулуу, цавуу, кокс, эрчим хүч гаргах зориулалтаар ашиглах байгалийн хий зэргээс бүрдэнэ. Компани нь Төв аймгийн Баяндэлгэр сумын Ногоон уул хэмээх газарт өөрийн 100% эзэмшлийн 2043 он хүртэл ашиглалтын лицензтэй, 32.4 га талбай бүхий ордноос үйлдвэрийнхээ түүхий эдийг нийлүүлдэг. Энэ нь Улаанбаатар хотод хамгийн ойр байрлах базальт чулуулгийн орд бөгөөд компанийн хувьд түүхий эдээ өөрөө бүрэн удирдах, бэлтгэн нийлүүлэгчдээс хараат байдлыг эрс бууруулах маш том давуу талыг олгодог.

### Чулуун хөвөнгийн үйлдвэрийн схем зураг




*Зураг 15 Үйлдвэрийн схем*

### Чулуун хөвөнгийн үйлдвэрлэлийн процесс

Уурхайгаас олборлон базальт хайргыг үйлдвэрт хүргүүлж 80-180 мм хэмжээтэй болгож буталсны дараа зууханд туузан шугамаар /конвейер/ хийж, цахилгаан цэнэгийн тусламжтайгаар базальтыг 2,000 цельсийн градус хүртэлх хэмд хайлуулна. Дараа нь хайлшийг төвөөс зугтах элдүүрүүдэд хийж, 5 мкм зузаантай болтол нь элдэнэ. Үүний дараа утаа сорогчоор туузан дамжуулагчаар мяндсан утас тунгаах камер луу хүргэнэ. Уг камерт тунгаах үйл явцаас гадна мяндсан утсыг холбогч эдээр /АВАЛОН/ боловсруулах ажиллагаа явагдана.

Камер дахь аэродинамикийн горим өргөн, нягтшрал, зузаанаараа тэгш хэвсэнцэр гаргаж авах боломж олгоно. Дараа нь уг бэлдэц дулаан боловсруулалт ба хөргөж шахах камеруудыг дамжих ба бэлэн болсон хавтан уртааш ба хөндлөн зүсэлт рүү орно. Үүний дараа хавтангуудыг боогноруулж хураан, бэлэн бүтээгдэхүүний агуулахад шилжүүлнэ. Агуулахад тэдгээрийг савлан хэрэглэгчдэд хүргэдэг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**Базальт орд олборлолт**

Түүхий эдийг трехобазальтын ордоос олборлож үйлдвэрт хүргүүлнэ





**Түүхий эдийн бэлтгэл**

Түүхий эдийг 80-180 мм-ийн хэмжээтэй бэлтгэх ба тус бүрд нь хадгалах савуудад байршуулсан байна





**Чулууг хайлуулах**

Базальт чулуу, шохойн чулуу,зэргийг найрлагын дагуу зууханд хийж 1,500-1,600 градуст хайлуулна





**Шингэн чулууг хөвөн болгох**

Хайлсан чулууг хурдтай эргэлдэж буй бул дээр унагаснаар цацарч, улмаар хөвөн хэлбэрт шилжинэ. Үүнтэй хамт цавууг цацаж өгснөөр хөвөн нь наалдамхай болно

**Хөвөнг биежүүлэх, нэг урт биет болгож холбох**

**Хөвөнг шарж хавтан болгох**

**Хавтанг зүсэх**

**Хавтанг савлах**







**Хөвөнг биежүүлэх, нэг урт биет болгож холбох**

**Хөвөнг шарж, термобазальт шугамд оруулна**

**Хавтанг цилиндр хэлбэрт оруулна**

**Савлах**








**Хөвөнг биежүүлэх**

**Хөвөнг гидропоник хөрс болгон ашиглана**



**Биежүүлсэн хөвөнг цавуутай хольж шүрших машинд оруулна**

**Дулаалах гадаргууд шүршиж наалдуулна**



**Хөвөнг биежүүлэх**

**Хөвөнг нунтаг болгох**

**Нунтаг хөвөнг холимог материалын түүхий эд болгож экспортод гаргана**









*Зураг 16 Үйлдвэрлэлийн процесс*

2087103
ПЮН02
BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

**Чулуун хөвөнгийн үйлдвэр, суурилсан тоног төхөөрөмж**



*Зураг 17 Одоогийн үйлдвэрийн барилга*



*Зураг 18 Одоогийн үйлдвэрийн тоног төхөөрөмж*

## Чулуун хөвөн бүтээгдэхүүний шинж чанар

Эрдэст чулуун дулаалгын материалыг 1937 оноос эхлэн Дани улсад үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд өдгөө хөгжсөн орнуудын дулаалгын материалын нэн тэргүүний сонголт болжээ. Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй базальт чулуун хөвөн материал нь барилгын ханыг нимгэрүүлэх, жинг хөнгөрүүлэх, тоосгон ханатай харьцуулахад 16-21.4 дахин, керамзит бетоноос 8.5-11.4 дахин бага дулаан дамжуулдаг, эрчим хүчний хэмнэлттэй, харьцангуй хямд өртөгтэй, дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн Basaltwool дулаан тусгаарлах материал болно. Бүхий л шинж чанараараа бусад дулаан тусгаарлах материалуудаас давуу байдаг учир олон улсад өргөнөөр ашиглагддаг.

Эрдэст чулуун хөвөнгийн давуу тал, шинж чанар:

- **Галд шатдаггүй**

Эрдэст чулуун хөвөнг базальт чулуу буюу галт уулын магмын халуун хайлмагийн царцдасаас тогтсон чулууг хайлуулах замаар үйлдвэрлэдэг учир -180°C - +1,100°C температурт тэсвэртэй, шатдаггүй (барилгын гал түймрийн хамгийн өндөр температур 960°C). Энэ чанараараа хүний амь, эд хөрөнгийг галын аюулаас хамгаалдаг.

- **Сайн дулаан тусгаарлагч**

Дулаан дамжуулах коэффициент $\lambda$ = 0.038 Вт/мК буюу дулаан тусгаарлах чадвар нь шилэн хөвөн, хөөсөнцөр зэрэг бусад төрлийн дулаалгын материалтай ижил төвшинд байдаг.

- **Дуу чимээ тусгаарлалт сайн**

Эрдэст чулуун хөвөнгийн мяндаслаг, хөвөнлөг чанар нь дуу чимээ тусгаарлах чадварыг нь эрс нэмэгдүүлж байдаг. Хамгийн сайн чанарын дуу тусгаарлагч юм. Нягтаас хамаарч дотор хана хооронд болон гадны дуу чимээнээс 45 ДБ-аас дээш тусгаарлах ба энэ нь жирийн ярианы дуу чимээтэй тэнцүү. Өөрөөр хэлбэл хажуу өрөөний энгийн дуу чимээ, хүний яриаг бүрэн тусгаарлах болно.

- **Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй**

Зүсэж хэрэглэхэд тоос, тоосонцор үүсдэггүй ба энэ нь хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөөгүй. Бүтээгдэхүүний орцын 95 хувь нь байгалийн эрдэс чулуу байдаг нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх үндсэн шалтгаан болдог. Мөн барилга галд өртсөн тохиолдолд шатахгүйгээс гадна хорт хий ялгаруулдаггүй нь байгаль болоод хүний амь насанд ээлтэй.

- **Удаан эдэлгээтэй**

Эрдэст чулуун хөвөн нь 50-с дээш жил нэг хэвээ хадгалах чадвартай бөгөөд энэ нь ямар ч барилгын бүтэн амьдралын турш дулаан, дуу чимээ, ус чийг тусгаарлах шинж чанараа алдалгүй барина гэсэн үг. Мөн цэвэр байгалийн эрдэс чулуун бүтээгдэхүүн нь химийн урвалд ордоггүй. Үүгээрээ чулуун хөвөн нь бусад бүх төрлийн дулаалгын материалаас хамгийн удаан эдэлгээтэй материал болдог.

- **Ус чийг нэвтрүүлдэггүй**

Эрдэст чулуун хөвөнг маш нарийн ширхэгтэй чулуун утсаар хийдэг учир ус уусгадаггүй. Иймээс физик шинж чанар нь ус чийг нэвтрүүлдэггүй, ус асгарахад гадаргуугийн дагуу урсдаг. Мөн усны уурын тархалтыг тэсвэрлэх коэффициент $\mu$ = 1 буюу агаарынхтай тэнцүү. Иймээс барилгын материалд ашиглахад хөгц ургахгүй байх сайн талтай.

- **Уян хатан**

Дифермацид ордоггүй учир ямар ч гадаргууд байрлуулсан эргээд тэлж хавтан хоорондох зай маш бага болдог ба үүний хэрээр дулаан тусгаарлалт нэмэгддэг. Ингэснээр ямар ч хэлбэртэй гадаргууг дулаалж болохоос гадна дулаалгын материал хоорондын зай, завсар багассанаар заадас хоорондын зайгаар дулаан алдах нь эрс багасдаг.

- **Зүсэж хэрэглэх боломжтой**

Эрдэст чулуун хөвөн нь зүсэж хэрэглэх боломжтой ба зүсэх үед тоос, тоосонцор, хог хаягдал үүсдэггүй.

- **Эдийн засгийн хэмнэлттэй**

Базальт хөвөнгийн мяндаслаг шинж чанар нь дулаан тусгаарлалт сайн байх үндсэн шалтгаан болдог. Иймээс хэрэглэгчийн эрчим хүчинд зарцуулах зардлыг эрс бууруулна. Энэ чанараараа хүйтэн ба халууны улиралд барилга доторх орчныг тав, тухтай, тохилог байлгаж чаддаг.

▪ **Байгальд ээлтэй эко**

Дэлхийн хэмжээнд нийт эрчим хүчний 30-40 хувийг барилга байгууламж халаахад зарцуулдаг аж. Жишээ нь, Европт нийт эрчим хүчний 40 хувийг, ОХУ-д 45 хувийг, Хятадад 28 хувийг барилга байгууламжаа халаахад зарцуулдаг. Иймээс барилга байгууламжуудын дулаалгыг чанартай сайн бүтээгдэхүүнээр хийснээр дулаан алдалт багасаж, тэр хэрээр эрчим хүчний хэрэглээ буурах ба агаарт цацагдах нүүрсхүчлийн хий багасах юм.

*Эх сурвалж: Rockwool.com, Rockwool.mn*

## Базальт чулуун материалын хэрэглээ ба ирээдүй

Базальт чулуу нь дэлхий дээр маш өргөн тархсан байгалийн чулуу бөгөөд уг гарал нь галт уулын дотроос дэлбэрэлтийнх нь үед газрын хөрсөн дээр гарч хөрсөн лава юм. Базальт нь маш бат бөх чанартай бөгөөд эртний Ромд хотын замын хучилтыг хийж байсан нь өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн байдаг билээ.



*Зураг 20 Байгалийн базальт чулуу*



*Зураг 19 Базальт чулуун зам*

**Базальт хөвөн:**

Базальт чулуугаар хийсэн бүтээгдэхүүн нь эрүүл мэндэд гаж нөлөөгүй, галд тэсвэртэй, дулаан тусгаарлах чадвар сайн, дуу тусгаарлалт өндөр, шатсан тохиолдолд хорт утаа ялгаруулдаггүй зэрэг чанаруудаараа зөвхөн дулаалгын материалд ашиглагдаад зогсохгүй өөр маш олон төрлийн бүтээгдэхүүн болон хөгжиж байна. Үүнд:

- Үйлдвэрийн барилгын гал тусгаарлагч
- Дуурийн театр, томоохон үзвэр үйлчилгээний газруудад дуу тусгаарлагч
- Метроны зогсоол, газар доогуурх хонгилд гал болон дуу тусгаарлагч
- Усан онгоц, тээврийн механизмд гал тусгаарлагч
- Орон сууц болон худалдаа үйлчилгээний барилга зэрэгт үл шатдаг чанар, дуу тусгаарлах чадвар, чичиргээ даах чадвар зэргийг нь ашиглан түлхүү хэрэглэдэг.




*Зураг 21 Базальт чулуун хөвөнгийн хэрэглээ*

**Базальт чулуун хөвөн үйлдвэрлэгч гадаадын компаниуд**

Базальт чулуун дулаалгын бүтээгдэхүүн нь 100 гаруй жилийн түүхтэй бөгөөд анх Европт улмаар Хойд Америк, Азийн орнуудад өргөнөөр ашиглагдсаар иржээ. Дэлхийн хэмжээнд уг бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон хэрэглээний өсөлтөөрөө Ази Номхон далайн бүс нутаг тэргүүлж байна. Тус бүс нутгийн эдийн засгийн томоохон тоглогчид болох БНХАУ, ОХУ, Энэтхэг зэрэг томоохон гүрнүүд дэд бүтэц, худалдаа үйлчилгээний салбарт маш их хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд уг салбарт баригдаж буй барилга, байгууламжид их хэмжээний дулаалгын чулуун хөвөн материал хэрэглэгдэж байна. Чулуун хөвөн дулаалгын зах зээлийн гол тоглогчид нь:

- Saint-Gobain (France), Францийн барилгын материалын томоохон үйлдвэрлэгч нарын нэг тус компани нь барилгын дулаалга, эрүүл мэндийн салбарт ашиглагддаг тоног төхөөрөмж, тээврийн аюулгүй байдал зэргийг хөгжүүлэх зорилгоор маш олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компани юм. Барилгын дулаалгын салбарт чулуун хөвөн бүтээгдэхүүн, эрүүл мэнд болон тээврийн салбартаа базальт чулуунаас гаргаж авсан экологид хор нөлөөгүй, химийн урвалд ордоггүй давуу шинж чанартай базальт утсыг ашигладаг байна. [1]
- Rockwool International (Denmark), Дани Улсын галд тэсвэртэй дулаалгын материал үйлдвэрлэгч уг групп компани нь чулуун хөвөн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч бөгөөд нийт 37 оронд 10,600 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг. Уг компани ОХУ-д нийт 4-н салбартай бөгөөд ихэнх байршил нь баруун Европтой ойролцоо байна. Мөн БНХАУ-д 1 салбартай ба нутгийн өмнөд хэсэгт байрладаг. Rockwool International компанийн гол бүтээгдэхүүнүүд нь чулуун хөвөн хананы дулаалга, дуу намсгагч хана, барилгын гадна фасад зэрэг барилгын салбарын чухал бүтээгдэхүүнүүдийг чулуун хөвөнгөөс гарган авч ашиглаж байна.[2]
- Knauf Insulation (Netherlands), дулаалгын материал үйлдвэрлэг уг компани нь Английн хамгийн шилдэг дулаалгын материал үйлдвэрлэгч компани бөгөөд Европын 35 оронд өөрийн салбарыг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Чулуун хөвөн материалаар барилгын хана, шал, тааз, дотно болон гадна дулаалга зэрэгт ашиглаж байгаа бөгөөд базальт чулуун бүтээгдэхүүний шинэ төрөл болох шүршдэг базальтыг мөн өргөнөөр ашиглан томоохон байгууламжуудын хавтангаар дулаалах боломжгүй хэсэгт ашиглаж байна.[3]
- Мөн Kamenny Vek (Dubna, Russia), Technobasalt (Kyiv, Ukraine), Hengdian Group Shanghai Russia & Gold Basalt Fibre Co. (Shanghai, China), and OJSC Research Institute Glassplastics and Fiber (Bucha, Ukraine), Guardian Fiberglass, Inc. (U.S.), Rock Wool Manufacturing Co. (U.S.), Thermafiber, Inc. (U.S.), USG Interiors, Inc. (U.S.) зэрэг компаниуд олон улсад чулуун хөвөн бүтээгдэхүүн нийлүүлж байна.[4]

Мөн сүүлийн жилүүдэд базальт чулуун хөвөн үйлдвэрлэгч компаниудын хоорондох нэгдэл, худалдан авалт нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь базальт чулууун хөвөнг ашигласан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаагийн илрэл юм. Жишээлбэл 2017 оны 10 сард АНУ-ын барилгын дулаалгын материал, шилэн хөвөн үйлдвэрлэгч Owens Corning компани Финландын чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэгч Paroc Group компанийг 900 сая еврогийн үнэлгээтэйгээр худалдан авсан байна[5]. Paroc Group нь Финландад төвтэй Европийн томоохон галд тэсвэртэй чулуун хөвөн дулаалга материал үйлдвэрлэгч бөгөөд дэлхийн 5 улсад 7 үйлдвэртэй, Финланд, Латви, Польш, ОХУ, Швед зэрэг 13 улсад 1,800 ажилчидтай үйл ажиллагаа явуулж дэлхийн 40 улсад бүтээгдэхүүнээ гаргаж байна. Paroc нь 2018 онд 500 сая ам.долларын борлуулалт хийж 50 сая орчим ам.долларын ашигтай ажиллана гэж Owens Corning үзэж байна. Owens Corning компани нь Нью Иоркийн хөрөнгийн биржид бүртгэлтэй (NYSE: OC) Fortune 500 компанийн нэг бөгөөд 6.4 тэрбум ам.долларын борлуулалттай дэлхийн томоохон шилэн хөвөн үйлдвэрлэгч юм. Paroc Group-ийг худалдан авснаараа Owens Corning

[1] https://www.saint-gobain.com/en
[2] http://www.rockwool.com/
[3] http://www.knaufinsulation.com/en/building-solutions
[4] http://www.marketsandmarkets.com/PressReleases/mineral-wool.asp
[5] http://www.paroc.com/about-paroc/news-and-media/news-archive/2017/owens-corning-to-acquire-paroc-group

СЗХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр
BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

компани нь чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэх хүчин чадалтай болж зах зээлээ тэлэх боломжтой болж байгаа юм.

**Базальт хөвөн хөрс**

Базальт чулуугаар хийсэн хөвөнг барилгын салбараас гадна “Гидропоник” газар тариаланд өргөнөөр хэрэглэдэг. Гидропоник нь ургамлыг, ус болон эрдэс бодисын нэгдлийг ашиглан хөрсгүйгээр ургуулдаг арга юм. Эрдэст чулуун хөвөнг хөрс болгон хэрэглэснээр, байгалийн эрдэс бодисыг натурал аргаар ургамалд хүргэж чаддаг бөгөөд ургацын хурдыг нэмэгдүүлдэг.



*Зураг 22 Гидропоник хөрс*

Эрдэст чулуун хөвөнгийн өөрийн шинж чанар нь дотроо мяндсархаг бүтэцтэй бөгөөд хүчил төрөгчийг хамгийн сайн ханган түгээгч ба базальт чулууны эрдэслэг шинж чанар нь нэмэлт тэжээл болдог бөгөөд бусад химийн элементүүдтэй урвалд ордоггүй тул бусад хөрс орлуулагчдыг бодвол эрүүл ахуйн шаардлагыг онцгой хангаж чаддагаараа давуу талтай юм. Бүх төрлийн эрдэст хөвөнг хөрс болгон ашигладаггүй бөгөөд зөвхөн “High-Grade” эрдэст чулуун хөвөн хэрэглэхийг олон улсын эрүүл мэндийн байгууллагаас зөвлөн зааж өгсөн байна. “High-Grade” эрдэст чулуун хөвөн найрлагадаа зөвхөн Базальт чулуу, Шохойн чулуу, Коксыг гол түүхий эд болгон ашигладаг. BASALTWOOL® брэндийн эрдэст чулуун хөвөнгийн хувьд энэхүү шаардлагыг бүрэн хангадаг бөгөөд “Гидропоник” тариаланд хэрэглэхэд тохиромжтой гэж үздэг. Үнэт цаас гаргагч нь өөрийн бүтээгдэхүүнээрээ компанийн байрандаа “Гидропоник” аргаар тасалгааны төрөл бүрийн ургамал тарьж туршилт хийсэн бөгөөд туршилт амжилттай хэрэгжсэн нь тус компанийн Базальт чулуун хөвөнг энэ зорилгоор ашиглах боломжтойг нотолсон байна.



*Зураг 23 Гидропоник тариалан*

**Базальт мяндсан утас**

Базальт чулууг өндөр температурт тодорхой технологийн дагуу хайлуулснаар базальт мяндсан утсыг гарган авдаг бөгөөд уг утасны физик шинж чанар нь И-шил болон карбон утастай тун төстэй байдаг. Базальт мяндсан утас нь дулааны тэсвэртэй, механикийн даацтай, экологид ээлтэй болон химийн тэсвэртэй байдлаараа маш өвөрмөц бөгөөд энэ нь уг бүтээгдэхүүнийг олон төрлийн холимог материалд ашиглах боломжийг бүрдүүлдэг.



*Зураг 24 Базальт утас*



*Зураг 25 Базальт утас*

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд базальт чулуунаас гарган авсан мяндсан утсыг нано-технологиор боловсруулан олон төрлийн холимог бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Базальт агуулсан химийн нэгдлүүд нь бат бэх, дулаанд тэсвэртэй, эдэлгээ сайн, хатуулаг чанартай базальт мяндас болдог, мөн хямд өртгөөр үйлдвэрлэгдэх боломжтой тул цаашид уламжлалт ган, болд, зарим төрлийн хатууруулсан хуванцар, шилэн мяндсан арматур, ган арматур, полипромпилен, полиэтилен, полиэстер, арамид болон карбон нүүрстөрөгчийн мяндсан бүтээгдэхүүнүүдийг орлохуйц өрсөлдөх чадвартай чухал бүтээгдэхүүн юм.





*Зураг 28 Базальт утсан арматур*

Базальт мяндсан утсаар (basalt fiber) хийсэн материал нь карбон нүүрстөрөгчийн мяндсан утас (carbon fiber) болон шилэн мяндас (fiberglass) материалуудтай адил боловч шилэн мяндастай харьцуулахад физик шинж чанар болон хатуулгаараа давуу, харин карбон нүүрстөрөгчийн мяндсан материалаас хямд үйлдвэрлэх боломжтойгоороо давуу талтай. Базальт мяндсан материал нь гантай харьцуулахад 4 дахин хатуу боловч 3 дахин хөнгөн учир илүү хөнгөн бөгөөд өртөг багатайгаар гантай тэнцэх хатуу материал болгон орлох боломжтой байна. Үүнээс гадна базальт мяндсан материал нь химийн урвалд ордоггүй, физик шинж чанараа маш удаан хугацаанд алддаггүй тул зэврэх гэх мэт химийн болон физикийн доройтолд ордоггүй тул хатуу хучилттай замын эдэлгээг 47%-аас илүү нэмэгдүүлдэг байна. Иймээс хөгжингүй орнуудад дэд бүтцийн шинэчлэлт хийхэд ганг орлох тэргүүний материал гэж үздэг байна.

Базальт мяндсан утсыг ашиглах түгээмэл жишээ:

- Дулаан тусгаарлах бүтээгдэхүүнүүд
- Салхин сэнсний сэнс
- Барилгын бэхэлгээ болон хатуу хучилтат замын арматур
- Өндөр даралттай савалгаа болон хоолой (түлш болон байгалийн хий)
- Спортын тоног хэрэгсэл
- Хуяг, сум нэвтрүүлэхгүй хантааз
- Автомашины сэлбэг, тоормосны диск

| Бусад хатуу материалтай харьцуулалт: | Жин (г/см3) | Механик хүч чадал, хатуу (MPa) | Уян хатан байдал (GPa) | Суналт (%) |
|---|---|---|---|---|
| **Нүүрстөрөгч (Carbon)** | 1.80 | 6,210 | 297 | 2.20 |
| **Базальт мяндас** | **2.65** | **4,800** | **110** | **3.3** |
| **Кевлар мяндас (Kevlar)** | 1.47 | 3,480 | 41.4 | 3.6 |
| **И-шилэн мяндас (E-Glass)** | 2.60 | 3,450 | 76 | 4.76 |
| **Ган (Steel)** | 7.20 | 1,100 | 200 | - |
| **Полипропилен (Polypropylene)** | 0.91 | 650 | 38 | 18 |

*Эх үүсвэр: basaltbar.com*

*Хүснэгт 28 Материалын хатуулагийн харьцуулалт*





*Зураг 29 Базальт мяндас, Нүүрстөрөгч мяндас, Кевлар мяндас*

Иймээс ч сүүлийн жилүүдэд дэлхий даяар базальт мяндсан утсаар хийсэн материалыг суудлын автомашины эд ангийг хийхэд өргөнөөр ашиглаж эхэлж байгаа бөгөөд жишээлбэл Америкийн Larte Design автомашин тоноглолын компани 2015 онд Tesla Model S-ийн шинэ спорт тоноглосон загварыг танилцуулахдаа урд болон хойд гуперийг нь базальт материалаар хийсэн байна. Carbon fiber материалыг тансаг зэрэглэлийн автомашины эд анги хийхэд түгээмлээр ашигладаг боловч Carbon fiber-тай харьцуулахад хямд үнэтэй ч илүү тэсвэрлэг чадвартай Basalt fiber материалыг ашиглаж олны анхаарлыг татжээ. Мөн базальт мяндсан материал нь хөнгөн тул Larte Design-ийн тоноглосон Tesla Model S-ийн жинг 4.8 кг багасгаж чадсан бөгөөд автомашины аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ илүү хөнгөн болгожээ[6].



*Зураг 30 Larte Design-ийн базальт гупертэй Tesla Model S*

**Базальт утас үйлдвэрлэгч компаниуд**

Базальт утсыг АНУ, Канад, Их Британи, ОХУ, Украйн, Дани, Итали, Япон, Бельги, Испани зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй олон оронд үйлдвэрлэн, өдрөөс өдөрт нэмэгдэж буй шинжлэх ухаан, технологийн дэвшилт үйлдвэрлэлд ашиглаж байна. Базальт утас үйлдвэрлэдэг гол компаниудын талаар товч дурдвал[7]:

- Technobasalt (Kyiv, Ukraine) Технобазальт нь базальт утас, базальт утсаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дэлхийн томоохон компаниудын нэг юм. Компанийн давуу чанар нь олон жилийн базальт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өндөр түвшинд бүтээгдсэн чанартай удирдлагын менежментийн системтэй уялдуулсан байдлаар тодорхойлогддог ба бүтээгдэхүүнийг цаг тухай бүрд нь өндөр чанартай нийлүүлдгээрээ онцлогтой компани юм. Компанийн бүх бүтээгдэхүүн нь Технобазальт брэнд нэрийн дор үйлдвэрлэгддэг ба Украйн Улсын чанарын тэмдэгтэйгээр үйлдвэрлэгддэг.
- Hengdian Group Shanghai Russia & Gold Basalt Fibre Co. (Shanghai, China) нь БНХАУ-н Шанхай хотод байрладаг ба базальт утас үйлдвэрлэн маш олон төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс гадна энэ төрлийн бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээний чиглэлд онцгой анхааран ажилладаг компани[8].
- Argosy International Inc (US) компани нь маш олон төрлийн бүтээгдэхүүний түүхий эд буюу материал үйлдвэрлэгч компани бөгөөд үүнд базальт болон базальт утсыг үйлдвэрлэн үйлдвэрлэлд бэлтгэн нийлүүлдэг байна. Компани АНУ, Солонгос, Тайван, Хятад зэрэг орнуудад үйлдвэрүүдээ байршуулж дэлхий нийтэд бүтээгдэхүүнээ түгээж байна.
- Advanced Composite Traders (US) компани дэлхийн томоохон үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүний түүхий эдийг зах зээлийн үнээс хямд нийлүүлдэг компани бөгөөд уг бүтээгдэхүүнд карбон утас, кевлар, базальт утас, шилэн утас зэргийг нийлүүлэн ажилладаг.
- ISOMATEX (Belgium) нь базальт утсан түүхий эдийн механик болон химийн шинж чанарыг сайжруулах тал дээр голлон ажилладаг компани юм. Компани базальт чулуун бүтээгдэхүүний 6 төрлийг Европын олон оронд нийлүүлдэг байна.
- Kamenny Vek (Russia), Базфабер брендийг эзэмшигч уг компани нь өндөр чанартай базальт бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэн, өндөр чанарын механикийн үзүүлэлттэй, өндөр

[6] https://www.larte-design.com/larte-news/tesla-model-s-tuning-kit-unveiled/
[7] http://www.compositesworld.com/
[8] http://www.made-in-china.com/showroom/gbf-tom/companyinfo/Hengdian-Group-Shanghai-Russia-Gold-Basalt-Fiber-Co-Ltd.html

СЗҮ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

температурт тэсвэртэй, химийн урвалд ордоггүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч компани юм.[9]

### 1.1.10 Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага

Үнэт цаас гаргагч нь өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд болон галд тэсвэртэй чулуун хөвөн дулаалгыг хэрэглэгчдэд таниулах зорилгоор хэд хэдэн амины орон сууц болон гэр хороололд оршин суугчдад өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх төслийг хэрэгжүүлээд байна. Үүнээс дурдахад "ГэрӨргөө" (GerHub) ТББ-ийн хэрэгжүүлж буй Монгол гэрийн дулаалгын аргыг шинэчилж, дулааны алдалтыг багасгах, нэмэлт байгууламжаар гэрийн ашигтай талбайг нэмэгдүүлж улмаар гэр хороололд амьдарч буй иргэдэд эдийн засгийн хэмнэлтэй байхаас гадна хотын утааг багасгах зорилготой төсөлд "Basaltwool" чулуун хөвөн дулаалгын материалыг хангаж нийлүүлсэн байна. Үүний үр дүнд уг төслийн анхны туршилтын загвар бэлэн болоод байгаа юм.



*Зураг 32 "Basaltwool" дулаалга суурилуулалт*



*Зураг 31 GerHub-ийн нэмэлт байгууламж*

Мөн Улаанбаатар хотын утааг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулж "Утааны эсрэг ээжүүд" холбоотой хамтран "Дулаалгын аян"-г өрнүүлж байгаа ба уг ажлын хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1-р хороонд оршин суугч Н.Баярхүүгийн амины орон сууцыг "Basaltwool" чулуун хөвөн дулаалгын материалаар бүрэн дулаалж өгсөн байна. Ингэхдээ барилгын ханыг "Basaltwool" чулуун хөвөн хавтангаар, дээврийг шүршдэг "Basaltwool" чулуун хөвөнгөөр дулаалсан ба ингэснээр дулааны алдагдлыг бууруулж дулаалгад зарцуулах эрчим хүчийг хэмнэх боломжтой болсон байна. Энэ мэтчилэн гэр хорооллын айл өрхүүдийн дулааны алдагдлыг багасгаснаар Улаанбаатар хотын утааг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулах юм.



*Зураг 35 Дулаалга хийхээс өмнө*



*Зураг 35 Дулаалсны дараа*



*Зураг 35 Үр дүн*

### 1.1.11 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ

Үнэт цаас гаргагч нь аудитын "Бэст Фортуна Аудит" ХХК-аар сүүлийн 5 жилийн санхүүгийн тайлангуудаа аудитлуулсан ба 2017 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр 23.1 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй, 1.4 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна. Үүнээс 496.5 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын зориулалтаар Капитал банкнаас 2012 онд авсан 5 жилийн зээлийн үлдэгдэл юм. Энэхүү зээлийн барьцаанд компани 1,944 м.кв талбайтай, үйлдвэрлэлийн зориулалттай барилга,

[9] http://www.compositesworld.com/suppliers/kamenny/DIR

2087103 ПЮН023
BASALTWOOL МОНГОЛ БАЗАЛЬТ ХК ДУЛААН ТУСГААРЛАГЧ

тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг барьцаалсан байна. Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар үнэт цаас гаргагч нь хугацаа хэтэрсэн зээлийн түүхгүй, нийт зээлийн төлбөрүүд хэвийн ангилалтай байна.

## Санхүүгийн байдлын тайлан

| (сая төгрөг) | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | **904.4** | **1,075.6** | **1,255.0** | **1,821.0** | **1,915.4** | **867.3** |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 42.6 | 299.4 | 261.1 | 194.6 | 601.3 | 115.3 |
| Дансны авлага | 42.5 | 72.5 | 595.0 | 997.9 | 884.7 | 330.3 |
| Бараа материал | 375.5 | 226.4 | 398.9 | 615.8 | 397.4 | 418.0 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 443.8 | 477.1 | - | 12.6 | 32.0 | 3.7 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **4,315.0** | **4,315.8** | **23,019.5** | **22,920.7** | **23,464.6** | **22,190.5** |
| Үндсэн хөрөнгө | 4,307.2 | 4,307.9 | 20,219.5 | 20,120.7 | 19,755.4 | 19,388.9 |
| Биет бус хөрөнгө | 6.8 | 6.8 | 2,800.0 | 2,800.0 | 2,800.0 | 2,801.5 |
| Хөрөнгө оруулалт | 1.0 | 1.0 | - | - | - | - |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - | - | - | 909.3 | - |
| **Нийт хөрөнгө** | **5,219.4** | **5,391.3** | **24,274.5** | **24,741.7** | **25,380.0** | **23,057.8** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **904.6** | **1,282.7** | **850.5** | **1,112.7** | **1,746.1** | **894.6** |
| Дансны өглөг | 14.4 | 0.6 | - | 25.4 | 301.6 | 420.0 |
| Татварын өр | 48.7 | 39.3 | 28.1 | 116.9 | 200.8 | 271.2 |
| Богино хугацаат зээл | 92.3 | 199.5 | 26.5 | - | 795.9 | - |
| Урьдчилж орсон орлого | - | 329.2 | - | 174.4 | 174.4 | - |
| Бусад өр төлбөр | 749.3 | 713.2 | 795.9 | 795.9 | 273.4 | 203.4 |
| **Урт хугацаат өр төлбөр** | **500.0** | **500.0** | **496.5** | **496.5** | **496.5** | **496.5** |
| Урт хугацаат зээл | 500.0 | 500.0 | 496.5 | 496.5 | 496.5 | 496.5 |
| **Нийт өр төлбөр** | **1,404.6** | **1,782.7** | **1,347.1** | **1,609.2** | **2,242.7** | **1,391.2** |
| **Эздийн өмч** | **3,814.8** | **3,608.6** | **22,927.4** | **23,132.4** | **23,137.3** | **21,666.6** |
| Хувьцаат капитал | 3,949.2 | 3,949.2 | 3,949.2 | 3,949.2 | 3,949.2 | 3,949.2 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | - | 18,630.2 | 18,630.2 | 18,630.2 | 17,103.8 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (134.4) | (340.6) | 348.0 | 553.0 | 558.0 | 613.6 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **5,219.4** | **5,391.3** | **24,274.5** | **24,741.7** | **25,380.0** | **23,057.8** |

*Хүснэгт 29 Санхүүгийн байдлын тайлан*

## Орлогын тайлан

| (сая төгрөг) | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **1,014.8** | **682.9** | **1,062.4** | **1,136.2** | **1,311.8** | **1,835.8** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 405.5 | 400.5 | 166.6 | 460.9 | 1,024.9 | 1,461.3 |
| **Нийт ашиг** | **609.3** | **282.4** | **895.9** | **675.3** | **286.9** | **374.5** |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | 227.9 | - | - | 69.6 | 130.7 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 557.4 | 154.0 | 261.0 | 447.7 | 182.3 | 171.1 |
| Бусад зардал | - | - | 9.0 | 0.2 | 30.0 | 25.8 |
| **Үйл ажиллагааны ашиг** | **51.9** | **(99.5)** | **625.9** | **227.8** | **5.1** | **46.9** |
| Бусад ашиг (алдагдал) | - | (106.7) | - | - | 3.7 | 18.4 |
| **Татварын өмнөх ашиг** | **51.9** | **(206.2)** | **625.9** | **227.8** | **8.8** | **65.3** |
| Татварын зардал | 5.2 | - | 0.4 | 22.8 | 3.9 | 9.7 |
| **Цэвэр ашиг** | **46.8** | **(206.2)** | **625.5** | **205.0** | **4.9** | **55.6** |

*Хүснэгт 30 Орлогын тайлан*

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар компани нь борлуулалтын тогтвортой орлоготой үйл ажиллагаа явуулж байгаа ба эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран ашигтай ажиллаж байна. Сүүлийн таван жилийн борлуулалтын дундаж өсөлт 29.5% бол 2017 онд борлуулалтын орлого өмнөх оноос 39.9% өссөн байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дунджаар нийт борлуулалтын 40 орчим хувь бол харин 2017 онд 79.6% болж өссөн байна. Цэвэр ашгийн хэмжээ 2016 он хүртэл бууралттай байсан бол 2017 онд өмнөх оноос даруй 10 дахин болж өсжээ.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

**Мөнгөн гүйлгээний тайлан**

| (сая төгрөг) | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **1,094.9** | **1,035.5** | **750.7** | **1,019.9** | **1,226.9** | **1,916.0** |
| Үйл ажиллагааны орлого | 1,094.9 | 1,035.5 | 480.4 | 682.1 | 1,226.7 | 1,914.4 |
| Бусад мөнгөн орлого | - | - | 270.2 | 337.8 | 0.2 | 1.6 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **1,347.8** | **781.4** | **604.4** | **1,059.9** | **847.5** | **1,514.6** |
| Ажиллагчдад төлсөн | 50.2 | 46.9 | 44.5 | 59.7 | 95.7 | 129.3 |
| Н.Даатгалын байгууллагад төлсөн | 12.9 | 11.2 | 12.3 | 16.2 | 25.1 | 34.3 |
| Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн | 266.0 | 165.5 | - | 638.5 | 520.2 | 991.0 |
| Түүхийн эд худалдан авахад төлсөн | - | - | 274.5 | 26.4 | - | - |
| Ашиглалтын зардалд төлсөн | 31.1 | 21.1 | 19.8 | 41.1 | 9.2 | 67.3 |
| Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 108.1 | 53.9 | 38.1 | 100.9 | 35.3 | 225.3 |
| Хүүний төлбөрт төлсөн | 104.9 | 35.0 | 41.8 | 4.0 | 6.8 | 1.7 |
| Татварын байгууллагад төлсөн | 55.2 | 5.2 | - | 1.2 | 20.0 | 22.0 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 4.0 | - | - | - | 6.0 | 5.6 |
| Бусад мөнгөн зарлага | 715.3 | 442.8 | 173.4 | 171.9 | 129.3 | 38.0 |
| **Үндсэн ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(253.0)** | **254.0** | **146.2** | **(40.0)** | **379.4** | **401.4** |
| **ХО-ын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | | |
| Мөнгөн орлогын дүн | - | - | - | 0.3 | 0.1 | 51.3 |
| Мөнгөн зарлагын дүн | 210.3 | 0.7 | 2.6 | 0.5 | - | 20.1 |
| **ХО-ын ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(210.3)** | **(0.7)** | **(2.6)** | **(0.2)** | **(250.8)** | **(20.1)** |
| **Санхүүгийн ҮА-ны мөнгөн гүйлгээ** | | | | | | |
| Мөнгөн орлогын дүн | 500.0 | 126.3 | 167.9 | - | 289.5 | 8.5 |
| Мөнгөн зарлагын дүн | 12.7 | 122.7 | 349.9 | 26.5 | 11.4 | 875.8 |
| Валютын ханшийн зөрүү | - | - | 9.0 | - | 2.4 | - |
| **Санхүүгийн ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **487.3** | **3.6** | **(182.0)** | **(26.4)** | **278.1** | **(867.3)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **24.1** | **256.9** | **(38.3)** | **(66.5)** | **406.7** | **(486.0)** |
| **Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл** | **0.0** | **42.6** | **299.4** | **261.1** | **194.6** | **601.3** |
| **Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл** | **42.6** | **299.4** | **261.1** | **194.6** | **601.3** | **115.3** |

*Хүснэгт 31 Мөнгөн гүйлгээний тайлан*

Үнэт цаас гаргагч нь 2015 оны 08 сарын 07-нд батлагдсан "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулийн хүрээнд 2014 оны санхүүгийн тайланд биет болон биет бус хөрөнгөө дахин үнэлж тусгахдаа гарсан хөрөнгийн үнэлгээний зөрүү 18,630,191.4 мянган төгрөгийг "Нэмж төлөгдсөн капитал" дансанд тусгаж санхүүгийн тайлангаа эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна. 2017 оны санхүүгийн тайлангаар 1,526,387.4 мянган төгрөгийн хөрөнгийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 70 дугаар тогтоолоор хасаж бууруулсан бөгөөд ингэснээр "Нэмж төлөгдсөн капитал" 17,103,804.0 мянган төгрөг болж буурсан байна. Дэлгэрэнгүйг энэхүү танилцуулгын Хөрөнгийн үнэлгээний тайлан болон Аудитын байгууллагын дүгнэлт хэсгээс харна уу.

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас олдог мөнгөн урсгал 2017 онд хамгийн өндөр төвшинд буюу 1.9 тэрбум төгрөгт хүрсэн бол мөн онд 875.8 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хийснээр цэвэр мөнгөн гүйлгээ нь -486 сая төгрөг болсон байна. Харин 2017 оны жилийн эцсийн байдлаар компани 115.3 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байв.

**Орлогын тайлангийн бүтцийн шинжилгээ**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал 2012 онд 55% байсан бол 2016, 2017 онуудад 18-21% хүрч буурсан байна. 2016 онд компанийн ашиг барилгын салбарын өсөлтийн удаашралтай

2087103 ПЮН0220
BASALTWOOL МОНГОЛ БАЗАЛЬТ ХК 5112494 7245178 ДУЛААН ТУСГААРЛАГЧ МАТЕРИАЛ ҮЙЛДВЭР

хамааралтайгаар цэвэр ашгийн маржин 0.4% болон буурсан боловч 2017 оны эцсийн байдлаар компанийн нийт ашгийн маржин 20.4% болж тогтворжих хандлагатай бөгөөд цэвэр ашгийн маржин 3.0% болон өссөн байна.

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 40.0% | 58.6% | 15.7% | 40.6% | 78.1% | 79.6% |
| **Нийт ашиг** | **60.0%** | **41.4%** | **84.3%** | **59.4%** | **21.9%** | **20.4%** |
| Борлуулалт, маркетингийн зардал | 0.0% | 33.4% | 0.0% | 0.0% | 5.3% | 7.1% |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 54.9% | 22.6% | 24.6% | 39.4% | 13.9% | 9.3% |
| Бусад зардал | 0.0% | 0.0% | 0.8% | 0.0% | 2.3% | 1.4% |
| **Үйл ажиллагааны ашиг** | **5.1%** | **-14.6%** | **58.9%** | **20.0%** | **0.4%** | **2.6%** |
| Бусад ашиг | 0.0% | -15.6% | 0.0% | 0.0% | 0.3% | 1.0% |
| **Татварын өмнөх ашиг** | **5.1%** | **-30.2%** | **58.9%** | **20.0%** | **0.7%** | **3.6%** |
| Татварын зардал | 0.5% | 0.0% | 0.0% | 2.0% | 0.3% | 0.5% |
| **Цэвэр ашиг** | **4.6%** | **-30.2%** | **58.9%** | **18.0%** | **0.4%** | **3.0%** |

*Хүснэгт 32 Орлогын тайлангийн шинжилгээ*

## Балансын бүтцийн шинжилгээ

2012 оны байдлаар нийт хөрөнгийн 17 хувийг эргэлтийн хөрөнгө, 83 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байсан бол 2017 оны байдлаар эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 3.8% болон буурч, эргэлтийн бус хөрөнгийн дүн 96.2% болон өсжээ. Энэ нь агуулах дахь бараа материал болон урьдчилж төлсөн зардал буурсантай холбоотой байна. Мөн энэ хугацаанд компанийн хөшүүргийн төвшин 27%-иас 6% хүртэл буурч сайжирсан байна.

| | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | **17.3%** | **19.9%** | **5.2%** | **7.4%** | **7.5%** | **3.8%** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 0.8% | 5.6% | 1.1% | 0.8% | 2.4% | 0.5% |
| Дансны авлага | 0.8% | 1.3% | 2.5% | 4.0% | 3.5% | 1.4% |
| Бараа материал | 7.2% | 4.2% | 1.6% | 2.5% | 1.6% | 1.8% |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 8.5% | 8.8% | 0.0% | 0.1% | 0.1% | 0.0% |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **82.7%** | **80.1%** | **94.8%** | **92.6%** | **92.5%** | **96.2%** |
| Үндсэн хөрөнгө | 82.5% | 79.9% | 83.3% | 81.3% | 81.4% | 84.1% |
| Биет бус хөрөнгө | 0.1% | 0.1% | 11.5% | 11.3% | 11.0% | 12.2% |
| **Нийт хөрөнгө** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **17.3%** | **23.8%** | **3.5%** | **4.5%** | **6.9%** | **3.9%** |
| Дансны өглөг | 0.3% | 0.0% | 0.0% | 0.1% | 1.2% | 1.8% |
| Татварын өр | 0.9% | 0.7% | 0.1% | 0.5% | 0.8% | 1.2% |
| Богино хугацаат зээл | 1.8% | 3.7% | 0.1% | 0.0% | 1.1% | 0.0% |
| Урьдчилж орсон орлого | 0.0% | 6.1% | 0.0% | 0.7% | 0.7% | 0.0% |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 14.4% | 13.2% | 3.3% | 3.2% | 3.1% | 0.9% |
| **Урт хугацаат өр төлбөр** | **9.6%** | **9.3%** | **2.0%** | **2.0%** | **2.0%** | **2.2%** |
| Урт хугацаат зээл | 9.6% | 9.3% | 2.0% | 2.0% | 2.0% | 2.2% |
| **Нийт өр төлбөр** | **26.9%** | **33.1%** | **5.5%** | **6.5%** | **8.8%** | **6.0%** |
| **Эздийн өмч** | **73.1%** | **66.9%** | **94.5%** | **93.5%** | **91.2%** | **94.0%** |
| Хувьцаат капитал | 75.7% | 73.3% | 16.3% | 16.0% | 15.6% | 17.1% |
| Нэмж төлөгдсөн капитал | 0.0% | 0.0% | 76.7% | 75.3% | 73.4% | 74.2% |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | -2.6% | -6.3% | 1.4% | 2.2% | 2.2% | 2.7% |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** |

*Хүснэгт 33 Балансын зүйлсийн шинжилгээ*

## Хөрвөх чадварын шинжилгээ

Ажлын цэвэр капитал буюу эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн нь 2012-2013 онд сөрөг үзүүлэлттэй байсан бол уг үзүүлэлт 2014 онд 404 сая, 2015 онд 708 сая төгрөгт хүч

байжээ. Харин 2017 онд -27.3 сая төгрөгт хүрсэн нь богино хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хийгдэхийн зэрэгцээ дансны авлага буурсантай холбоотой байна. Эргэлтийн харьцаа буюу эргэлтийн хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт харьцуулсан харьцаа 2017 онд 0.97 байгаа нь компани эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацааны өр төлбөрөө барагдуулах чадвар бага байгааг харуулж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хассан үзүүлэлтийг богино хугацаат өр төлбөрт харьцуулсан харьцаа) 2017 онд 0.5 байгаа нь компани бараа материалаа борлуулсны үндсэн дээр богино хугацаат өр төлбөрөө барагдуулах боломж бага байгааг харуулж байна. Гэсэн хэдийн ч компанийн нийт өр төлбөрийн хэмжээ багассан байгаа нь сайн үзүүлэлт юм.

| Хөрвөх чадварын үзүүлэлтүүд | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Ажлын цэвэр капитал** | (0.18) | (207.12) | 404.47 | 708.27 | 169.25 | (27.32) |
| **Эргэлтийн харьцаа** | 1.00 | 0.84 | 1.48 | 1.64 | 1.10 | 0.97 |
| **Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар** | 0.58 | 0.66 | 1.01 | 1.08 | 0.87 | 0.50 |

*Хүснэгт 34 Хөрвөх чадварын шинжилгээ*

**Үйл ажиллагааны шинжилгээ**

Үнэт цаас гаргагчийн бараа материалын дундаж наслалт 2017 онд 82 хоног болж буурсан бол бараа материалын эргэлт 4.4 байгаа нь компани агуулахад байгаа бараа бүтээгдэхүүнээ үр дүнтэйгээр ашиглаж байгааг харуулж байна. Харин капиталын эргэлт буюу үндсэн хөрөнгийн эргэлт харьцангуй бага байгаа нь компанийн үйл ажиллагааны чиг, онцлогтой холбоотой юм.

| Үйл ажиллагааны үзүүлэлтүүд | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Бараа материалын эргэлт** | 2.70 | 3.02 | 2.66 | 1.84 | 3.3 | 4.4 |
| **Бараа материалын дундаж наслалт** | 133.21 | 119.36 | 135.17 | 195.13 | 109.06 | 81.97 |
| **Үндсэн хөрөнгийн эргэлт (%)** | 0.27 | 0.19 | 0.05 | 0.05 | 0.06 | 0.08 |
| **Нийт хөрөнгийн эргэлт (%)** | 0.19 | 0.13 | 0.04 | 0.05 | 0.05 | 0.08 |

*Хүснэгт 35 Үйл ажиллагааны шинжилгээ*

**Өрийн шинжилгээ**

2012 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн өрийн харьцаа буюу өр төлбөрийг нийт хөрөнгөнд хуваасан харьцаа нь 27% байсан бол уг харьцаа 2017 онд 6% болж буурсан байна. Өр эздийн өмчийн харьцаа мөн 36.8%-иас 6.4% хүрч багассан байна. Дээрх үзүүлэлтүүд нь компанийн нийт хөрөнгө 2015 онд "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хуулийн" хүрээнд хөрөнгийг дахин үнэлсэнтэй холбоотой ба компанийн хувьд нийт хөрөнгө болон эздийн өмчийн дүн нэмэгдсэн нь өрийн дарамтыг бууруулсан харагдаж байна. Харин 2017 оны эцсийн байдлаар өрийн үзүүлэлтүүд сайжирсан байгаа нь компани өр төлбөрөө төлж барагдуулсантай холбоотой.

| Өрийн үзүүлэлтүүд | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| **Өр/эздийн өмчийн харьцаа** | 36.8% | 49.4% | 5.9% | 7.0% | 9.7% | 6.4% |
| **Өр төлбөр/Нийт актив** | 26.9% | 33.1% | 5.5% | 6.5% | 8.8% | 6.0% |

*Хүснэгт 36 Өрийн шинжилгээ*

### 1.1.12 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт

Үнэт цаас гаргагч нь аудитын "Бэст Фортуна Аудит" ХХК-аар 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайландаа аудитын дүгнэлтийг гаргуулсан байна. Энэхүү аудитын дүгнэлтэд:

"Бидний дүгнэлтээр "Монгол базальт" ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх хавсаргасан санхүүгийн тайлангууд (санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмний өөрчлөлт, мөнгөн гүйлгээ) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар

батлагдсан журам, заавар, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна" гэж дүгнэсэн байна. Аудитын дүгнэлтийг энэхүү Үнэт цаасны танилцуулгын Аудитын байгууллагын дүгнэлт хэсэгт бүрэн эхээр нь хавсаргав.

### 1.1.13 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр "Эм Си Эс Пропертий" ХХК-тай "Чулуун хөвөн дулаалгатай угсармал хавтан дээвэр нийлүүлж, угсрах ажил гүйцэтгэх гэрээ" байгуулсан ба энэхүү гэрээний үнийн дүн нь 666,821,650 төгрөг бөгөөд одоо хэрэгжилтийн шатандаа явж байна. Энэхүү гэрээний дүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.7-д заасан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн таваас дээш хувь байгаа буюу компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 16.88 хувьтай тэнцэж байна. Түүнчлэн 2017 оны 03 дугаар сарын 13-ны өдөр "Эн Си Ди Групп" ХХК-тай Худалдах-Худалдан авах гэрээ хийсэн ба энэхүү гэрээний дүн нь 583,102,302 төгрөг бөгөөд компанийн хуль нийлүүлсэн хөрөнгөний 14.76 хувьтай тэнцэж байгаа бөгөөд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд хийгдэж, хэрэгжилт нь хэвийн явагдаж байна.

Түүнчлэн 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Капитал банкнаас 500,000,000 төгрөгийн зээл авч Зээлийн болон Зээлийн барьцааны гэрээ байгуулсан ба энэхүү гэрээ нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү зээлийн хэмжээ компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн таваас дээш хувь буюу 12.66 хувьтай тэнцэж байгаа ба *(Хавсралт 18- 21. Голомт банк, Хаан банк болон Капитал банкны лавлагаа болон газар эзэмших эрхийн барьцаанд бүртгэлгүй тухай тодорхойлолт)* хэвийн ангилалтай, төлөгдөж байгаа болно. Зээлийн барьцааны гэрээгээр Капитал банканд Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо Үйлдвэрийн баруун бүс /16100/, Үйлдвэрийн тойруу 132 тоот хаягт байрлах 1944 мкв талбайтай, үйлдвэрлэлийн зориулалттай, 153 автомашины гражийн барилга, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг барьцаалсан байна. Зээлийн болон Зээлийн барьцааны гэрээ нь Иргэний хууль, Банкны тухай хууль болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль, тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан компанийн активын 25 хувь буюу түүнээс дээш хэмжээний буюу их хэмжээний хэлцэл хийгээгүй, түүнчлэн Компанийн тухай хуулийн 89.1-д заасан Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

### 1.1.14 Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн 19 хувийг эзэмшдэг П.Сайнбилэг нь "Термобазальт" ХХК-ийн 100 хувийг дангаараа эзэмшдэг, компанийн 51 хувийг эзэмшдэг Л.Ариунболд нь "Юнимат-Эдюкэйшн" ХХК-ийн 50 хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр компаниуд нь Компанийн тухай хуулийн 6.15-д заасны дагуу "Монгол базальт" ХК-ийн зэргэлдээ компаниуд юм.

"Монгол базальт" хаалттай ХК нь хараат болон охин компанигүй бөгөөд хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаагаар компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Л.Ариунболд, түүний гэргий П.Сайнбилэг болон тэдгээрийн охидууд А.Энхгэрэл, А.Энхмаа, А.Энхжин нар болно. Компанийн одоогийн хувь эзэмшигчид нь бүгд нэг гэр бүлийн гишүүд тул холбоотой этгээдүүд компанийн хувьцааны 100 хувийг эзэмшиж байна.

### 1.1.15 Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагчийн 2016 оны 7 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 67 дугаар тогтоолоор компанийн Ногдол ашгийн журмыг баталсан ба уг журамд компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна гэж заасан байна.

Мөн энэхүү ногдол ашгийн дүн нь тухайн жилийн цэвэр ашгийн 20 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан байна.

Компанийн ногдол ашгийн журмын дагуу ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн шийдвэрлэх ба тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулна. Тухайн жил тараасан ногдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлэхийг уг журмаар зохицуулсан.

Мөн компани ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар уг журамд заасан байна.

## Ногдол ашгийн журам

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар "Монгол базальт" ХК-ийн хөрөнгө оруулагчдад ашиг хуваарилах ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**Хоёр. Ногдол ашгийн бодлого**

2.1. Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой төвшинд байлгах зорилготой ажиллана.

2.2. Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.3. Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулна.

2.4. Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас биет эд хөрөнгөөр олгож болно.

**Гурав. Ашгийн хэмжээг тодорхойлох**

3.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.

3.2. Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна. Энэхүү дүн нь компанийн тухай жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй хэмжээтэй байна.

3.3. Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ногдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-өөс тогтооно.

**Дөрөв. Ногдол ашиг хуваарилах**

4.1. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

4.2. Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.

4:3. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусдаг байна.

**Тав. Мэдээлэл хүргэх**

5.1. Тухайн жил тараасан ногдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.

Компанийн засаглалын кодексын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ногдол ашгийн бодлого, дотоод хяналтын журам, мэдээллийн ил тод байдлын журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам зэргийг нэмэлт хувьцааг олон нийтэд санал болгон худалдан борлуулсны дараа хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан, тус хурлаас томилогдсон ТУЗ нь эдгээр журмыг батлана. Журмын төслийг үнэт цаасны танилцуулгын хавсралтад тусгав.

### 1.1.16 Бизнесийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

Компанийн тухай хуулийн 8.1-д заасны дагуу дүрмийн 2.1-д "барилгын материалын үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, төсөл хөтөлбөр, сургалт судалгаа"-ны үйл ажиллагаа эрхлэхээр, Компанийн тухай хуулийн 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.6-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын БМҮ 090/13 тоот "Эрдэс /чулуун/ хөвөнгийн үйлдвэрлэл эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 3 жилийн хугацаатай авсан байна. Компанийн дүрэмд заасан "гадаад дотоод худалдаа, төсөл хөтөлбөр, сургалт судалгаа"-ны үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй ба барилгын материалын үйлдвэрлэлийн зөвшөөрөл авсан нь Компанийн тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцэж байна.

"Монгол базальт" хаалттай ХК нь Барилга хот байгуулалтын яамнаас олгосон БМҮ 118/16 дугаартай Барилгын материал үйлдвэрлэл: Эрдэс /чулуун/ хөвөнгийн үйлдвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг 2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр авсан ба энэхүү тусгай зөвшөөрөл нь 5 жилийн хугацаатай ба 2021 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл хүчинтэй байна. *(Хавсралт 5. Барилга, хот байгуулалтын яамнаас олгосон Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл)*

Компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага Л.Ариунболд нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагын 957445 тоот Basaltwool бүтээгдэхүүний гэрчилгээ, Монгол Улсын хууль зүйн яамны 9872 дугаартай "Rockwool" барааны тэмдгийн гэрчилгээ, базальт чулуун мяндсаар арматур үйлдвэрлэх арга 2132 ашигтай загварын гэрчилгээ, 6783 тоот Basaltwool барааны тэмдгийн гэрчилгээ, 6810 дугаартай "Эрдэс чулуун хөвөн" барааны тэмдгийн гэрчилгээг эзэмшдэг ба эдгээрийн хугацаа дуусаагүй, хүчин төгөлдөр байна. Дээрх барааны тэмдгүүд нь компанийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал Л.Ариунболдын нэр дээр байгаа бөгөөд Патент, барааны тэмдэгтийн эрхийг шилжүүлэн ашиглуулах гэрээг 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж "Монгол базальт" ХК-д хугацаагүйгээр шилжүүлсэн байна. *(Хавсралт 6-11. Барааны тэмдэг, ашигтай загварын гэрчилгээний хуулбар)*

Компанийн тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдгээр аливаа төрлийн үүргийн гүйцэтгэл хангуулах тухай хийсэн хэлцэл байхгүй байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэлийн түүхий эд болох базальт чулууг олборлох зорилгоор авсан Ашигт малтмалын газраас олгосон MV-017426 дугаартай Төв аймгийн Баяндэлгэр сумын Ногоон уул гэдэг газар 32.39 гектар талбайд ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн 9010001085 тоот гэрчилгээтэй бөгөөд гэрчилгээний хугацаа 2043 оны 12 дугаар сарын 02-ыг хүртэл хүчинтэй байна.

### 1.1.17 Татварын орчин

Монгол Улс нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, татварын ачааллыг бууруулах, татварын дөрвөн арвын бодлого хэрэгжүүлдэг улс юм. Татварын бодлого нь эдийн засгийн өсөлт, хүртээмжтэй байдлыг зохицуулах нэг гол бодлогын хүрээнд дотоодын үйлдвэржилт, гадаад худалдааг дэмжих

боломжтой байдаг. 2016 оны Монгол Улсын Засгийн газрын 185-р тогтоолоор "Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-г шинэчлэн тогтоож зарим төрлийн бүтээгдэхүүний гаалийн албан татвар тэр дундаа дулаалгын материалын импортын татварын хувь хэмжээг 5%-аас 15% хүртэл өсгөснөөр компани чулуун хөвөн дулаалгын зах зээл, цаашлаад Монголын дулаалгын зах зээлийн гол тоглогч болох нөхцөл бүрэн бүрдээд байна.

Монгол Улс нь мөн экспортын бүтээгдэхүүнийг дэмжих зорилгоор гадаадад худалдаалсан бүтээгдэхүүнд ямар нэгэн татвар тавьдаггүй. Харин эсрэгээрээ НӨАТ-н буцаан олголтыг олгон дотоодын үйлдвэрлэгч нараа дэмжиж ажилласаар ирсэн.

Эрдэс чулуун хөвөн дулаалгын материал нь 68061010 гэсэн олон улсын гаалийн кодтой ба тухайн төрлийн бүтээгдэхүүнд ногдох экспортлох орнуудын гаалийн болон худалдааны татвар дараах байдалтай байна.

| | Гаалийн татвар | НӨАТ/Худалдааны татвар |
|---|---|---|
| ОХУ | 11.3% | 18% |
| БНХАУ | 10.5% | 17% |
| Япон | 0%, Монгол Улсаас гаалийн татвар байхгүй | 11%[10] |

*Хүснэгт 37 Чулуун хөвөнгийн татвар*

## 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1.2.1 Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны гадаад орчин

#### Монгол Улсын эдийн засгийн байдал, цаашдын чиг хандлага

Монголын эдийн засагт уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, олборлолтын хэмжээ, гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын зах зээлийн идэвхжил зэрэг үндсэн хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлж байдаг. 2010 оноос үүдэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт нь Монгол Улсын түүхэнд байгаагүй өндөр өсөлтийг үзүүлж байсан бол 2013 оноос хойш БНХАУ-н эдийн засгийн өсөлтийн удаашралтай уялдаатайгаар уул уурхайн түүхий эдийн үнэ буурч улмаар Монголын экспортод хүчтэй нөлөөлснөөр эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн. Мөн нөгөө талаар гадаадын шууд хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр буурсан нь эдийн засгийн өсөлтийг удаашрахад нөлөөлсөн байна.



Мөн өнгөрсөн жилүүдэд Монгол Улс гадаадын зах зээл дээр олон улсын бонд гарган арилжаалж уг бондын мөнгийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан дэд бүтэц болон үйлдвэржилтийн төслүүдэд зарцуулсан. Харин бондын эргэн төлөлтийг 2017 оны эхэнд хийх байсан ба уг эргэн төлөлтийг төлөх үед Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан, хөрөнгө оруулагчдийн итгэл суларсан зэрэг нөхцөлүүдээс хамаарч бондын хүү өндөр байсан бөгөөд уг хүүг бууруулах, цаашдаа төсвийн сахилга батыг сайжруулж, урт хугацааны хөгжилд хүрэхийн тулд Монгол Улсын Сангийн яам, Олон Улсын Валютын сангийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийг 2017 оны 5 сард баталсан.

ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" нь 3 жилийн хугацаатай бөгөөд энэ хүрээнд ОУВС-аас 434.3 сая ам.долларын санхүүжилтийг олгох бөгөөд, ОУВС болон олон

[10]ttps://www.dutycalculator.com/hs-code-duty-rate-import-restrictions/680610/rockwool-insulation/6806.10.0090/6806.10.0000/5670/

улсын байгууллагууд болон хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн зориулалтаар авч ашиглана.

| № | Санхүүжүүлэх байгууллага | Дүн | Хугацаа | Хүү |
|---|---|---|---|---|
| 1. | ОУВС | 434.3 сая | 15 | <2% |
| 2. | Азийн Хөгжлийн Банк | 900 сая | тодорхойгүй | тодорхойгүй |
| 3. | Дэлхийн Банк | 600 сая | 15 | 2% |
| 4. | Япон улс | 850 сая | >10 | 1-1.5% |
| 5. | БНСУ | 450 сая | тодорхойгүй | тодорхойгүй |
| 6. | БНХАУ-ын Төв банкны своп хэлцэл | 2.2 тэрбум (15 тэрбум юань) | 3 | - |
| | **Нийт** | **5.5 тэрбум** | | |

*Хүснэгт 38 ОУВС-н Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нөхцөл*

*Эх сурвалж: ОУВС, Сангийн яам*

Төлбөрийн тэнцлийг сайжруулан макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг өөрчлөх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлснээр, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэж 8.1%, инфляцын түвшин 6.1-7.0% болно гэж үзжээ.

Мөн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын төлбөрийн тэнцэл сайжирч, төсвийн нэгдмэл байр суурьтай болж татварын бодлогыг шинэчлэх ба төсвийн зарлагыг үе шаттай бууруулж, Хөгжлийн банкны засаглалыг сайжруулж бие даасан хараат бус байдлыг хангаж, өрийн тогтвортой байдлыг хангаж ажиллана гэж заасан байна.

Улмаар уг хөтөлбөрийг авч хэрэгжүүлснээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дараах байдалтай болно гэж тооцсон байна.

| | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|
| **ДНБ өсөлт** | **-0.1%** | **1.8%** | **8.1%** | **-** |
| Инфляци | 6.1% | 6.1% | 6.9% | - |
| Экспорт | US$4.8 тб. | US$4.9 тб. | US$5.4 тб. | US$5.8 тб. |
| Импорт | US$3.3 тб. | US$3.9 тб. | US$4.7 тб. | US$4.8 тб. |
| Валютын нөөц | US$1.6 тб. | US$2.7 тб. | US$3.5 тб. | US$3.8 тб. |
| ДНБ-д эзлэх өрийн хэмжээ | 86.3% | 88.3% | 85.7% | 83.2% |
| ДНБ-д эзлэх төсвийн алдагдал | 3.4% | 6.4% | 6.0% | |

*Хүснэгт 39 Эдийн засгийн төсөөлөл*

Эх сурвалж: Сангийн яам

Цаашлаад 2018-2020 оны хооронд уул уурхайн бүтээгдэхүүнүүд болох зэс, алт, нүүрсний үнийн түвшинтэй холбоотойгоор эдийн засагт идэвхжил гарах төлөвтэй байна. 2017 он гарсаар уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа чулуун нүүрсний үнэ БНХАУ-н зах зээл дээр тогтвортой байгаа нь Монголын нүүрс экспортлогчдын хувьд сайн мэдээ бөгөөд цаашдаа экспортын хэмжээг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг хангах нэг түлхэц хүч болох юм. Үүнтэй уялдаад уул уурхайн бус салбарын ГШХО нэмэгдэх тохиолдолд эдийн засгийн өсөлт нэмэгдэх боломжтой болох гэсэн судалгааг Дэлхийн банк гаргаад байна.




*Хүснэгт 40 Дэлхийн банкны төсөөлөл*

Мөн Монгол Улсын томоохон төслүүдийн нэг болох Оюу-Толгой төслийн хоёрдох үе шат буюу далд уурхайн бүтээн байгуулалт, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт, "Бөөрөлжүүтийн цахилгаан станц", "Таван Толгойн цахилгаан станц", "Гацууртын алтны уурхай" зэрэг томоохон төслүүдийг дагасан олон төрлийн бизнесүүд орж ирэн эдийн засгийн үйл ажиллагаанд эерэг хувь нэмэр оруулах юм. Оюу-Толгой төсөл нь нийт 4 тэрбум ам.долларыг далд уурхайн бүтээн байгуулалтад зарцуулах төлөвлөгөөтэй байгаа ба үүнээс тодорхой хувь нь дотоодын зах зээлд шингэснээр бизнесийн орчинг сайжруулах боломжтой юм.

Монгол Улс нь үйлдвэржилт, ялангуяа экспортыг дэмжих, импортыг орлох бодлого хэрэгжүүлж байгаа тул импортын бүтээгдэхүүний татварыг өсгөн, экспортыг дэмжсэн санхүүжилт зэргийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан олгож байгаа нь дотоодод нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх таатай орчинг бий болгож байна. Мөн цаашлаад экспортыг дэмжих хүрээнд Япон, ОХУ, БНХАУ зэрэг худалдааны гол түнш улсуудтай экспортын татварыг хөнгөвчлөх хэлцэл яриа зэргийг өрнүүлж буй нь гадаад худалдааг дэмжих сайн бодлого болж байна.

| Эдийн засгийн үзүүлэлтүүд | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг) | 16,668 | 19,174 | 22,227 | 23,150 | 23,936 | 27,167 |
| Бодит ДНБ (тэрбум төгрөг) | 12,853 | 14,351 | 15,482 | 15,851 | 16,048 | 16,874 |
| Бодит ДНБ өсөлт | 12.3% | 11.6% | 7.9% | 2.4% | 1.2% | 5.1% |
| Жилийн инфляци | 14% | 13% | 11% | 2% | 1.1% | 6.4% |

*Хүснэгт 41 Статискийн нэгдсэн мэдээллийн сан*

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг цаашид өсөлттэй гарна гэсэн төсөөллийг бүх байгууллага гаргаад байгаа ба дараах байдалтай харагдаж байна.




*Хүснэгт 42 Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны тайлан*

## Монгол Улсын барилгын салбар

Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн салбар сүүлийн жилүүдэд маш хурдацтайгаар хөгжиж байгаа бөгөөд ялангуяа нийслэл хотын хүн ам жил ирэх тусам нэмэгдэж, хүн амын орлогын төвшин өсөх зэрэг нийгмийн өөрчлөлтүүд нь ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажлыг 2010-2016 оны хооронд 4.6 дахин өсөх, барилгын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг 5 дахин өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.



Ашиглалтад оруулсан барилга угсралт их засварын ажлын хэмжээ 2014-2015 онуудад түүхэн дээд хэмжээнд буюу жилийн 2.9 их наяд төгрөгт хүрч байсан бол 2016 онд уг тоо нь 2.7 болж буурсан нь шинээр ашиглалтад орж буй орон сууцны барилгын бууралттай хамааралтай байна. 2013 онд барилгын салбарт орсон хөрөнгө оруулалт 802 тэрбум төгрөг болсон ба энэ үед 1.2 сая $м^2$ орон сууц шинээр ашиглалтад орж улсын хэмжээнд нийт орон сууцны хэмжээг 11.5 сая $м^2$ болгон өсгөжээ. Энэ нь нийт орон сууцны тоог 18,012-оор буюу 8.4 хувиар нэг жилийн дотор

өсгөсөн үсрэнгүй хөгжил байлаа. Орон сууцны салбарт гарсан энэ үсрэнгүй хөгжлийн хурдац нь 2014-2015 онуудад бага зэрэг саарсан боловч нийт баригдаж буй орон сууцны хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр байна. 2016 оны байдлаар барилга угсралт, их засварын салбарт нийтдээ 2.7 их наяд төгрөг зарцуулсан нь мөн л энэ салбарын хөгжлийг шинэ шатанд хүргэсэн онцлогтой жил болсон юм.

Монгол Улсын эдийн засагт барилгын салбар томоохон хувь нэмэр оруулдаг бөгөөд 2016 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 4 хувийг бүрдүүлж уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын дараагаар орох том салбар болсон байна. Барилгын салбарт 2015 оны байдлаар 5,600 орчим аж ахуйн нэгж, 95.7 мянган хүн хөдөлмөр эрхэлж байна. Монгол Улсын хэмжээнд нийт ажил эрхэлж буй хүн амын 7% нь тус салбарт ажиллаж байгаа бөгөөд барилгын салбар нь хөдөө аж ахуй, худалдаа, боловсролын салбарын дараа орох томоохон ажил олгогч салбар болж байна.

Цаашлаад Монголын барилгын салбар нь хэрэглэгчдийн эрэлтээс шалтгаалан шинэ орон сууц болон оффисын зориулалттай байруудыг ихээр барихаар төлөвлөсөн байгаа нь энэ салбарын хөгжлийг тодорхойлохоор байна. Барилгын салбар нь эдийн засгийн гол салбарын хувьд нийт эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл өндөр, нөгөө талаар эдийн засгийн өсөлтийн үзүүлэлт, хүн амын худалдан авах чадвар, орлогын төвшин зэрэг нь энэ салбарын хөгжлийг тодорхойлдог. Тиймээс барилгын салбарын цаашдын хөгжлийн улс орны нийт эдийн засагтай шууд холбон ойлгож болохоор байна.

2016 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 859.1 мянган өрх байгаа бол нийт өрхийн 25 хувь нь инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог орон сууцанд амьдарч байна. Улаанбаатар хотод нийт өрхийн 43.7% нь төвлөрч байгаа бол үүнээс 218 мянган өрх нь гэр хороололд, 158.4 мянган өрх орон сууцны хороололд амьдарч байна.




*Эх сурвалж: Судалгааны барилга.мн агентлаг*

Монгол улсын хэмжээнд орон сууцны нийлүүлэлтийг дэмжих зорилгоор үе шаттайгаар хөтөлбөрүүдийг зохион байгуулж буй бөгөөд 2003 оноос хойших хөтөлбөрүүдийг харвал:

| Он | Хөтөлбөр |
|---|---|
| 2003 | Азийн Хөгжлийн банкны зээлийн хөтөлбөр |
| 2007 | 40 мянган айлын орон сууц хөтөлбөр |
| 2010 | Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах "4000 орон сууц" |
| 2011 | ОССК-ын 6 хувийн хүүтэй зээл, 100 мянган айлын орон сууц хөтөлбөр |
| 2013 | Ипотекийн 8 хувийн хүүтэй зээл |
| 2014 | ГХДТ, 588 айлын орон сууц ашиглалтад орсон Буянт Ухаа төсөл-1, 1764 айлын төсөл |
| 2015 | ГХДТ, 1656 айлын орон сууц ашиглалтад орсон Буянт Ухаа төсөл-2 3900 айлын орон сууц |

*Хүснэгт 43 Орон сууцны хэрэгжсэн хөтөлбөрүүд*

Барилгын салбарт оруулах хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалттай ойролцоо төвшинд очсон нь Монгол улс шиг уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн орны хувьд онцлог үзүүлэлт юм.

## Дотоодын дулаалгын материалын зах зээл

Монгол базальт ХК-н үйл ажиллагаа явуулдаг дулаалгын материалын зах зээлийн багтаамжийг зөв тодорхойлж цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн цар хүрээг тогтоох нь нэн чухал юм. Харин албан ёсоор зарлагдсан статистик, тоо баримт байдаггүй тул Монгол Улсын дулаалгын материалын зах зээлийн багтаамжийг тодорхойлоход дараах хоёр аргаар тооцоолов. Үүнд:

### I. Дулаалгын материалын үйлдвэрлэл болон импортын аргаар зах зээлийн багтаамжийг тогтоох

Дулаалгын материалыг хэрэглэх нь барилгын дулааны алдагдлыг бууруулах хамгийн шилдэг арга юм. Тиймээс хүн төрөлхтөн маш олон төрлийн дулаалгын материалыг ашиглан амьдарч буй орчныхоо дулааныг тохируулсаар ирсэн. Орчин үед шилэн хөвөн, чулуун хөвөн, хөвөн даавуу, целлойд, вакуумжуулсан давхар шил, EPS цагаан хөөсөнцөр, XPS хөөсөнцөр, полиуритан, вермикулит, перлит, мод ургамлаас гаралтай мяндас (олс, маалинга, хөвөн, үйс гэх мэт), сүрэл, шар шавар, цемент, хонины ноос гэх зэрэг маш олон янзын материал хэрэглэж байна. Эдгээр материал нь дулааны эсэргүүцэл, цацраг туяа, конвекцийн хувьд харилцан адилгүй байдаг. Харин Монгол Улсын дулаалгын материалын зах зээлд хамгийн өргөн ашиглагддаг 3 төрлийн материал нь эрдэс чулуун хөвөн, шилэн хөвөн, хөөсөнцөр байгаа бол нийт дулаалгын зах зээлийн 85-90 хувийг хөөсөнцөр эзэлж байна.

Харин дотооддоо хөөсөнцрийн 40-50 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас шилдэг 10 компани нь нийт суурилагдсан хүчин чадлын 68 хувийг эзэлж байна. Энэ төрлийн үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалт нь эдийн засгийн уналттай үед 40%-50%, хэвийн үед 50%-70%, өсөлттэй үед 70%-80% хувийг ашигладаг гэсэн олон улсын статистик тоонд үндэслэн 2015 оны зах зээлийн боломжит нийлүүлэлтийг тооцвол нийт зах зээлийн хүчин чадал 1 сая орчим метр куб байна. Хүчин чадлын дундаж ашиглалтыг хамгийн бага буюу 40 хувьтай гэж үзвэл нийт үйлдвэрлэл 415 сая $м^3$ болох юм. Нэг метр куб хөөсөнцрийн дундаж үнийг 105 мянган төгрөгөөр тооцоход нийт хөөсөнцөрийн зах зээл ойролцоогоор 43.5 тэрбум төгрөгт хүрч байна. Цаашлаад хөөсөнцрийн зах зээлийн багтаамж нь дотоодын үйлдвэрлэл дээр импортын бүтээгдэхүүнийг нэмснээр нийт дүн нь 44.5 тэрбум төгрөг болж байна.

Дулаалгын материалын зах зээлийн 85-90 хувь нь хөөсөнцөр байдаг гэж тооцвол нийт дулаалгын материалын зах зээлийн багтаамж 49.4-52.0 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Дээрх тоонд үндэслэн тооцвол Монгол базальт ХК нь нийт дулаалгын материалын зах зээлийн 2.4%, чулуун хөвөн дулаалгын материалын зах зээлийн 60%-ийг эзэлж байна.

| Дотоодын хөөсөнцөр хавтан үйлдвэрлэгч TOP 10 компани | | | |
|---|---|---|---|
| Компанийн нэр | Зах зээлд эзлэх хувь | Хүчин чадал м3 | Эзлэх хувь |
| Хөнгөн тавцан | 9.64% | 100,000 | 9.64% |
| Эм Жи Ай Эм | 9.64% | 100,000 | 19.28% |
| Өнгөт төмөр | 9.64% | 100,000 | 28.92% |
| Пирамид Индустри | 8.68% | 90,000 | 37.60% |
| Бау Плюс | 5.79% | 60,000 | 43.39% |
| Хос Хийморь | 5.79% | 60,000 | 49.18% |
| Эсу | 5.01% | 52,000 | 54.19% |
| Вц | 4.82% | 50,000 | 59.01% |
| Монуно | 4.82% | 50,000 | 63.83% |
| Нягт Хөөс | 4.34% | 45,000 | 68.17% |

*Хүснэгт 44 Дотоодын хөөсөнцөр үйлдвэрлэгчид*

*Эх сурвалж: Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоо*

## II. Эдийн засагт эзлэх хувиар тооцох

Үндэсний Статистикийн Хорооноос гаргадаг Дотоодын Нийт Бүтээгдэхүүн болон барилгын салбарт зарцуулагдсан барилга угсралт, их засварын ажлын зардлын тоонд үндэслэн дулаалгын материалын зах зээлийн багтаамжийг тооцож болдог. Орон сууцны зориулалттай барилгын хувьд нийт барилгын өртгийн 3-5%, орон сууцны бус барилгын өртгийн 5-8%-ийг дулаалгын материал эзэлдэг нь Монголын томоохон барилгын компаниудын инженер, санхүүч, гүйцэтгэх захирлуудаас авсан судалгааны үр дүнгээр гарч ирсэн тоо юм. Дээрх судалгаанд үндэслэн тооцоолоход 2016 оны байдлаар нэрлэсэн ДНБ-ний 4.0% нь барилгын салбарт ногдож байгаа ба уг салбарын зардлын 5% нь дулаалгын материалд зарцуулагддаг гэж үзвэл нийт дулаалгын материалын зах зээл 47.4 тэрбум төгрөгт хүрч байна.

Дээрх тооцоогоор Монгол базальт ХК-ны хувьд 2015 оны байдлаар дулаалгын материалын зах зээлийн 2.5%, чулуун хөвөн дулаалгын материалын зах зээлийн 60%-ийг эзэлж байна.

| (сая.төг) | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| ДНБ | 13,173,763 | 16,688,420 | 19,174,243 | 22,227,054 | 23,134,068 | 23,935,853 |
| Барилга | 402,828 | 837,488 | 979,689 | 988,961 | 977,999 | 948,171 |
| Барилга/ДНБ | 3.1% | 5.0% | 5.1% | 4.4% | 4.2% | 4.0% |
| Дулаалгын материалын зах зээл | 20,141 | 41,874 | 48,984 | 49,448 | 48,900 | 47,409 |

*Хүснэгт 45 ДНБ-д Барилгын салбарын эзлэх хувь*

Харин суурилагдсан хүчин чадлаар нь тооцвол Монгол базальт ХК нь нийт дулаалгын материалын зах зээлийн 20-25 хувийг дангаар хангах боломжтой байна.




*Зураг 36 Уул уурхай болон барилгын салбарын хөрөнгө оруулалтын харьцаа*

2010-2013 оны хооронд нийт хөрөнгө оруулалтын 45-62% нь уул уурхайд орж байсан бол 6-13% нь барилгын салбарт орж байсан. Харин 2015-2016 оны хооронд барилгын салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн бөгөөд 2016 онд нийт хөрөнгө оруулалт тэнцсэн байна. Энэ нь барилгын салбарт шаардагдах барилгын материалын хэмжээнд өсөлт үзүүлэх юм.

### Монгол Улсын дулаалгын материалын зах зээлийн төлөв

Монгол Улсын Засгийн газраас хүн амыг орон сууцжуулах "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр", "Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөр, "Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хөтөлбөр" зэрэг олон төсөл хөтөлбөр, болон "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-г хэрэгжүүлж байгаа нь барилгын салбарт шаардагдах дулаалгын материалын эрэлтийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болохоор байна.

"Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд 2017 оны 7 дугаар сарын байдлаар нийт 92.1 мянган иргэн зээлд хамрагдсан ба нийт зээлийн үлдэгдэл 4.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Улмаар Монгол Улсад шинээр орон сууцанд орох залуу гэр бүлийн тоо их, эрэлт өндөр байдаг, хүн амыг орон сууцжуулах шаардлага өндөр байгаа зэрэг нь энэ салбарт цаашид өсөлт гарах боломжтойг харуулж байна. Цаашлаад Монгол Улс нь төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжүүлж байгаа тул хөдөө орон нутагт барилгын салбар цаашдаа улам хөгжиж ард иргэд хямд үнээр байртай болох боломж нээгдэж байна.




*Зураг 37 Нийт ипотекийн зээлийн хэмжээ*

"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-н хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэр дэх барилга, байгууламж, шугам сүлжээнд дулаалга хийх, дулаан алдагдлыг бууруулах "Дулаан техникийн шинэчлэл хөтөлбөр" боловсруулах ажлын хэсэг 2016 оны 11 сарын 7-ны өдөр Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/147-р тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Уг хөтөлбөр нь угсармал орон сууц, олон нийтийн барилга, амины орон сууц, зуслангийн сууц, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулах ба газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийгдсэн барилга байгууламж, шугам сүлжээг дулаан техникийн шинэчлэлийн хэрэгжүүлэх юм.

Угсармал орон сууцны барилгын дахин дулаалгын хөтөлбөр нь УИХ-с баталсан "Эрчим хүчний хэмнэлтийн тухай" хууль, "Ногоон хөгжлийн бодлого", "Агаарын тухай" хууль зэрэгт хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, "Нийслэлийн орон сууцны хөтөлбөр"-н хүрээнд хэрэгжих юм.

Одоогийн угсармал орон сууцны дулааны хэрэглээ жилд 226.9 гкал/цаг байдаг бол дулаалсны дараах угсармал орон сууцны дулааны хэрэглээ нь 141.1 гкал/цаг болох тооцоотой бөгөөд даруй 85.8 гкал/цаг-г хэмнэх боломжтой юм. Энэхүү хэмнэлтийг өнөөгийн төвшинтэй харьцуулахад ДЦС-2-н жилд үйлдвэрлэдэг 65 гкал/цаг дулаанаас 32 хувиар илүү хэмнэлтийг хийж болохуйц байна.

Улаанбаатар хотын хүн амын 20 хувь нь 1965-2000 онд баригдсан угсармал орон сууцанд амьдардаг байгаа ба уг байрнууд нь олон жил ашиглагдсан, барилгын хашилт хийц хуучирч муудсан, дулааны алдагдал ихтэй байна. Иймээс Улаанбаатар хотын хэрэглэж буй дулааны хэрэглээг хэмнэхийн тулд угсармал орон сууцыг дулаалах, техникийн шинэчлэл хийх шаардлага бий болж байна. 2016 оны байдлаар нийт 1077 ширхэг блок барилгад нийт 45.5 мянган өрх айл амьдарч байна. Дээрх барилгын 411,878 $м^2$ талбайг нэг жилд чулуун хөвөн дулаалгаар дахин дулаалахад 5.2 тэрбум төгрөгийн түүхий эд материал шаардагдах юм.

Харин уг талбайг хөөсөнцөр хавтангаар дулаалахад 5.3 тэрбум төгрөг буюу 2.2 сая ам.доллар шаардлагатай болох бөгөөд уг түүхий эдийг БНХАУ-с импортоор авдаг тул дээрх түүхий эдийн зарцуулалт нь 100 хувь импорт болон валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлэх боломжтой юм.




*Зураг 38 Улаанбаатар хотын барилгын байршлын мэдээлэл*

Хөтөлбөрийн хоёр дахь чухал хэсэг болох амины орон сууцны дулаалгын ажлын хүрээнд Улаанбаатар хотод амины орон сууцанд оршин сууж буй 108 мянга гаруй өрхийн дулаалгын асуудлыг шийдвэрлэх байгаа юм.

Ердийн үед нэг өрх жилд 8.3 тонн нүүрс зарцуулдаг бол дулаалгыг сайжруулснаар нэг өрх айл жилд 5.6 тонн нүүрс буюу 2.7 тонн нүүрс хэмнэх боломжтой болох юм. Харин тус өрх айлууд амины орон сууцаа базальт чулуун хөвөнгөөр дулаалснаар жилд 2.6 тонн нүүрс хэрэглэх ба агаарын бохирдлыг даруй 60 хувиар багасгах боломжтой болох юм.[11]

Нийт амины орон сууцыг гурван төрлийн талбайд хуваан дулаалгын материалын тооцооллыг гүйцэтгэхэд дунджаар 60 тэрбум төгрөгийн зах зээл байгаа нь харагдаж байна.

| Нэг амины орон сууцны дундаж талбай | 60м2 | 70м2 | 80м2 |
|---|---|---|---|
| Амины орон сууцны тоо | 106,395 | 106,395 | 106,395 |
| Нийт талбай | 6,383,700 | 7,447,650 | 8,511,600 |
| үүнээс: дулаалах талбай /дунджаар 50 хувь/ | 3,191,850 | 3,723,825 | 4,255,800 |
| Шүршдэг цавуутай базальт чулуун хөвөнгөөр дулаалбал /1м2=0.05м3/ чулуун хөвөн 50 мм | 3,191,850 | 3,723,825 | 4,255,800 |
| 1 м2 шүршдэг цавуутай базальт чулуун хөвөнгийн үнэ /төг/ | 18,000 | 18,000 | 18,000 |
| Шүршдэг цавуутай базальт чулуун хөвөнгийн нийт үнэ /тэрбум.төг/ | 57.45 | 67.03 | 76.60 |
| 1 м2 шүршдэг цавуугүй базальт чулуун хөвөнгийн үнэ /төг/ | 7,250 | 7,250 | 7,250 |
| Шүршдэг цавуугүй базальт чулуун хөвөнгийн нийт үнэ /тэрбум.төг/ | 23.14 | 27.00 | 30.85 |

*Хүснэгт 46 Амины орон сууцны базальт дулаалгын хэрэглээ*

Цаашлаад Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээнд дахин дулаалга хийх шинэчлэлийн төслийн хүрээнд Улаанбаатар хотын Ф200-Ф1200 мм-н 379.5 км магистраль шугам хоолойн дулааны алдагдлыг бууруулах шаардлагатай байгаа юм.

Уг шугам хоолойнууд нь насжилт өндөртэй байдаг тул дулаан алдагдал өндөртэй эдийн засгийн хувьд маш үр бүтээл багатай байна. Дээрх шугам хоолойг термобазальт (СТУ) дулаалгын материалаар дулаалснаар их хэмжээний эрчим хүчийг хэмнэж хотын хэмжээнд дулаалгын зардлыг багасгахад эерэгээр нөлөөлөх юм. Жишээлбэл ОХУ-ын Москва хот СТУ материалаар дулааны шугам

[11] Улаанбаатар хотын агаарын бохирдлын 52 хувь нь гэр хорооллын хэрэглэж буй зуух, 20 хувь нь автомашин, 10 хувь нь нам даралтын зуух, 10 хувь нь барилга байгууламж хуурай хог хаягдал, 6 хувь нь цахилгаан станцууд байна.

сүлжээний бүх шугам хоолойгоо дулаалснаар жилд дунджаар 500 МВт цахилгаан эрчим хүч хэмнэсэн гэсэн тооцоог гаргажээ.

## Монголын дулаалгын зах зээлийн Портерийн шинжилгээ

### Нийлүүлэлтийн хүч

- Базальт бүтээгдэхүүний түүхий эд болон дагалдах бүтээгдэхүүний нийлүүлэлтийг олон компани маш их өрсөлдөөнтэйгөөр нийлүүлдэг тул үнийн хувьд тогтвортой байна
- Үнэт цаас гаргагч нь өөрийн гэсэн базальт ордтой тул нийлүүлэх бүтээгдэхүүний үнэ тогтмол байна.

### Худалдан авагчийн хүч

- Худалдан авагч нар олон болох тусам үйлдвэрлэлийн тоо өсөх тул үнэ буурах боломжтой
- Монголын зах зээлд монополь учир үнийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх боломжтой
- Импортын дулаалгын материалын гаалийн татвар нэмэгдсэн тул үнийн давуу байдал бий болох боломжтой болж байна.

### Өрсөлдөгч

- Базальтын зах зээлд дотоодын үйлдвэрлэгч байхгүй тул өрсөлдөөн байхгүй, гэвч өөр төрлийн тэр дундаа хямд үнэтэй хөөсөнцөр, шилэн хөвөн зэргийн импортлогч нар болон үйлдвэрлэгч олонтой.
- Чанараар илт давуу бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.
- Төр засгаас дотоодын үйлдвэрлэгчийг дэмжих бодлого баримталж байгаа нь таатай нөхцөл болно.

### Орлуулалтын аюул

- Дулаалгын материалын зах зээлд олон төрлийн бүтээгдэхүүнүүд бий бөгөөд хэрэглэгчид өөр бүтээгдэхүүн рүү шилжих боломж өндөртэй.
- Бусад орлох бүтээгдэхүүнээс чанараар ялгардаг.

### Шинэ оролцогчийн аюул

- Базальтын үйлдвэрлэл нь өндөр капитал шаарддаг ба технологийн нарийн мэдлэг шаарддаг тул зах зээлд өрсөлдөгчид шинээр ороход амаргүй, Харин бусад төрлийн дулаалгын материалын өрсөлдөөн маш их, шинээр тоглогчид орох магадлал өндөр

Монгол Улсын барилгын дулаалгын зах зээлд үндсэн 5-н төрлийн бүтээгдэхүүн ашиглагдаж байгаа бөгөөд дотоодод шилэн хөвөнгөөс бусад бүх төрлийн дулаалгын материал болох хөөсөнцөр хавтан, чулуун хөвөн, эсгий дулаалга, сендвичэн хавтан зэргийг үйлдвэрлэж байна. 2015 оны байдлаар 70 гаруй аж ахуйн нэгж 476 мянган ам.доллар үнэ бүхий 185 тн дулаалгын хөөсөнцөр материал, 2000 орчим хувь хүн, аж ахуйн нэгж 3.2 сая ам.долларын үнэ бүхий 2.5 сая тонн шилэн хөвөн, 30 орчим аж ахуйн нэгж 339 мянган ам.долларын үнэ бүхий 540 тонн чулуун хөвөн импортолсон байна. Дээрх компаниудын нийт импортын хэмжээ 2015 онд 4 орчим сая ам.долларт хүрсэн нь дотоодын зах зээлд тэр хэмжээний үйлдвэрлэлийн орон зай байгааг харуулж байгаа юм.

**Дулаалгын материалын импорт**

| | 2013 | | 2014 | | 2015 | | 2016 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо тн/ | `000 USD | Тоо /тн/ | `000 USD | Тоо /тн/ | `000 USD | Тоо /тн/ | `000 USD |
| Эрдэс хөвөн | 383 | 578 | 1,486 | 1,064 | 547 | 357 | 258 | 429 |
| Шилэн мяндас, хөвөн | 2,003 | 2,717 | 2,740 | 3,846 | 2,490 | 3,253 | 1,777 | 2,109 |
| Хөөсөнцөр | 364 | 126 | 122 | 335 | 185 | 454 | | |
| **Нийт** | **2,751** | **3,421** | **4,349** | **5,245** | **3,223** | **4,065** | | |

*Хүснэгт 47 Дулаалгын материалын импорт (Гааль, Татварын ерөнхий газар)*

Дулаалгын материалын зах зээл нь 2015 оны байдлаар ойролцоогоор 50 тэрбум төгрөг байгаа бол цаашлаад "Дулааны техникийн шинэчлэл" дэд хөтөлбөр (2017-2020) хэрэгжвэл уг зах зээлд эерэг нөлөөтэй юм.

## Барилгын салбар дахь эрэлт

Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд орлогын төвшнөөсөө шалтгаалан орон сууц худалдан авах боломжгүйгээс гэр хороолол сүүлийн арваад жилд эрчимтэйгээр тэлсэн билээ. Энэ их нүүдлээс өмнө нийслэлийн айл өрхүүдийн 50 гаруй хувь нь төвлөрсөн хангамжид холбогдсон орон сууцны хороололд амьдарч байсан бол 2003 оноос эхлэн гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо нэмэгдэж, 2011 оны байдлаар нийт өрхийн 60%, 2012 онд 59.6% болон 2014 онд 57.9% нь гэр хороололд амьдарч байна. 2013 оноос хэрэгжиж эхлэж буй Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн 8 хувь, алслагдсан дүүргийн 5 хувийн ипотекийн зээл зэрэг болон Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг хөтөлбөрүүд нь цаашлаад барилгажуулалтыг дэмжин орон сууцны бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулахаар байна. Хэдийгээр 2016 оны байдлаар зах зээлд орон сууцны нийлүүлэлт эрэлтээс давсан байдалтай байгаа боловч цаашлаад гэр хороололд дахин төлөвлөлтөөр баригдахаар төлөвлөгдсөн орон сууцнуудын бүтээн байгуулалт хэрэгжсэнээр нийт барилгын тоо болон худалдан авах чадвар нэмэгдэхээр байгаа юм.

2016 оны 1-р сарын байдлаар нийслэлийн 362 мянган өрхийн 43% нь буюу 156 мянган өрх орон сууцны хороололд, 57% буюу 206 мянган өрх нь гэр хорооллын бүсэд оршин сууж байна.
Орон сууц худалдан авах боломжтой 63,915 өрх үүнээс бэлэн мөнгөөр худалдаж авах хүсэлтэй өрхийн тоо 10,327, өөрийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгөө борлуулах замаар худалдан авах 6,746, ипотекийн зээлийн нөхцөлийг хангаж чадахуйц 37,039, өөрийн өмчлөлийн газрыг орон сууцаар шууд солих хүсэлтэй 9,803 өрх байна.




*Зураг 39 Барилга Эм Эн ХХК, Судалгааны алба*

Орон сууцны эрэлт нийлүүлэлтийн гол үзүүлэлт болох үнэ сүүлийн жилүүдэд тогтмол бууралттай байгаа нь худалдан авах чадвартай нийт өрхийн тоог нэмэгдүүлж цаашид барилгын салбарт худалдан авалт үүсэх боломжийг нээх юм. Монгол Улсын хувьд залуу гэр бүл ихтэй, орон сууцанд амьдрах хүсэлт өндөр байдаг бөгөөд тэдний байранд орж чаддаггүй гол шалтгаан нь залуу гэр бүлүүдийн хувьд хуримтлал үүсгэж амжаагүй, эсвэл орон сууцны үнэ хэтэрхий өндөр байдагт оршиж байгаа юм. Нийлүүлэлт нь эрэлтээс давсан энэ үед барилгын үнэ буудаг ба энэ нь залуу гэр бүлүүдийн хувьд өргөн боломжийг бий болгох юм.

Орон сууцны барилгаас гадна хувийн секторт зочид буудал, дэлгүүр худалдааны төвүүд, үйлчилгээний салбарын шинэ бүтээн байгуулалтууд мөн өсөн нэмэгдэж байна. Төр засгийн зүгээс мөн улсын сургууль, цэцэрлэгүүдийн тоог нэмэгдүүлэх, барилга байшинг шинэчлэн засах, шинээр нэмж барих ажлуудыг анхааралдаа аван ажиллаж байна.




*Зураг 40 Орон сууцны үнийн индекс (Монголбанкны статистик)*

| Монголын дулаалгын материалын зах зээлийн SWOT анализ | |
|---|---|
| **Давуу тал**<br>▪ Зах зээлд оролцогчид цөөн<br>▪ Базальт бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байхгүй тул монополь болох боломжтой<br>▪ Өвөл маш хүйтэн болдог тул сайн чанартай дулаалгын материалын хэрэгцээ өндөр<br>▪ Дулаалгын материалын импортын бодлого, дотоодын зах зээлийг хамгаалах чиглэлтэй болсон тул импортын өрсөлдөөн багасна | **Сул тал**<br>▪ Хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ таниулахад цаг хугацаа, мөнгө шаардагдана<br>▪ Импортын өөр материалууд болох хөөсөнцөр, шилэн хөвөн зэргийн импорт өндөртэй<br>▪ Хямд дулаалгын материал ихтэй<br>▪ Хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байдал нь хямд бүтээгдэхүүнийг илүүд үзэх нөхцөлийг бий болгодог |
| **Боломж**<br>▪ Зах зээлд шинэ орон сууц, үйлдвэрүүд зогсолтгүй баригдаж байгаа<br>▪ Сайн чанартай бүтээгдэхүүнээр дотоодын зах зээлийг 100 хувь хангах боломжтой<br>▪ Тээврийн зардал бага байдаг нь өөр төрлийн импортын бүтээгдэхүүнтэй үнээр өрсөлдөх нөхцөлийг бий болгож байгаа | **Аюул**<br>▪ Бусад дулаалгын материалаас үнэ өндөр тул хэрэглэгчдийн шаардлагаас давсан үнэтэй байх магадлалтай<br>▪ Зах зээл удаашрснаар дотоодын барилгын салбар уналтад орох магадлалтай |

## Барилгын салбар дахь нийлүүлэлт

2016 оны 7-р сарын байдлаар 253 төслийн нийт 53,276 айлын сууцны барилга баригдаж захиалга авч байна. Үүнээс 98% нь 224 төслийн орон сууц, 2% нь 29 төслийн хаус байна.

Мөн барилгын ажил зогссон 35 төслийн 8,937 айлын орон сууц, 3 төслийн 208 айлын хаус, таун хаус байна. Захиалга авч эхлээгүй байгаа 91 төслийн 46,586 айлын орон сууц, 8 төслийн 4,111 айлын хаус, таун хаус байна.

УБ хотын сууцны нийлүүлэлт, айлын тоогоор:

| | Төслийн тоо | Нийт |
|---|---|---|
| Орон сууц | 224 | 52,177 |
| Хаус | 29 | 1,099 |
| Нийт | 253 | 53,276 |

*Хүснэгт 48 Судалгааны MMCGI агентлаг*

Азийн Хөгжлийн Банк, Нийслэлийн засаг даргын тамгын газрын хамтран хэрэгжүүлж буй "Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хөтөлбөрт" 10 гаруй мянган айл өрхийг хамруулахаар шийдвэрлэсэн байна. Уг төслийн хүрээнд гэр хороолол төлбөрийн чадварт нийцсэн 10-15 мянга гаруй өрхийн орон

сууцыг барьж байгуулах бөгөөд гэр хорооллын 100-130 га газрыг дахин төлөвлөж эко дүүрэг болгон хөгжүүлэх юм. Үүнээс 55 хувь нь төлбөрийн чадварт нийцсэн орон сууц, 15 хувь нь халамжийн орон сууц, 30 хувь нь зах зээлийн үнээр борлогдох орон сууц байхаар төлөвлөжээ. Улаанбаатар хотын гэр хороолллыг дахин төлөвлөх замаар гэр хорооллын иргэдийн амьдрах орчныг сайжруулж, хот төлөвлөлтийн нэгдсэн шийдэл, төлөвлөлттэй, холимог газар ашиглалт, холимог орлогын төвшний өрхүүдэд зориулсан бүс бий болгох зорилготой төсөл юм.

Цаашдаа Засгийн газар, НЗДТГ зэрэг төрийн оролцоотой байгууллагуудын санаачилга болон хувийн салбарын хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор барилгын салбарт шинээр орон сууцнууд, сургууль цэцэрлэг ихээр баригдах төлөвтэй байна.

### 1.2.2 Олон улсын дулаан тусгаарлах материалын зах зээл

Олон улсын судалгааны байгууллагын судалгаанаас харахад дэлхийн дулаан тусгаарлах материалын зах зээл 2017 онд 52.3 тэрбум ам.доллар байсан бөгөөд 2025 он хүртэл жилд дунджаар 8.6% өсөлттэй байх төлөвтэй байна[12]. Дэлхий даяар эрчим хүчний зардал нэмэгдэж байгаагаас гадна БНХАУ зэрэг томоохон зах зээлд эрчим хүч хэмнэх барилгын стандартууд шинээр нэмэгдэж байгаа нь дулаалгын материалын зах зээлд эерэгээр нөлөөлж байна. Энэхүү судалгаанд дурдсанаар 2025 онд дэлхийн дулаан тусгаарлах материалын зах зээл 101.3 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн байна.

#### БНХАУ-ын зах зээл

Дэлхийн хоёр дахь том зах зээл болох БНХАУ-н барилгын салбар нь 2000-2010 оны хооронд маш хурдацтайгаар буюу жилийн 23 хувийн өсөлттэй байсан бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлттэй нягт уялдаа холбоотой байв. Барилгын салбар нь БНХАУ-н ДНБ-ий 26.4 хувийг эзэлдэг бөгөөд Хятадын эдийн засаг удааширсан 2014-2016 онуудын хооронд барилгын салбарын өсөлт мөн саарсан үзүүлэлттэй байлаа. 2014-2016 онуудад Хятадын нийт 100 томоохон хотод орон сууцны үнэ унасан байдалтай байгаа нь цаашдаа барилгын салбарт оролцдог талуудын санхүүгийн асуудалд хүндрэлүүд гарч ирэхэд нөлөөлж байгаа тул Хятадын засгийн газраас барилгын салбарын дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллаж байна. Хятадын коммунист намын 18 дахь удаагийн уулзалтын шийдэл нь илүү чанарыг эрхэмлэсэн, тогтвортой хөгжилд хүрэх уриатай бөгөөд шинэ загварын хотжилтын төлөвлөгөөг боловсруулж газрыг илүү үр дүнтэй ашиглаж, хот хөдөөг холбосон дэд бүтэц, зам тавих зэрэг ажлуудыг тусгасан байна.[13] Энэ хүрээнд олон хот, зам, дэд бүтэц зэрэг барилгын салбарт голлох үүрэг гүйцэтгэдэг төслүүдийг хэрэгжүүлж эхлэхээр байна.

2014 онд Хятадын Засгийн газар Шинэ-Хотжилт төлөвлөгөөндөө 2014-2020 оны хооронд хотын байгууламжуудаа Ногоон буюу эдийн засаг байгаль орчны хувьд ээлтэй байгууламжуудаар нийт байгууламжуудын 50 хувийг барина гэсэн төлөвлөгөөг гаргасан. Энэ нь 2020 он гэхэд Хятадын ногоон шинэ барилгын талбай 7 тэрбум метр квадратад хүрнэ гэсэн үг юм. Мөн XII дахь таван жилийн төлөвлөгөөнд хуучин барилгуудыг дахин дулаалах болсон. Хойд бүс нутагт 400сая м$^2$, Дундын бүс нутагт 50 сая м$^2$, Нийтийн орон сууцны 120 сая м$^2$, 50 ш кампус, нийтийн 200,000 м$^2$ талбай бүхий барилгуудыг дахин дулаалахаар болсон байна. Хуучин барилгын дулаалгыг хойд бүс нутгаар түлхүү хийж байгаа нь цаг агаарын онцлогтой холбоотой байна.

Хятадын дулаалгын материалын зах зээлийн дөнгөж 7 хувийг эрдэст чулуун хөвөн эзэлж байгаа бол ОХУ- ын хувьд 40 хувь, Монголын хувьд 10 хүрэхгүй байгаа юм. Ийнхүү зөрүүтэй байгаагийн гол шалтгаан цаг уурын ялгаатай байдал, худалдан авах чадвар, төр засгийн бодлогоос хамаарч байна. Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр Хятадын дулаалгын зах зээлийн багтаамж ирэх жилүүдэд эрс өсөх төлөвтэй байгааг OAL Consultants-аас судалжээ. Тус компанийн судалгаагаар 2012 оны байдлаар 173 сая.м$^3$ дулаалгын материал бүхий зах зээл байгаа бол 2017 он гэхэд 330 сая м$^3$ буюу 2012 оныхоос

[12] https://www.grandviewresearch.com/industry-analysis/insulation-market
[13] http://www.ccilc.pt/sites/default/files/eu_sme_centre_report_-_the_construction_sector_in_china_update_-_june_2015.pdf

90 хувиар өсөх таамаглалыг гаргажээ. Тэгвэл өнөөгийн бодит тоонд үндэслэн тооцвол эрдэст чулуун хөвөнгийн жилийн хэрэглээ 12 сая $м^3$ юм. Цаашид Хятадын хэрэгжүүлж буй "Ногоон Барилга" хөтөлбөрийн хүрээнд зах зээлд эзлэх хувь 50% хүртэл өсөх боломжтой.[14]




*Зураг 41 Хятадын хувьсан өөрчлөгдөж буй хот суурин газар*

БНХАУ-н барилгын салбарын хөгжил нь 2016-2020 онд жилийн 3.9 хувийн өсөлттэй байх төлөвтэй байгаа ба 2020-2025 онуудад 4.8 хувиар өснө гэсэн таамаглалыг JLL үл хөдлөхийн компани дэвшүүлээд байна[15].

**Байршлын давуу тал:**
"Монгол базальт" ХК-нь дулаалгын материалын хэрэглээ өндөртэй Хойд Хятадын зах зээлд хүрэхэд газарзүйн байршлын хувьд Хятадын томоохон үйлдвэрлэгчидтэй ойролцоо хэмжээний зайд байгаа боловч Хятадын эрдэст чулуун хөвөнгийн үйлдвэрүүд нь Бээжингээс урагшаа эсвэл зүүн зүгт байрлаж байгаа нь компанийн хувьд харьцангуй давуу тал болох боломжтой.

**Чанараар өрсөлдөх чадвар:**
Хятадын хувьд эрдэст чулуун хөвөнг үйлдвэрлэхдээ ашиглаж буй түүхий эд нь манай ашиглаж буй түүхий эдийн чанартай дүйцдэггүй бөгөөд цэвэр базальт чулуун хөвөнгөөр хийхээс илүү төмрийн үйлдвэрийн үлдэгдэл шаарга хэрэглэдэг байна. Энэ чанараараа "Монгол базальт" ХК-ны бүтээгдэхүүн нь Хятадын зах зээлд, ялангуяа, эрс хүйтэн бүс нутгийн зах зээлд чанараар өрсөлдөх бүрэн боломжтой байна.

**Баримтлах стратеги:**
Бүтээгдэхүүний үнийг аль болох бага хэмжээнд барьж, чанараар өрсөлдөх стратеги баримтлах стратегиар ажиллана. Зах зээлд ойрхон байршилтай, цаг агаар нь эрс хүйтэн, хотжилт багатай зэрэг нь хойд Хятадын зах зээлд "Монгол базальт" хувьцаат компанийн бүтээгдэхүүн нэвтрэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

[14] http://www.ccilc.pt/sites/default/files/eu_sme_centre_report_-_the_construction_sector_in_china_update_-_june_2015.pdf
[15] http://www.scmp.com/property/hong-kong-china/article/1877354/construction-declines-china-shifts-industrial-sector

| Хятадын эрдэст чулуун хөвөнгийн зах зээл/м3 | |
|---|---|
| 12,110,000.00 | |
| Хойд Хятад | Монгол Базальт |
| 1,211,000.00 | 35,000.00 |
| ХОЙД ХЯТАДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН | |
| 3% | |




*Зураг 42 БНХАУ-н зах зээлийн тойм*

| БНХАУ-н дулаалгын материалын зах зээл | |
|---|---|
| **Давуу тал**<br>▪ Зах зээлийн хэмжээ том, хэрэглэгч олонтой<br>▪ Нутгийн зүүн болон хойд хэсэг, ялангуяа Өвөрмонгол, Манжуур талаар өвөл маш хүйтэн болдог тул сайн чанартай дулаалгын материалын хэрэгцээ өндөр<br>▪ Хэрэглэгчид нь материалаа сайн ойлгосон тул таниулахад цаг бага зарцуулна<br>▪ Бусад орон, ялангуяа ОХУ-аас базальтан дулаалгын бүтээгдэхүүн авдаггүй | **Сул тал**<br>▪ Өрсөлдөөн маш өндөр, ялангуяа үнээр өрсөлдөх чадвар өндөртэй компаниуд олон<br>▪ Зах зээлд хүрэх зай Хятадын дотоодын компаниудаас илүү<br>▪ Гаалийн татвар, орлогын татвар зайлшгүй төлнө<br>▪ Хямд дулаалгын материал ихтэй<br>▪ Дотоодын компаниуд олонтой |
| **Боломж**<br>▪ Зах зээлд шинэ орон сууц, үйлдвэрүүд зогсолтгүй баригдаж байгаа<br>▪ Сайн чанартай бүтээгдэхүүнээр дотоодын компаниудтай өрсөлдөх боломжтой<br>▪ Их хэмжээгээр нийлүүлэх боломжтой<br>▪ Төмөр замаар тээвэрлэлт хийх тул зардал бага | **Аюул**<br>▪ Гаалийн татвар болон худалдааны татвар өсөх боломжтой<br>▪ Тээвэрлэлтэд удаашрал, хүндрэл гарах боломжтой<br>▪ Худалдааны дотоодоо хамгаалах бодлого явуулах магадлалтай |

*Хүснэгт 49 БНХАУ-н дулаалгын материалын зах зээл*

## ОХУ-ын зах зээл

ОХУ-ын барилгын салбар 2014 онд 197.3 тэрбум ам.доллар, 2015 онд 182.5 тэрбум ам.долларт хүрч байсан бол 2016 онд энэ салбарын өсөлт 1 хувиар удаашрах төлөвтэй байна.[16] 2014, 2015 онуудын удаашралын гол шалтгаан нь бизнесийн орчин, ханшийн уналт, Барууны орнуудын эдийн засгийн хориг, гадаадын хөрөнгө оруулалтын бууралт, газрын тосны үнийн уналт зэргээс хамаарч байв. Хэдийгээр сүүлийн 2-3 жил удаашралтай байсан ч энэ салбар цаашид тогтвортойгоор өсөх боломжтой байна. ОХУ-н засгийн газраас хэрэгжүүлж буй “Нийгэм эдийн засгийн хөгжил 2020” нэртэй хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх ба авто зам, төмөр зам, нисэх буудал зэрэг томоохон төслүүд нь барилгын салбарыг 2020 он хүртэл жилийн 2.5 хувийн өсөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэхээр байна.[17]

ОХУ нь 1992 онд Оросын Барилга, Архитектурын Академийн Барилгын Судалгааны Институци, Оросын Улсын Барилгын Хороо бусад төрийн байгууллагууд хамтран эрчим хүчний хэмнэлттэй барилга барих стандартуудыг боловсруулсаар 2005 он гэхэд цоо шинэ стандарттай болсон бөгөөд энэ нь 2002 онд Европт хэрэгжүүлж эхэлсэн стандарттай эн тэнцүү хэмжээнд хүрчээ. Үүний дараа 2009 оны 11-р сард ерөнхийлөгч Дмитрий Медведев эрчим хүчний шинэ хуулийг батлаж 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээг 40 хувиар бууруулах зорилго тавьжээ. Ийнхүү эрчим хүчний хэрэглээг

[16] 2010 оны ам.долларын тогтвортой үнээр авав.
[17] http://www.businesswire.com/news/home/20160215005407/en/Russia-Construction-Market-Growth-2.52-CAGR-2020

бууруулахад гудамж ба барилгын дулаанд зарцуулж буй эрчим хүчийг 44 хувиар бууруулах зорилт тавьсан юм.

Учир нь ОХУ-ын барилгууд нь Европтой харьцуулахад 2-3 дахин их эрчим хүчийг дулаанд зарцуулдаг. Дулааны цахилгаан станцаас гарсан дулааны 40 хувь нь хэрэглэгчиддээ хүрдэггүй, замдаа алдагддаг гэж дэлхийн хамгийн том эрдэст чулуун хөвөн үйлдвэрлэгч Роквүүл компаниас мэдээлжээ. Иймээс ОХУ тавьсан зорилгодоо хүрэхийн тулд барилгуудын дулаалгын материал, цонх, хаалгыг сайжруулж, дулаан бага дамжуулдаг болгох ёстой юм. Эдгээр дотор дулаалгын материал нь гол байр суурьтай бөгөөд хуучин барилгуудаа дахин дулаалах, шинэ орон сууцнуудыг дулаан бага дамжуулдаг материалаар дулаалах шаардлага үүссээр байна. Дээрх шаардлагыг хангасан дулаалгын материал нь яах аргагүй эрдэст чулуун хөвөн учир уг бүтээгдэхүүний зах зээл ОХУ-д эрс нэмэгдэж эхэллээ. Орос дахь Роквүүл ХК-ийн маркетингийн албаны захирал "2020 он гэхэд ОХУ нь эрчим хүчний хэрэглээг 40 хувиар бууруулахаар зорьж байна. Шинэ эрчим хүчний хууль нь шинэ барилгуудад сайн чанарын дулаалгын материал ашиглах, хуучин барилгуудын дулаалгыг сайжруулах хэрэгцээг бий болгож эрдэст чулуун хөвөнгийн эрэлтийг нэмэгдүүлэх нь гарцаагүй" гэжээ. Зах зээлийн өсөн нэмэгдэх боломжийг олж харсан эрдэст чулуун хөвөн үйлдвэрлэгчдийн өрсөлдөөн ОХУ-д ширүүссээр байна.

**ОХУ-н базальт чулуун бүтээгдэхүүний зах зээл**

ОХУ-н чулуун хөвөнгийн зах зээлийн 31 хувийг Технoникол, 21 хувийг Роквул, Изорок, Изовол хоёр тус бүр 9 хувийг эзэлж байгаа бол Лайнрок-Изовер, Энергозашита болон Термостепс тус бүр 8, 4, 1 хувийг тус тус эзэлж байна. Доорх зурагт ОХУ-н чулуун хөвөнгийн үйлдвэрүүдийн байршлыг харуулсан байгаа бөгөөд нутгийн зүүн хэсэгт үйлдвэрүүдийн тоо цөөн байгааг онцолж болохоор байна. ОХУ-н зүүн хэсэгт Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хүргэх тээврийн зардал бага улмаар үнийн хувьд илүү уян хатан нөхцөлтэйгөөр зах зээлд нийлүүлэх боломжтой болох юм.




*Зураг 43 АРАБУС судалгааны агентлаг 2012*

Үйлдвэрлэлийн байрлалаар нь болон үйлдвэрийн хэмжээгээр нь нягтлан харвал дараах байдалтай байгаа ба нийт үйлдвэрлэлийн ердөө 9 хувь буюу 1.6 сая $м^3$ бүтээгдэхүүн Сибир, Зүүн хязгаарт үйлдвэрлэгдэж байна.




*Зураг 44 АРАБУС судалгааны агентлаг 2012*

**ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээ**

2014 онд ОХУ-н ерөнхийлөгч В. Путины Монгол Улсад хийсэн айлчлалын хүрээнд хоёр улсын хоорондын худалдааг 2020 он гэхэд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улс нь ОХУ-тай худалдааны өндөр алдагдалтай байдаг ба уг алдагдлыг багасгах зорилгоор Монголын экспортыг 20 жилийн турш ОХУ-руу ямар нэгэн орлогын болон гаалийн татваргүй экспортлох хэлцлийг эхлүүлээд байна. Уг шийдвэр батлагдах тохиолдолд "Монгол базальт" компанид маш ашигтай нөхцөл байдал үүсэх юм.

**Байршлын давуу тал**

ОХУ-ын эрдэст чулуун хөвөнгийн үйлдвэр нь төв, хойд, баруун талдаа төвлөрчээ. Энэ нь компанийн зорилтот зах зээл болох Эрхүү муж орчим, Улаан-Үдэд Оросын дотоодын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ нийлүүлэхийн тулд Монголоос нийлүүлснээс хамгийн багадаа хоёр дахин их зам туулахад хүргэж байгаа юм.

**ОХУ-н Эрхүүд бүтээгдэхүүн нийлүүлэх зай**




*Зураг 45 АРАБУС судалгааны агентлаг 2012*

**Үнээр өрсөлдөх чадвар**

Эрдэст чулуун хөвөн нь овор ихтэй учир хол газар тээвэрлэхэд тээврийн зардал ихээр нэмэгдэх тул компанийн зорилтот зах зээлд үнээр өрсөлдөх боломжтой Оросын дотоодын үйлдвэрлэгч ховор байна. Мөн "Монгол базальт" ХК-н үйлдвэрлэлийн өртөг ОХУ-ын Үйлдвэрлэгчдийн өртгөөс бага байгаа юм. Гэвч ОХУ-руу Монголоос бүтээгдэхүүн экспортлоход гаалийн татвар, НӨАТ зэргээс хамаарч бүтээгдэхүүний үнэ 20-30 хувиар нэмэгддэг нь энэхүү давуу байдлаа ашиглаж чадахгүй байх

гол шалтгаан болж байна. Тэгвэл ОХУ нь Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэн бөгөөд уг байгууллагын гишүүн болсны хувьд "хоёр талын гадаад худалдаанд тавьж буй татвар, тариф нь ижил байх" гэсэн зарчмыг баримтлах тул татварын хувь хэмжээ 5-10 хувь хүртэл буурах боломжтой юм. Үүнээс гадна ОХУ- ын ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ОХУ-д Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг 20 жилийн хугацаанд татвар, тарифгүйгээр нийлүүлэх тухай хүсэлтээ ОХУ-ын ерөнхийлөгчид илэрхийлсэн. Уг хүсэлт ирэх жилээс ажил хэрэг болох тохиолдолд компанид ОХУ-руу бүтээгдэхүүнээ борлуулах боломж нэмэгдэх юм.

**Баримтлах стратеги**

"Монгол базальт" ХК-ийн шинэ үйлдвэрт ашиглагдах технологи, тоног төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийнх учир ОХУ- ын өрсөлдөгчийн бүтээгдэхүүнтэй ижил төвшний чанар бүхий эрдэст чулуун хөвөн дулаалгыг үйлдвэрлэх боломжтой. Иймээс компанийн хувьд үнээр өрсөлдөх чадвартай байх нь маш чухал юм. Эрхүүд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний дундаж үнэ кг тутамд 2,000 төгрөг байгаа бол "Монгол базальт" ХК-ийн бүтээгдэхүүний үйлдвэрийн өртөг 911 төгрөг. Энэ нөхцөлд тус компани нь 20-30 хувийн цэвэр ахиуц ашигтай ажиллах боломжтой юм.

| ОХУ-н дулаалгын материалын зах зээл | |
|---|---|
| **Давуу тал**<br>▪ Зах зээлийн хэмжээ том, хэрэглэгч олон<br>▪ Нутгийн зүүн болон урд хэсэг, ялангуяа Эрхүү, Улаан-үд хавиар үйлдвэрийн тоо цөөн, дотоодын компаниудын тээвэрлэлтийн зай их<br>▪ Хэрэглэгчид нь материалаа сайн ойлгосон тул таниулахад цаг бага зарцуулна | **Сул тал**<br>▪ Өрсөлдөөн их, дотоодод тогтсон зах зээлээ эзэлсэн компаниуд олонтой.<br>▪ Гаалийн татвар, орлогын татвар зайлшгүй төлнө |
| **Боломж**<br>▪ Зах зээлд шинэ орон сууц, үйлдвэрүүд зогсолтгүй баригдаж байгаа<br>▪ Өвөл маш хүйтэн тул, дулаалгын сайн чанарын бүтээгдэхүүн шаардлагатай<br>▪ Сайн чанартай бүтээгдэхүүнээр дотоодын компаниудтай өрсөлдөх боломжтой<br>▪ ОХУ-н компаниудтай хамтарч нутгийн зүүн, зүүн урд хэсгийг хангах боломжтой<br>▪ Төмөр замаар тээвэрлэх тул зардал бага | **Аюул**<br>▪ Гаалийн татвар болон худалдааны татвар өсөх боломжтой<br>▪ Тээвэрлэлтэд удаашрал, хүндрэл гарах боломжтой<br>▪ Эдийн засгийн удаашралтай холбоотойгоор дулаалгын материалын зах зээл хумигдах магадлалтай |

*Хүснэгт 50 ОХУ-ын дулаалгын материалын зах зээл*

## Япон Улсын зах зээл

Япон улс нь АНУ-н дараа орох хоёрдогч том барилга угсралтын орон бөгөөд хүн амын орлогын хэмжээ өндөр, насжилтын төвшин их зэргээс шалтгаалан эрчим хүч бага зарцуулдаг, экологид ээлтэй шинэ технологийн бүтээгдэхүүн ашиглах сонирхол нь нэмэгдэж буй орон юм. Япон улсын барилгын салбар 2019 оныг хүртэл жилд 1.2 хувь өсөлттэй байх төлөвтэй ба 2020 онд Токио хотод олимп болохтой холбоотойгоор цэнгэлдэх хүрээлэнгүүдийн барилгын ажлын хэмжээ нэмэгдэх төлөвтэй байна. Мөн Япон орныг зорих жуулчдын тоо өсөхийн хэрээр чанартай зочид буудлууд нэмэгдэж байна.

Япон улсын Засгийн газраас нийт эрчим хүчний 30 хувийг орон сууц эзэлж байгааг онцолсон бөгөөд орон сууцанд эрчим хүч бага хэрэглэдэг технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. 2012 оноос хойш Японы засгийн газраас эрчим хүчний хэмнэлттэй барилгыг барихаар дараах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллаж байна. Үүнд:

- Шинээр баригдаж буй барилгад хэрэглэгдэх эрчим хүч нь тухайн барилгын орчинд үүсгэх сэргээгдэх эрчим хүчний хэмжээтэй тэнцүү байлгах зорилгоор карбон диоксидийг багасгадаг сертификат бүхий барилгыг материалыг ашиглахыг дэмжиж байна.
- Ашиглагдаж буй барилгуудын эрчим хүчний хэмнэлттэй болгохын тулд эрчим хүчний хэмнэлттэй барилгын материал ашиглан дахин засварлах

- Хувь хүмүүс болон байгууллагуудын чадавхыг сайжруулж эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн ашиглах ухагдахууныг бий болгохоор ажиллаж байна.
- Япон улсын зах зээл нь маш өндөр өрсөлдөөнтэй байдаг тул шинээр нэвтрэх бүтээгдэхүүнүүд өөр бусад улсын брэндүүдтэй өрсөлдөх шаардлагатай болдог. Энэ өрсөлдөөнд ялахын тулд хэрэглэгчдэд өөрсдийн бүтээгдэхүүнийг таниулах, тэдгээрийн итгэлийг олох болон өрсөлдөгч нараас бүтээгдэхүүнээ давуу талтай гэдгийг харуулах шаардлага үүсдэг.[18]

## Дулаалгын материалын импорт

Япон Улс 2013, 2014 онд барилга, байгууламжийн салбартаа 48.7 их наяд иен зарцуулсан ба энэ нь 2009 оноос хойш тасралтгүй өссөн үзүүлэлт болж байна. Нийт хөрөнгө оруулалтын 50 хувь орчим нь хувийн салбарын барилгад зарцуулагддаг бол ойролцоогоор 5 хувь нь Засгийн газрын хөрөнгө оруулалт байдаг байна. Японд барилгын салбарт 5 сая орчим хүн ба 470 мянга орчим компани ажилладаг. Япон улсын барилгын дулаалгын материалын импорт 2014 онд 161 сая ам.доллар буюу 400 гаруй тэрбум төгрөгт хүрсэн нь маш том зах зээл байгааг илтгэж байна.

| Sector | Imports (2014, USD) | U.S. Rank as Import Source | U.S. Import Market Share |
|---|---|---|---|
| HVACR | $7.7 billion | 3 | 9.1% |
| Lighting | $1.5 billion | 5 | 4.3% |
| Plumbing | $776 mil. | 9 | 2.5% |
| Wood products | $10.9 billion | 5 | 8.4% |
| Insulation | $161 million | 2 | 18.8% |
| Windows & Doors | $795 million | 4 | 2.9% |
| Glass | $196 million | 5 | 12.5% |

Зураг 46 Япон Улсын импортын зах зээл

Япон улсын дулаалгын материалын импортыг дараах улс орнууд хангадаг байна. Үүнд:

1. БНХАУ (33.9%)
2. АНУ (18.8%)
3. Их Британи (11.6%)
4. Өмнөд Солонгос (7.3%)
5. Герман (4.5%)

2014 оны статистик мэдээгээр Япон улс нь эрдэст чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалыг 30-аад улсаас импортолсон бөгөөд БНХАУ-аас хамгийн их буюу нийт импортын хэмжээний 28% болох 25 сая ам.долларын, Англи улсаас нийт импортын 20% болох 18.5 сая ам.доллар, Өмнөд Солонгос улсаас 19% буюу 17.5 сая ам.долларын эрдэст чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалыг тус тус импортолсон байна. 2014 оны байдлаар Япон улс нийт 859 тэрбум ам.доллартай тэнцэхүйц хэмжээний барилгын материал импортолсны 74 сая ам.доллар (10%) нь эрдэст чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал 1.06 дахин өссөн үзүүлэлт бол 2012 онтой харьцуулбал 1.21 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс дүгнэхэд, Япон улсад эрдэст чулуун хөвөнгийн импорт жил бүр хурдацтай өсөж байгааг харуулж байна.




*Зураг 47 Япон Улсын чулуун хөвөнгийн импорт*

[18] http://trade.gov/topmarkets/pdf/Building_Products_Japan.pdf

**BASALTWOOL–ыг Япон улсад экспортлох стратеги**

Япон Улсын эрдэст чулуун хөвөнгийн импортын хэмжээ жилд 75 сая гаруй ам.доллар хүрч байна. Япон улс нь эрдэст чулуун хөвөнг барилгын салбараас гадна хүнд, хөнгөн аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн салбарт өргөн зориулалтаар ашигладаг. Хамгийн өргөн хэрэглээнүүдийн нэг бол хөрсгүй тариалан "Гидропоник" юм. "Монгол базальт" компани нь жил бүр Япон Улсад 5 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний эрдэст чулуун хөвөнг экспортлох тохиолдолд Японы зах зээлийн 6-7%-ийг хангах бүрэн боломжтой.

**Үнээр өрсөлдөх стратеги**

2015 онд Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн гэрээний дагуу хоёр улсын хооронд худалдааны нэн таатай нөхцөл бүрэлдсэн нь бусад улс орнуудтай харьцуулахад гаалийн татвар тэг хувь болж байгаа нь "Монгол базальт" ХК-ийн бүтээгдэхүүн үнээр өрсөлдөх боломжийг бүрдүүлж байна. Европын чулуун хөвөнгийн үнэ өндөр ба Япон улсад импортлох эрдэст чулуун хөвөнгийн гаалийн татвар 23-25 хувь тул Монгол улсаас базальтан эрдэст чулуун хөвөнг экспортлох эерэг нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

**Байршлаар өрсөлдөх стратеги**

Манай Улсын газар зүйн байршил нь Япон улсад бараа экспортлох нөхцөлөөрөө Хятад улстай өрсөлдөх боломжтой бөгөөд БНХАУ–ын дарга Си Жиньпины айлчлалаар Тянжинь боомтыг оролцуулан 6 боомтод тээвэр ложистикийн хөнгөлөлттэй нөхцөл өгсөн нь бараа экспортлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Япон улс Европоос хамгийн ихээр импортолдог GRODAN брэндийн эрдэст чулуун хөвөн зах зээл дээр 1м$^2$ нь 20-30 ам.доллар (татвар ороогүй үнэ) байдаг бол Монгол улсаас BASALTWOOL® брэндийн эрдэст чулуун хөвөнг Япон Улсын зах зээлд 10-15 ам.доллараар нийлүүлэх боломжтой.

Үнэт цаас гаргагч нь Япон Улсын Марубени Интекс компанитай Хамтран ажиллах санамж бичгийг 2016 оны 2 сард байгуулсан бөгөөд Японы зах зээлд гаргах боломжит бүтээгдэхүүний судалгаа туршилтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүнийг түүхий эд болгон экспортолж автомашины тоормосны диск үйлдвэрлэх боломжтойг харуулсан байна. Харин Япон Улсад бүтээгдэхүүнээ түүхий эд болгон гаргахад Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийн шинэчлэлд хөрөнгө оруулалт хийж хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

| Японы дулаалгын материалын зах зээл | |
|---|---|
| **Давуу тал**<br>▪ Зах зээлийн хэмжээ том, хэрэглэгч олон<br>▪ Дулаалгын материал тэр дундаа базальтыг импортоор их хэмжээгээр авдаг<br>▪ Өндөр үнээр худалдан авах чадвартай | **Сул тал**<br>▪ Тээвэрлэлтийн зай хол<br>▪ Чанарын болон бусад төрлийн стандарт өндөртэй<br>▪ Өрсөлдөгч компаниуд олонтой<br>▪ Европоос чанартай бүтээгдэхүүн авч хэвшсэн |
| **Боломж**<br>▪ Чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой<br>▪ Зах зээл ихтэй тул нийлүүлэлт ихээр хийх боломжтой<br>▪ Японы худалдааны зуучлагч компанитай хамтарснаар борлуулалтад бус нийлүүлэлтэд анхаарлаа хандуулах боломжтой<br>▪ Базальт материалыг зөвхөн дулаалгаас бусад төрлийн зорилгоор нийлүүлэх боломжтой | **Аюул**<br>▪ Тээвэрлэлтэд удаашрал, хүндрэл гарах боломжтой<br>▪ Эдийн засгийн удаашралтай холбоотойгоор дулаалгын материалын зах зээл хумигдах магадлалтай<br>▪ Өрсөлдөгчид үнээр өрсөлдөх боломжтой |

*Хүснэгт 51 Японы дулаалгын материалын зах зээл*

### 1.2.3 Богино хугацааны бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь богино хугацааны бизнес төлөвлөгөөндөө чулуун хөвөн үйлдвэрлэлийг илүү боловсронгуй болгох, олон улсад экспортлоход чанарын шаардлага хангасан нарийн ширхэг бүхий хөвөн үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд компанид техник, технологийн шинэчлэл хийх шаардлагатай байгаа бөгөөд үүнд цахилгаан зуух, шүршдэг базальт технологийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, базальт карьерийн аж ахуйг хөгжүүлэх ажлууд багтаж байна. Эдгээр ажлуудад шаардлагатай хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 6.4 тэрбум төгрөг бөгөөд үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаа гаргаж энэхүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

| Хөрөнгө оруулалтын хэмжээ | | | |
|---|---|---|---|
| Д/д | Зориулалт | Дүн (төгрөг) | Хувь |
| 1 | Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл | 2,525,000,000 | 39.3% |
| 2 | Цахилгааны дэд станц | 1,100,000,000 | 17.1% |
| 3 | Үйлдвэрийн барилга | 680,000,000 | 10.6% |
| 4 | Үйлдвэрт ажиллах машин механизм | 330,000,000 | 5.1% |
| 5 | Базальт чулуу карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж | 490,976,700 | 7.6% |
| 6 | Базальт чулуу карьерийн аж ахуйн машин механизм | 210,000,000 | 3.3% |
| 7 | Түүхий эдийн нөөц | 599,013,800 | 9.3% |
| 8 | Эх үүсвэрийн эргэн төлөлт | 496,547,500 | 7.7% |
| **НИЙТ ДҮН** | | **6,431,538,000** | **100%** |

*Хүснэгт 52 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт*

Дээрх шинэчлэлийн үр дүнд бүтээгдэхүүний чанар сайжрах, үйлдвэрлэлийн чадавх нэмэгдэх хүчин зүйлс бүрдэх бөгөөд үйлдвэрийн гарцыг жилд 5,000 тонн байсныг 8,000 тонн хүртэл нэмэгдүүлэхээс гадна базальт чулууны бусад хэрэглээ болох дэд бүтэц, зам тээвэр, барилгын цутгамал суурьнд зориулсан бүтээгдэхүүнүүд бэлтгэх боломжтой болно. Мөн одоогийн үйлдвэр нь 50-125кг/м$^3$ нягттай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа бол шинэ үйлдвэр нь ашиглалтад орсноор 25-200кг/м$^3$ нягт бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой болох бөгөөд бүтээгдэхүүний төрөл мөн нэмэгдэх юм.

Уг шинэчлэлд шаардлагатай техник, технологийн шинэчлэл, цахилгаан зуух, шүршдэг базальт технологийн үйлдвэр, дэд цахилгаан станц, үйлдвэрт ажиллах машин механизм, базальт чулуу карьерийн тоног төхөөрөмж, машин механизмыг худалдаж авахаар төлөвлөсөн байгаа бөгөөд богино хугацаанд хийхээр төлөвлөж, татан төвлөрүүлэх хөрөнгийн 2,751,675,500 (хоёр тэрбум долоон зуун тавин нэгэн сая зургаан зуун далан таван мянга таван зуун) төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

| | Одоогийн үйлдвэр | Шинэчлэлийн дараа |
|---|---|---|
| **Хүчин чадал (жил)** | 5,000 тонн | 8,000 тонн |
| **Бүтээгдэхүүний нягт** | 50-125кг/м$^3$ | 30-175кг/м$^3$ |
| **Хаяг** | БГД-ийн 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Үйлдвэрийн тойруу-132, Чингисийн талбайгаас 8.3 км зайтай. | |

*Хүснэгт 53 Одоогийн болон шинэчил хийсэн үйлдвэрийн техникийн харьцуулсан үзүүлэлтүүд*

Компани үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж зах зээлийн тодорхой хэсгийг өөрийн үйлдвэрлэдэг өндөр чанартай, найдвартай бүтээгдэхүүнээр хангаснаар 2019 онд 3.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллах боломжтой гэж үзсэн байна. Мөн базальт чулуун орцтой холимог материалын түүхий эд бэлтгэж экспортод гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд Япон улсын Марубени компанитай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд өөрийн хувьцааг нээлттэй арилжаалах замаар татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй 6.4 тэрбум төгрөгийн хөрөнгө

оруулалтаас 2.5 тэрбум төгрөгийг чулуун хөвөн үйлдвэрийн өргөтгөл болон шинэчлэлд, 1.1 тэрбум төгрөгийг үйлдвэрийн өргөтгөлтэй холбоотой шаардлагатай цахилгааны дэд станцыг суурилуулахад, 680 сая төгрөгийг үйлдвэрийн барилгын шинэчлэл болон шинээр бэлэн бүтээгдэхүүний агуулах барих ажилд, 330 сая төгрөгийг үйлдвэрт ашиглах машин механизмын хөрөнгө оруулалтад, мөн 701 сая төгрөгийг базальт чулуун ордын карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж болон машин механизмын хөрөнгө оруулалтад зарцуулахаар төлөвлөөд байна. Үүнээс гадна 496.5 сая төгрөгийг урт хугацаат зээлийн эргэн төлөлтөд, 599 сая төгрөгийг үйлдвэрийн 4 сарын түүхий эдийн нөөц бэлтгэхэд зарцуулна.

Эдгээр хөрөнгө оруулалтын задаргаа болон дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Үнэт цаасны танилцуулгын Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт хэсгээс харж болно.

### 1.2.4 Дунд хугацааны бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь одоогоор дотоодын эрдэс чулуун хөвөн зах зээлийн 60 хувийг хангаж байгаа боловч дунд хугацаандаа Монголын нийт дулаалгын материалын зах зээлийн 30 хүртэлх хувийг ханган, цаашид бүтээгдэхүүнээ олон улсын тэр дундаа БНХАУ, ОХУ болон Япон Улсын зах зээлд хүргэн борлуулах зорилготой ажиллаж байна. Үүний хүрээнд Япон Улсын Марубени Интекс компанитай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж үнэт цаас гаргагчийн чулуун хөвөн бүтээгдэхүүнийг Япон Улсын зах зээлд таниулах, худалдааны суваг олж өгөх, зах зээлд бүтээгдэхүүн борлуулах мэдээлэл зэргээр хангахыг баталгаажуулсан бөгөөд бүтээгдэхүүнийхээ дээжийг Япон улсад илгээж шинжилгээ хийлгэж байна. Харин БНХАУ-н зах зээл дэх чулуун хөвөн бүтээгдэхүүнүүд нь үнээр харьцангуй хямд байдаг тул БНХАУ-н зах зээлд чанараар өрсөлдөх боломжтой. Үнэт цаас гаргагч нь Хятад улсын Бойси-хаусын технологи нэртэй компанитай 2017 оны 4 дүгээр сарын 11-нд 1,500,000 ам. долларын бүтээгдэхүүнийг Хятадын зах зээлд борлуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн ОХУ-д бүтээгдэхүүнээ борлуулах зорилгоор 2015 оны 8 дугаар сарын 25-нд ОХУ-н STU LLC компанитай МБ08252015 тоот 500 мянган ам.долларын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан бөгөөд энэ хүрээнд хамтран ажиллаж байна. Ингэснээр үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүнээ дээрх улсуудад нийлүүлж зах зээлийн тодорхой хувийг эзлэх боломж нээгдэнэ гэж үзэж байна. Үүнд:

- БНХАУ-н хойд болон зүүн хойд хэсгийн 1.2 сая $м^3$ эрдэс чулуун хөвөнгийн зах зээлийн 3%,
- ОХУ-н зүүн болон зүүн урд хэсэг буюу Сибирь хавийн 875 мянган тонн эрдэст чулуун хөвөнгийн зах зээлийн 5%,
- Япон Улсын зах зээлд базальт хөвөн болон мяндсан утас зэрэг бүтээгдэхүүнээ нийлүүлэх бололцоотой гэж тооцож байна.

**Евро Стандартын шинэ үйлдвэрийн төсөл**

Энэхүү дунд хугацааны зорилгод хүрэхийн тулд компани базальт хөвөнгийн шинэ үйлдвэрийг одоо байгаа үйлдвэрийн хажууд өөрийн эзэмшлийн газарт барихаар төсөл боловсруулаад байгаа бөгөөд “Евро Стандартын Эрчим хүч хэмнэгч BASALTWOOL Эрдэст Чулуун Хөвөнгийн Үйлдвэрийн ТЭЗҮ” судалгааг хийж гүйцэтгэээд байна. Уг ТЭЗҮ судалгаанд дурдсанаар шинэ үйлдвэрийн төсөл хэрэгжсэнээр компани нь БНХАУ-ын Синотеки компаниас дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц өндөр технологийн базальт чулуун хөвөнгийн үйлдвэрийн шугамын худалдан авч ашиглалтад оруулан одоогийн үйлдвэрийн гарцыг жилд 21,000 тонн хүртэл буюу 4 дахин нэмэгдүүлэх юм. Энэхүү шинэ үйлдвэрийг нэвтрүүлснээр бүтээгдэхүүний өртөг 30-40% буурч, нэр төрөл 5-аас 20 орчим болж нэмэгдэх юм. Энэ нь бүтээгдэхүүний үнийг 20-30% хямдруулах боломжийг олгож “Монгол базальт” ХК нь өөрийн базальт чулуун хөвөн бүтээгдэхүүнээрээ дэлхийд өрсөлдөх хангалттай хүчин чадалтай болох бөгөөд Монгол Улсын томоохон экспортлогчдын нэг болох боломжтой юм. Энэхүү төслийн нийт өртөг нь 26.8 тэрбум төгрөг байх тооцоотой байгаа бөгөөд уг төслийг 2019-2020 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Мөн энэхүү ажлын хүрээнд компани шинээр байгуулах эрдэс чулуун хөвөнгийн үйлдвэрийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2018-2025)-г "Газар Лха" ХХК-иар гүйцэтгүүлээд байна.









BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК



*Зураг 48 Шинэ Евро стандартын үйлдвэрийн зураг төсөл, харагдах байдал*







*Зураг 49 Шинэ Евро стандартын үйлдвэр барих газар*



*Зураг 50 Шинэ үйлдвэрийн байршлын төлөвлөлт*

## Зах зээлийн ирээдүйн боломж

“Монгол базальт” ХК нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүлэмжийн хийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж чадахуйц нийгэм, олон нийтийн хүртээх өгөөж өндөртэй салбарт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд үүнийг хөгжингүй болон хөгжиж буй аль ч улсын төр, олон нийтийн зүгээс дэмжиж байгаа нь урт хугацаанд үр ашигтай байх үндсэн хөрс суурь болж байна.

Компанийн дунд хугацаанд хэрэгжүүлэх шинэ үйлдвэрийн төслийн ТЭЗҮ судалгааны хүрээнд Монголын дулаалгын материалын зах зээлийн багтаамж 2014 онд 39 тэрбум, 2015 онд 50 орчим тэрбум төгрөг болж өссөнийг онцолсон байна. Эдийн засгийн өсөлт, хүн амын өсөлт, орлогын өсөлт, ипотекийн 8 хувийн зээлийн програм зэрэг нь орон сууц худалдан авах чадамжтай эрэлтийг дэмжиж байгаа нь дулаалгын материалын зах зээлийг нэмэгдүүлж иржээ. Цаашид гэр хорооллын дахин төлөвлөлт, төрийн орон сууцны корпорацын хэрэгжүүлж буй төслүүд, хувийн хэвшлийнхний барьж буй барилгын төслүүд болон амины орон сууцны дулаалга, угсармал орон сууцны дулаалга болон дулааны шугам хоолойн дулаалгын төсөл зэрэг нь ирэх жилүүдэд дулаалгын материалын эрэлтийг нэмэгдүүлэх юм. Ингэснээр галд шатахгүй экологийн цэвэр дулаалгын материалын хэрэглээ нэмэгдэхээс гадна Улаанбаатар хотын нэн тулгамдсан асуудал болоод байгаа агаарын бохирдлыг багасгахад дорвитой алхам болно гэж үзэж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаар баримтлах чиглэл, салбарын хөгжлийн төлөө төлөвлөсөн болон хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдэд барилга, барилгын материалын салбарыг хөгжүүлэх, экологид ээлтэй технологи ашиглах, хэрэглэгчдийн эрүүл, аюулгүй амьдрах баталгааг бий болгоход чиглэсэн, импортыг орлох бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрүүдийг дэмжих үзэл баримтлал орсон нь “Монгол базальт” компанийн үйл ажиллагааг явуулах макро болон микро орчинг төрийн бодлогын хүрээнд дэмжиж байгаагийн илрэл болж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлаар 2016 оны 11 сард батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хоёрдугаар хэсэгт Дунд хугацаанд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, тогтвортой өсөлтийг хангах, өрийн дарамтыг багасгах гэсний 2.1.6-д Импортыг орлох барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих гэсэн хэсэг байгаа нь компанийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх боломжтой юм.

**Монгол Улсын Засгийн Газрын дэмжлэг**

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт засгийн газрын зүгээс олон жил үйл ажиллагаа явуулж буй үндэсний үйлдвэрлэл, тэр дундаа эдийн засгийн үр өгөөж өндөр, дулаалгын алдагдлыг бууруулдаг, галд тэсвэртэй барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих тухай заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар болон төрийн оролцоотой байгууллагуудын барилга угсралтын ажилд дотоодын бэлтгэн нийлүүлэгчийг дэмжиж ажиллах бодлого баримталж байгаа нь Монголын цорын ганц эрдэст чулуун хөвөн үйлдвэрлэгч “Монгол базальт” компанид таатай нөхцөл үүсэж байна. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд томоохон барилгын гал түймэрт шилэн хөвөн болон хөөсөнцөр дулаалга ашигласны нөлөө давамгайлж байгаа нь хэрэглэгчид галын аюулд тэсвэртэй, эрүүл, ухаалаг хэрэглээг сонгох хандлагатай болж байна.

Дотоодын үйлдвэрлэгчид экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрийн бүтээн байгуулалт хийн эдийн засгийн өсөлтийг дэмжих гэж буйтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн Газар 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Засгийн газрын 76 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр”-н хүрээнд УИХ-н 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 10.7-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор нэр бүхий хэд хэдэн компанид Монгол Улсын Хөгжлийн банкнаас зээл олгох, мөн гадаадын даатгалын байгууллагаас тухайн нэр бүхий компаниудыг экспортын зээл авах зэрэг үйл ажиллагааг дэмжин ажиллахыг Сангийн сайд Б. Болор, Аж үйлдвэрийн сайд Д. Эрдэнэбат, Хөгжлийн банкны ТУЗ-д тус тус даалгасан бөгөөд эдгээр компаниудын нэгт “Монгол базальт” ХК орж байгаа юм.

Мөн Улаанбаатар хот “Дулаан техникийн шинэчлэл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд:

- Угсармал орон сууц, олон нийтийн барилга, амины орон сууц, зуслангийн сууц, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулах
- Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийгдсэн барилга байгууламж, шугам сүлжээг дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулах юм.

Үнэт цаас гаргагч нь угсармал орон сууц, амины орон сууцны төслийн хүрээнд хэд хэдэн судалгаа шинжилгээг гүйцэтгээд байгаа ба цаашид уг салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлэх бүрэн боломжтой болоод байна.

## 1.3 БИЗНЕСИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Үнэт цаас гаргагч нь базальт чулуун хөвөнгийн үйлдвэрлэл эрхлэн явуулахад дараах эрсдэлүүд тулгарч болно. Үүнд:




### 1.3.1 Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь үүсэж болох эрсдэлийг дараах байдлаар удирдан ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

| | Эрсдэлийн төрөл | Үүсэх үр дүн | Эрсдэлийн удирдлага |
|---|---|---|---|
| Гадаад | Улс төр, хууль эрх зүй | • Барилгын тухай хуульд гэнэтийн өөрчлөлт гарч үйлдвэрлэлд хориг саад тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх<br>• Дулаалгын стандарт нормд өөрчлөлт орж чулуун хөвөнг ашиглахыг хориглох<br>• Гэнэтийн ажил хаялт, улс орны хэмжээнд онцгой дэглэм тогтоох, үймээн самуун гарч эмх замбараагүй байдал бий болох | • Чулуун хөвөнгийн давуу талыг олон нийтэд танилцуулж, экологид ээрэг бүтээгдэхүүн болохыг нь нотлон харуулах.<br>• Үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх дээр хяналт тавих<br>• Хуулийн шинэчлэлийг үйл ажиллагаандаа цаг тухайд нь хэрэгжүүлж ажиллах<br>• Дотоод аудит, хяналтыг тогтмол тавих |
| | Эдийн засаг | • Эдийн засгийн өсөлт саарах<br>• Ханш хэлбэлзэх | • Эдийн засгийн байдалтай уялдсан бизнес төлөвлөгөөг боловсруулах<br>• Ханшийн хэлбэлзлээс сэргийлсэн фьючирс, хэджинг хэрэгсэл ашиглах<br>• Барилгын төрөл бүрийн үйлдвэрлэлд зохицсон бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, амьжиргааны бүх төвшинд тохирсон бизнесийг хөгжүүлэх |
| | Байгалийн гамшиг | • Үер, түймэр, газар хөдлөлт, зуд г.м. | • Компанийн үндсэн хөрөнгийг даатгуулах замаар эрсдэлийг шилжүүлэх |

| | | | |
|---|---|---|---|
| Дотоод | Үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл | • Үйлдвэрийн тоног, төхөөрөмжийг зориулалтын бусаар ашиглах, эсвэл буруу ашигласнаас үүдэн эвдрэл гэмтэл гарах, | • Үйлдвэрийн тоног, төхөөрөмжид цаг тухайд нь засвар үйлчилгээг хийж, хүний нөөцийн мэдлэгийг чадавхжуулснаар уг эрсдэлээс сэргийлэх боломжтой. |
| | Хүний нөөц | • Ажиллах хүч болон хүний нөөцийн асуудлаас болж хэвийн үйл ажиллагааны горим алдагдах<br>• Үйлчилгээний соёл, чанар буурах, ажлын байрны норм, норматив зөрчигдөх | • Найдвартай хүний нөөц, ажиллах хүчтэй байх: Ажилтан чөлөө авсан, ээлжийн амралттай, болон өвчтэй үед орлох боловсон хүчин бэлдэх.<br>• Ажлын байрны тодорхойлолт, стандарт, нормыг сайтар боловсруулах |
| | Санхүү | • Орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх<br>• Бүтээгдэхүүн боловсруулах явцад тооцоолоогүй зардал үүсэх<br>• Валютын ханш хэлбэлзэх | • Валютын зах зээл дээрх хэлбэлзлээс зайлсхийх арга хэрэгслийг ашиглах буюу энэхүү эрсдэлийг шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах |
| | Бүтээгдэхүүний борлуулалттай | • Зах зээл дээр гарч болох хүчин зүйлсээс хамаарч бүтээгдэхүүний эрэлт буурах, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнд мөнгөө түгжих | • Бүтээгдэхүүний давуу тал болон чанарыг сурталчилж, тогтвортой маркетинг хийснээр бүтээгдэхүүнийг борлуулах боломжтой<br>• Найдвартай, тасралтгүй үйл ажиллагаа явуулах бэлэн мөнгөний эх үүсвэрээ сайтар хангах |
| | Өрсөлдөгчийн эрсдэл | • Үнийн өрсөлдөөн бий болж бүтээгдэхүүний үнэ хямдрах<br>• Чанарын өрсөлдөөн бий болж давуу чанартай бүтээгдэхүүн зах зээлд бий болох | • Компани нь шинэ тоног төхөөрөмж, цахилгаан зуух суурилуулснаар бүтээгдэхүүний өртгийг багасгах боломжтой болох бөгөөд улмаар үнийн өрсөлдөөнд өрсөлдөх чадвараа хадгалах юм.<br>• Импортын бүтээгдэхүүний хувьд үнэд нөлөөлдөг гол зүйлс нь валютын ханш, гаалийн татварын өсөлт, тээврийн зардал зэрэг нөлөөлдөг бөгөөд импортын бүтээгдэхүүний үнийг өсгөж байна. |

*Хүснэгт 54 Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө*

### 1.3.2 Хөрөнгө оруулалтад харгалзах нөхцөл ба эрсдэлийн хүчин зүйл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй барилгын материалын салбар болон үйлдвэрийн шинэчлэлд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах тул гадаад эрсдэл гарах магадлал их юм.

**Төрийн бодлого, улс төрийн нөхцөл байдалтай холбоотой үүсэх эрсдэл**

Монголын төрийн зүгээс барилгын салбарт баримталж байгаа бодлого сүүлийн жилүүдэд ард түмнийг орон сууцаар хангах, гэр хорооллыг барилгажуулах зэрэг барилгын салбарт ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Улс төрийн аль нэг нам хүчин төрийн эрхийг барьсан ч гэсэн цаашдаа иргэдийг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх төлөвтэй байгаа нь энэ салбарыг тэр дундаа дулаалгын найдвартай, чанартай материалыг барилгын салбарт нийлүүлэх үйл явцад дөхөм өгөхөөр төлөвтэй байна. Иймд улс төрөөс хамаарсан эрсдэл энэ салбарт харьцангуй бага юм.

**Бизнесийн салбар, эдийн засгийн эрсдэл**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд макро болон микро эдийн засгийн тогтворгүй байдал, хямрал сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд эдийн засагт дараах нөхцөл байдал үүсэх нь компанид болон түүний худалдан авагчдын хувьд хүндрэлтэй байдлыг бий болгох эрсдэл дагуулна. Үүнд:

- Төсөв, мөнгөний бодлого чангарах
- Валютын ханшийн тогтворгүй байдал
- Үнийн өсөлт, инфляц нэмэгдэх
- Ажилгүйдлийн төвшин нэмэгдэх
- Түүхий эдийн үнэ ханш өсөх, нийлүүлэлт багасгах

Хэдийгээр дээрх хүчин зүйлсийн эрсдэл байгаа боловч зарим тохиолдолд эерэг нөлөө бас байх боломжтой. Тухайлбал, валютын ханшийн өсөлтөөс үүдэн импортоор орж ирж буй өрсөлдөгч бүтээгдэхүүний үнэ нь өндөр болж, дотоодод үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн үнийн хувьд давуу талтай болдог. Мөн ажилгүйдэл, инцляцийн өсөлтийн эсрэг чиглэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогуудыг авч хэрэгжүүлэх нь бизнесийн боломжийг нэмэгдүүлдэг.

**Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл**

Чулуун хөвөнгийн нарийн технологийг ашиглаж буй үйлдвэрлэл нь мэргэшсэн боловсон хүчин, технологийн нарийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал зэргийг өндөр төвшинд шаарддаг бөгөөд аюулгүй ажиллагааны дүрэм журмууд, тэдгээрийн хэрэгжилтээс компанийн хэвийн ажиллагаа ихээхэн шалтгаалдаг. Компанийн хувьд үйлдвэрлэлийн явцаас гадна бүтээгдэхүүнээ харилцагчдад борлуулсны дараа чанарын шаардлага хангасан эсэхэд өндөр хариуцлага хүлээдэг. Тухайлбал, үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүн Монгол Улсын болон олон Улсын стандартад нийцэж буй эсэх дээр байнга хяналт шалгалт хийн, хэрэглэгчдийн захиалсан бүтээгдэхүүн тэдний гар дээр очиж буй эсэхийг хянан ажилладаг. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, барилгын технологийн зөв шийдэл, ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн чанар зэрэг нь чухал ач холбогдолтой. Тиймээс, технологийн шийдэл болон тоног төхөөрөмжийн чанараас шалтгаалан үйл ажиллагаанд эрсдэл үүсэх боломжтой.

Компанийн менежмент, зохион байгуулалтын буруу хэв загвар нь дотоод эрсдэлийг бий болгодог. Иймд үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааныхаа онцлогт зохицсон зөв менежментийн бодлогыг боловсруулан, үйл ажиллагааны доголдол үүсгэхгүйн тулд тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ажилтны хариуцлага, үйл ажиллагаанд шаардагдах стандарт, цогц дүрэм, журмуудаа тогтмол сайжруулан, хариуцлагатайгаар мөрдөн ажиллах нь чухал.

**Компанийн удирдлага, засаглалаас шалтгаалах эрсдэл**

Компанийн гүйцэтгэх удирдлагын бодлого шийдвэр, менежментийн хэв маяг нь бизнесийн ашиг, маркетинг, хүний нөөцийн бодлого, нийгмийн хариуцлага гэх мэт компанийн бүх үйл ажиллагаа, нэр хүндийг тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагын хооронд эрх ашиг, сонирхлын зөрчил үүсэх асуудал ч байдаг. Тиймээс, гүйцэтгэх удирдлагын туршлагын байдал, багийн буруу бодлого, алдаатай шийдвэрээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх эрсдэл байхыг үгүйсгэхгүй. Түүнчлэн, компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид нэгж хувьцаанд ногдох саналын эрхийн дагуу аливаа бодлого шийдвэр гаргахад давамгайлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөх эрсдэл байдаг. Компанийн сайн засаглал, соёлыг зөв бүрдүүлэх, хувьцааны төвлөрлийг бууруулах, хууль журмын дагуу ажиллахыг шаардах, хяналт тавихад хувьцаа эзэмшигчид идэвхтэй оролцож, эрхээ хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Мөн гүйцэтгэх удирдлага, тэр дундаа шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, ажлын зохион байгуулалтыг компанийн дүрэм, журамд тодорхой тусгаж, гишүүдийг Компанийн засаглалын сургалтад суулгах зэргээр компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх нь энэ төрлийн эрсдэлийг зөв удирдахад чухал ач холбогдолтой.

## Өрсөлдөгчидтэй холбоотой эрсдэл

“Монгол базальт” компани нь одоогийн байдлаар Монголд үйл ажиллагаа явуулж буй цорын ганц чулуун хөвөнгийн компани боловч чулуун хөвөнгийн зах зээл нь техник технологи, боловсон хүчин, чулуун ордын нөөц болон эхний хөрөнгө оруулалт ихээр шаарддаг салбар тул дотоодын өрсөлдөгчид гарч ирэх магадлал харьцангуй бага боловч уг салбарын өсөх ирээдүй зэрэг нь боломжит өрсөлдөгчдөд тааламжтай харагдах нь зайлшгүй тул зах зээл хуваах эрсдэл өндөртэй. ОХУ, БНХАУ зэрэг томоохон улс орнуудын үйлдвэрлэгчид чулуун хөвөнгийн зах зээлд харьцангуй хямд үнэтэй бүтээгдэхүүн нийлүүлэх замаар өрсөлдөх боломжтой юм.

Мөн дулаалгын материалын зах зээлийн гол өрсөлдөгчид нь дотоодод энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй сендвичин хавтан үйлдвэрлэгчид болон дулаалгын хөөсөнцөр хавтан үйлдвэрлэгчид юм. Одоогийн байдлаар Монгол улсад хөөсөнцрийн 50 гаруй үйлдвэр, сендвичин хавтангийн 10 орчим үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бол шилэн хөвөн үйлдвэрлэдэг нэг ч үйлдвэр байхгүй бүгдийг импортоор авч байна.

## Санхүүгийн эрсдэл

Санхүүгийн эрсдэлд төслийн санхүүжилтийн мөнгөн урсгал, гадаад валютын ханшийн хэлбэлзэл, тоног төхөөрөмж болон ажил үйлчилгээний үнийн хэлбэлзэл, мэдээллийн технологийн үйлчилгээний үнийн хэлбэлзэл, цаг хугацаатай холбоотой компанийн ашигт ажиллагаанд нөлөөлж болох аливаа эрсдэл орно. Тухайлбал, анхдагч зах зээлд хувьцаа гаргах ажиллагаа нь эдийн засгийн болон зах зээлийн хүндрэлтэй байдлаас хамаарч цаг хугацаандаа амжихгүй, хөрөнгө оруулалтаа бүрэн татаж чадахгүй байх эрсдэл үүсэж болно. Түүнчлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг нэмэгдэх, компанийн борлуулалт буурах, хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудах зэрэг нь санхүүгийн эргэлтийг багасгах эрсдэлтэй.

| Эрсдэлийн төрөл | Эрсдэлийн түвшин | Эрсдэлийн магадлал | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ |
|---|---|---|---|
| Санхүүжилтийн эрсдэл | Өндөр | Дунд | Анхдагч зах зээлийн арилжаа төлөвлөсний дагуу хэрэгжээгүйгээс үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө дутах, үйл явц удаашрах, эсвэл амжилтгүй болох гэх мэт санхүүжилтийн эрсдэл тулгарч болно. Үүнийг урьдчилан тооцоолж, санхүүжилтийн хуваарь, үе шатыг нарийн төлөвлөж, хувилбаруудыг гаргах хэрэгтэй.<br>Мөн Үнэт цаас гаргагч нь тоног төхөөрөмж худалдан авах явцад гадаад худалдааны санхүүжилтийн эрсдэл үүсэх магадлалтай. Тиймээс банкны гадаад худалдааны сувгуудыг ашиглах нь эрсдэлийг бууруулах хүчин зүйл болох юм. |
| Тоног төхөөрөмжийн үнийн өсөлт | Дунд | Бага | Үнэт цаас гаргагчийн авахаар тогтсон шинэ тоног төхөөрөмжийн үнэ валютын ханштай холбоотойгоор өсөх магадлалтай. |
| Ажил, үйлчилгээний үнийн өсөлт | Бага | Бага | Үнэт цаас гаргагч нь барилгын үйлдвэрийн барилгыг харьцангуй энгийн хийцтэйгээр богино хугацаанд барихаар төлөвлөж байгаа нь барилгын ажил үйлчилгээний үнийн өсөлтийн эрсдэлийг бууруулж байна. |
| Гадаад валютын ханшийн өсөлт | Өндөр | Өндөр | АНУ-н эдийн засгийн байдал, Холбооны нөөцийн бодлого, Монгол Улсын эдийн засгийн байдал, гадаад валютын нөөцтэй холбоотойгоор ам.долларын ханш тогтворгүй байх боломжтой тул ханшийн өсөлтийг урьдчилан таамаглаж, зохих валютаар хөрвүүлэн, төлбөр төлөгдөх хүртэл хадгалах нь эрсдэлийг бууруулах нэг алхам юм. |
| Татварын өөрчлөлт | Бага | Бага | Эдийн засгийн байдалтай холбоотойгоор аж ахуйн нэгжүүдийн орлого буурч байгаа тохиолдолд татвар нэмэгдэх магадлал тун бага юм. |
| Цаг хугацааны эрсдэл | Бага | Бага | Санхүүжилт хуваариас хоцрох, гүйлгээ саатах гэх мэт төлөвлөгөөт орлого орж ирэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах үүднээс худалдан авалтын хуваарийг оновчтой гаргах, хөрөнгө оруулагчдад танилцуулах. |

*Хүснэгт 55 Эрсдэлийн тооцоолол*

## Хүний нөөцтэй холбоотой эрсдэл

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад ганцхан байдаг гэдэг утгаараа хүний нөөцийн хувьд харьцангуй тогтвортой ба нийт ажилчдын ихэнх хувь нь мэргэшсэн ажилчид байдаг тул тухайн хүмүүсийн ажлаа

орхих магадлал харьцангуй бага юм. Мөн компанийн ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд сурган, мэргэшүүлэх нь чухал ач холбогдолтой. Үйл ажиллагаанд шаардагдах мэргэжилтнүүдийг бэлтгэж, хүний нөөцийн цогц бодлого боловсруулж ажиллах шаардлагатай бөгөөд үйлдвэрийн инженер, үйлдвэрийн ахлах зэрэг мэргэжил маш чухал үүрэгтэй.

Үйл ажиллагаанд бүх төвшний ажилтнуудад тогтвортой ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж чадсан байх нь үйл ажиллагааны зардлыг хэмнэх болон бүтээмж өндөртэй ажиллах үндсэн нөхцөл болдог. Чадварлаг мэргэжилтнүүддээ урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлсэн таатай ажлын байрыг бүрдүүлж, хүний нөөцийн зөв бодлого явуулж, улмаар ажилдаа хариуцлагатай хандахад чиглэгдсэн хариуцлагын тогтолцоог нэвтрүүлж, түүнийг тусгасан урт хугацааны хөдөлмөрийн гэрээг байгуулах нь чухал юм. Үнэт цаас гаргагчийн хувьд Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дотоод дүрэм, журмуудыг боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.

**Үнэт цаасны зах зээлтэй холбогдон үүсч болох эрсдэл**

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой эрсдэлд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжүүлэлт, зах зээл дээрх хувьцааны үнийн өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүдийг дурдаж болно. Үүнд, зах зээлд гаргасан хувьцааны үнийн хэлбэлзэл, арилжааны идэвх, хөрвөх чадвар муу байх асуудлууд орно. Хувьцааны ханшийн өсөлт, бууралт нь хөрөнгө оруулагчдад таатай болон таагүй нөхцөл байдлыг үүсгэж байдаг.

Нээлттэй хувьцаат компани болсноор үнэт цаасны зах зээлтэй холбоотой олон тооны дүрэм, журмуудыг мөрдөж, шаардлагатай шимтгэл хураамжийг төлөх, тайлан мэдээллийг олон нийтэд хүргэж байх хэрэгтэй болно. Энэ бүхнийг хуулиар заасан хугацаанд амжихгүй байх эрсдэл гарч болох энэ асуудлыг хариуцсан тусгай ажилтан томилж, ажлын төлөвлөлтөд тусгаж өгснөөр шийдвэрлэж болно.

**Өрсөлдөгчийн эрсдэл**

Зах зээлд шинээр өрсөлдөгч гарч ирэх, импортын бүтээгдэхүүн борлуулагч талууд нэмэгдэх зэрэг хүчин зүйлс нь компанийн шууд өрсөлдөөнийг бий болгох юм. Чулуун хөвөн үйлдвэрлэлийн зах зээл нь хэдийгээр капитал ихээр шаарддаг үйлдвэрлэл боловч бүтээгдэхүүнийг орлуулагч дулаалгын хэрэгсэл болох хөөсөнцөр дулаалгын зах зээл тэр дундаа галд тэсвэртэй хөөсөнцөр үйлдвэрлэгчид нэмэгдэх боломжтой юм.

Мөн дотоодын дулаалгын материал үйлдвэрлэгчид үнээр өрсөлдөх боломжтой бөгөөд компани тэр бүхэнд бэлтгэлтэй байх нь цаашид өрсөлдөгчийн эрсдэлийг бууруулах нөхцөл болох юм.

# БҮЛЭГ 2

## ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ









# БҮЛЭГ 2 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 2.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн "Бүртгэлийн журам" болон "Анхдагч зах зээлийн арилжааны журам", Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн "Үнэт цаасны тооцооны үйл ажиллагааны журам"-д тус тус үндэслэн үнэт цаасаа олон нийтэд анх удаа санал болгож байна.

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | **"Монгол Базальт" хаалттай ХК** |
| **Үнэт цаасны төрөл** | Энгийн хувьцаа |
| **Үнэт цаасны арилжаа** | Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй хүрээнд санал болгох |
| **ҮЦТХТ-д бүртгэлтэй нийт гаргасан хувьцааны тоо** | 39,491,900 ширхэг |
| **Нэрлэсэн үнэ** | 100 төгрөг |
| **Олон нийтэд санал болгох хувьцааны тоо** | 16,925,100 ширхэг |
| **Олон нийтэд санал болгож буй хувь** | 30.0% |
| **Олон нийтэд санал болгох хувьцааны худалдах үнэ** | 380 төгрөг |
| **Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ** | 6,431,538,000 төгрөг |
| **Олон нийтэд санал болгон худалдсны дараах нийт хувьцааны тоо** | 56,417,000 ширхэг |
| **Олон нийтэд санал болгон худалдсны дараах хувь нийлүүлсэн хөрөнгө** | 5,641,700,000 төгрөг |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт** | Үйлдвэрийн хүчин чадал болон бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх зорилгоор шинэчлэл хийх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, эх үүсвэрийн өртөг бууруулах |
| **Олон нийтэд санал болгох арга хэлбэр** | Тогтоосон үнийн аргаар олон нийтэд нээлттэй санал болгон худалдана |
| **Андеррайтер** | "Бумбат Алтай ҮЦК" ХХК |
| **Туслах андеррайтер** | "Гаули ҮЦК" ХХК, "Стандарт инвестмент ҮЦК" ХХК |
| **Төлбөр, тооцоо** | "Арилжааны Төлбөр Тооцоо" ХХК |
| **Үнэт цаасны хадгаламж** | "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК |
| **Арилжаалах зах зээл** | "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК |

### Үнэт цаас гаргах тухай шийдвэр

Үнэт цаас гаргагч нь Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн 2017 оны 3 сарын 28-ны өдрийн 01/748 дугаар тогтоолын дагуу Хаалттай хувьцаат компани болон бүртгэгдсэн. Компанийн тухай хуулийн 31, 32, 33, 62 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн 5, 6, 7 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 2 сарын 19-ний өдрийн 2/19-18 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэмж хувьцаа гаргаж байгаа бөгөөд хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж олон нийтэд санал болгох замаар Нээлттэй хувьцаат компани болж байгаа болно. Компанид нэмэлт санхүүжилт татах зорилгоор нэмж гаргаж буй 16,925,100 ширхэг энгийн хувьцааг нэгж бүр нь 380 төгрөгөөр тогтоосон үнийн аргаар олон нийтэд нээлттэй санал болгон худалдана.

### Нэмэлт хувьцаа гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компани нэмэлт хувьцаа гаргаснаар одоогийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь нь бүгд ижил 30%-иар буурах ба энэхүү өөрчлөлтийг доорх хүснэгтээр харуулав.

| | Хувьцаа эзэмшигчийн нэр | Нэмэлт хувьцаа гаргахаас өмнө | | Нэмэлт хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|---|
| | | Хувьцааны тоо | Эзлэх хувь | Хувьцааны тоо | Эзлэх хувь |
| 1 | Л. Ариунболд | 20,140,869 | 51.0% | 20,140,869 | 35.7% |
| 2 | П. Сайнбилэг | 7,503,461 | 19.0% | 7,503,461 | 13.3% |
| 3 | А. Энхгэрэл | 3,949,190 | 10.0% | 3,949,190 | 7.0% |
| 4 | А. Энхмаа | 3,949,190 | 10.0% | 3,949,190 | 7.0% |
| 5 | А. Энхжин | 3,949,190 | 10.0% | 3,949,190 | 7.0% |
| 6 | Олон нийт (IPO) | - | - | 16,925,100 | 30.0% |
| | **Нийт** | **39,491,900** | **100%** | **56,417,000** | **100%** |

*Хүснэгт 56 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц*

### 2.1.1 Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас гаргагч компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах ЭРХҮҮДИЙГ ЭДЭЛНЭ. Үүнд:

- Бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дагуу эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу компанийн нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эерэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:
  - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх
  - Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх
  - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг батлах
  - Хувьцаа эзэмшигч дангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй

- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:
  - Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах
  - Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах
  - Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна.
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх
- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах
- Хувьцаа эзэмшигч нь доорх үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороо болон шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй. Үүнд:
  - Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй тохиолдолд гомдол гаргах
  - ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг албан тушаалтнаар компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
  - Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
  - Компанийн энгийн хувьцааны эзэмшигч нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх

### 2.1.2 Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

Компанийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх
- Энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх
- Компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах
- Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр мэдэгдэх
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.
- Компанийн хувьцааг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч нь өөрийн эзэмшлийн үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс, эсхүл компанийн хувьцааны тав буюу түүнээс дээш багц болон хяналтын багцыг хамтран эзэмших болсноос хойш ажлын 3 өдрийн дотор компанид бичгээр мэдэгдэх
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг

## 2.2 ҮНЭТ ЦААСНЫ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 сарын 19-ний өдрийн 2/19-18 тоот тогтоолоор анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгох хувьцааны нэгж бүрийн үнийг 380 төгрөг байхаар тогтоосон. Хувьцааны энэхүү үнэлгээ нь Үнэт цаас гаргагчийн "Мөнх Оргил Трейд" ХХК-р гүйцэтгүүлсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үр дүнд үндэслэн шинээр үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч болох хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлөөр санал болгож аль болох олон хөрөнгө оруулагчийг компанид хувь эзэмшүүлэх үүднээс хямдруулсан үнээр тогтоосон болно.

### 2.2.1 Бизнесийн үнэлгээний үр дүн

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК-тай байгуулсан "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний гэрээ"-ний дагуу компанийн бизнесийн үнэлгээг 2018 оны 03 сарын 09-ний өдрийн байдлаар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд энэхүү үнэлгээний тайланд үнэт цаас гаргагчийн эзэмшигчийн өмчийн үнэ цэнийг 25,241,942,104.9 төгрөг буюу нэгж хувьцааны үнэ 639 төгрөг гэж тодорхойлсон байна.

Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээнд Олон улсын үнэлгээний стандарт 200 болон Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-д дурдсан үнэлгээний 3 хандлагаас Мөнгөн урсгалыг хорогдуулах арга (discounted cash flow method) - ОУҮС-200-гийн Т22-Т30 аргыг хэрэглэж, эцэслэсэн дүгнэлтийг гаргасан болно.

Энэхүү аргад тулгуурласан үнэлгээ нь "компанийн өнөөгийн үнэ цэнэ нь хөрөнгийг ашигласнаас ирээдүйд гарах үр дүнгийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцэнэ" гэсэн гол урдач нөхцөл дээр тулгуурлана. Өөрөөр хэлбэл, компанийг худалдан авахад оруулах хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагчийн ирээдүйд олох мөнгөний өнөөгийн үнэ цэнэтэй тэнцэхийг хэлнэ.

Компанийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн шинэчлэл болон өргөтгөлд зарцуулж, компанийн бизнес төлөвлөгөөний дагуу бүтээгдэхүүнээ гадаад улсын зах зээлд гаргасны үр дүнд бий болох ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын таамаглалд суурилан гаргасан болно.

Цэвэр мөнгөн урсгалын тооцоолол:

| EBIT | Татвар болон хүү төлөхийн өмнөх ашиг |
|---|---|
| хасах | Ашгийн татвар |
| нэмэх | Элэгдлийн шимтгэл |
| нэмэх (хасах) | Цэвэр эргэлтийн хөрөнгийн багасалт (ихсэлт) |
| нэмэх (хасах) | Хөрөнгийн худалдаа (хөрөнгө оруулалт) |
| Дүн | Нийт хөрөнгийн цэвэр мөнгөн урсгал |

Дээрх тооцоололд ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг компанийн урт хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэн гаргасан бөгөөд уг төсөөлөлд компанийн тоног төхөөрөмжийн шинэчлэл 2018 онд ашиглалтад орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал өсөх ба бүтээгдэхүүний нэр төрөл, чанар нэмэгдэнэ гэж төсөөлсөн. Улмаар компанийн төлөвлөгөөний дагуу дотоодын борлуулалтаа нэмэгдүүлж Монголын барилгын дулаалгын материалын зах зээлд эзлэх хувиа өсгөхөөс гадна Япон, Хятад, Орос улсууд руу бүтээгдэхүүнээ экспортлохоор тооцоолсон бөгөөд ингэснээр борлуулалт 2022 онд 14.8 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 5.0 тэрбум төгрөг хүртэл өсөх боломжтой гэж төсөөлөв.

Цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох үнэлгээ нь ирээдүйн мөнгөн урсгалыг хэрхэн тооцох, хорогдуулах (дискаунтын) хувийг оновчтой сонгохоос шалтгаална. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээнд хорогдуулах хувийг "хөрөнгийн эх үүсвэрийн жигнэсэн дундаж"-ийн аргаар тооцоолсон бөгөөд хорогдуулах хувь нь 21% байв.

Ийнхүү Цэвэр мөнгөн урсгалын тооцоолол болон "мөнгөн урсгалыг хорогдуулах арга"-ын үнэлгээг "Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга"-ын үнэлгээний "Үе тутмын хорогдуулах хувиуд ялгаатай байх үеийн өнөөгийн үнэ, цэнийг тооцоолох 2 үет загвар" буюу

$$PV_{EQUITY} = \sum_{t=1}^{n} FFCF_t \cdot \prod_{t=1}^{n} \left( \frac{1}{1+R_t} \right) + TerVal_n \cdot \prod_{t=1}^{n} \left( \frac{1}{1+R_t} \right)$$

томьёгоор тооцоолоход ирээдүйн цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар үнэлсэн үнэт цаас гаргагчийн үнэлгээ нь **25,241,942,104.9 төгрөг** гэж тодорхойлогдсон бөгөөд үүнийг нийт гаргасан 39,491,900 ширхэг хувьцаанд хуваахад нэгж хувьцааны зах зээлийн үнэлгээ **639 төгрөг** болж байна.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээнд Олон улсын үнэлгээний стандарт 200-д заасан үнэлгээний бусад арагчлалийг ашиглаагүй бөгөөд, Хөрөнгөнд суурилсан үнэлгээний аргыг хэрэглэхэд ирээдүйн хөрөнгө оруулалтыг тооцоололд оруулах боломжгүй, Зах зээлийн харьцуулалтын аргыг хэрэглэхэд Монгол Улсад үнэт цаас гаргагчтай ижил төстэй бизнес байхгүй тул ашиглах боломжгүй байв.

Мөн компани нь одоогийн байдлаар хаалттай, хувьцаат компанийн (ХК) хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэхүү бизнесийн үнэлгээгээр тодорхойлогдсон үнэ цэнэ нь тодорхой багц хувьцааны үнэ цэнэ биш компанийн нийт үнэ, цэнэ тул хяналтгүйн хорогдуулгыг хийх шаардлагагүй болно. Түс компани нь одоогийн байдлаар хувьцаагаа нээлттэй арилжаалаагүй байгаа боловч хаалттай хувьцаат компани хэлбэрээр байгаа тул хөрвөх чадваргүйн хорогдуулгыг үнэлгээнд хийгээгүй болно.

### 2.2.2 Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны буюу 2018-2020 оны бизнес төлөвлөгөөндөө чулуун хөвөн үйлдвэрлэлийг илүү боловсронгуй болгох, олон улсад экспортлоход чанарын шаардлага хангасан нарийн ширхэг бүхий хөвөн үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд компанид техник, технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үүнд цахилгаан зуух, шүршдэг базальт технологийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, базальт карьерийн аж ахуйг хөгжүүлэх ажлууд багтаж байна. Эдгээр ажлуудад шаардлагатай хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь 6.4 тэрбум төгрөг бөгөөд үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаа гаргаж энэхүү хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

| Хөрөнгө оруулалтын хэмжээ | | | |
|---|---|---|---|
| Д/д | Зориулалт | Дүн (төгрөг) | Хувь |
| 1 | Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл | 2,525,000,000 | 39.3% |
| 2 | Цахилгааны дэд станц | 1,100,000,000 | 17.1% |
| 3 | Үйлдвэрийн барилга | 680,000,000 | 10.6% |
| 4 | Үйлдвэрт ажиллах машин механизм | 330,000,000 | 5.1% |
| 5 | Базальт чулуу карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж | 490,976,700 | 7.6% |
| 6 | Базальт чулуу карьерийн аж ахуйн машин механизм | 210,000,000 | 3.3% |
| 7 | Түүхий эдийн нөөц | 599,013,800 | 9.3% |
| 8 | Эх үүсвэрийн эргэн төлөлт | 496,547,500 | 7.7% |
| | **НИЙТ ДҮН** | **6,431,538,000** | **100%** |

*Хүснэгт 57 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт*

Дээрх шинэчлэлийн үр дүнд бүтээгдэхүүний чанар сайжрах, үйлдвэрлэлийн чадавх нэмэгдэх хүчин зүйлс бүрдэх бөгөөд үйлдвэрийн гарцыг жилд 5,000 тонн байсныг 8,000 тонн хүртэл нэмэгдүүлэхээс гадна базальт чулууны бусад хэрэглээ болох дэд бүтэц, зам тээвэр, барилгын цутгамал суурьнд зориулсан бүтээгдэхүүнүүд бэлтгэх боломжтой болно. Мөн одоогийн үйлдвэр нь 50-125кг/м$^3$ нягттай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа бол үйлдвэрийн шинэчлэл хийснээр 25-200кг/м$^3$ нягт бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой болох бөгөөд бүтээгдэхүүний төрөл мөн нэмэгдэх юм.

| | Одоогийн үйлдвэр | Шинэчлэлийн дараа |
|---|---|---|
| **Хүчин чадал (жил)** | 5,000 тонн | 8,000 тонн |
| **Бүтээгдэхүүний нягт** | 50-125кг/м$^3$ | 30-175кг/м$^3$ |
| **Хаяг** | БГД-ийн 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Үйлдвэрийн тойруу-132, Чингисийн талбайгаас 8.3 км зайтай. | |

*Хүснэгт 58 Одоогийн болон шинэчил хийсэн үйлдвэрийн техникийн харьцуулсан үзүүлэлтүүд*

Компани үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж зах зээлийн тодорхой хэсгийг өөрийн үйлдвэрлэдэг өндөр чанартай, найдвартай бүтээгдэхүүнээр хангаснаар 2019 онд 3.8 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллах боломжтой гэж үзсэн байна. Мөн базальт чулуун орцтой холимог материалын түүхий эд бэлтгэж экспортод гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд Япон улсын Марубени компанитай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан ажиллаж байна.

### Үйлдвэрийн хөрөнгө оруулалт

| Д/д | Үйлдвэрийн хөрөнгө оруулалт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (ам.доллар) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шүршдэг базальт технологийн үйлдвэр | ком | 1 | 80,000 | 200,000,000 |
| 2 | Цахилгаан зуух | ком | 1 | 570,000 | 1,425,000,000 |
| 3 | Үйлдвэрийн автоматжуулалт | ком | 1 | 50,000 | 125,000,000 |
| 4 | Механик цехийн шинчлэл | ком | 1 | 60,000 | 150,000,000 |
| 5 | Цавууны цехийн шинчлэл | ком | 1 | 30,000 | 75,000,000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Лабораторийн шинчлэл | ком | 1 | 20,000 | 50,000,000 |
| 7 | Центрифуг бул засварын төхөөрөмж | ком | 1 | 40,000 | 100,000,000 |
| 8 | Хэсэгчлэн угсрах сэндвич угсрах шугам | ком | 1 | 60,000 | 150,000,000 |
| 9 | Хавтан хөргөх хэрчих хаах хэсгийн шинчлэл | ком | 1 | 100,000 | 250,000,000 |
| **НИЙТ ДҮН** | | | | | **2,525,000,000** |

*Хүснэгт 59 Үйлдвэрийн хөрөнгө оруулалтын дүн*

*Шүршдэг базальт технологийн үйлдвэр*

Шүршдэг базальт технологи нь базальт хөвөнг тусгай цавуутай хольж, дулаалгын хана, таазанд шууд цацан хэрэглэдэг технологи бөгөөд дараах хэд хэдэн давуу талтай. Үүнд:

1. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дамжлага бага тул үнийн хувьд хямд
2. Хавтангаар дулаалахад бэрхшээлтэй өнцөг булан болон таазыг дулаалах боломжтой
3. Дулаалгын ажиллагаа бага тул бага өртгөөр суурилуулах боломжтой

Үнэт цаас гаргагч нь энэхүү шүршдэг базальт технологийн үйлдвэрийг шинэчлэн хүчин чадлыг нь нэмэгдүүлэхэд 200,000,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Энэхүү бүтээгдэхүүнийг компани 2016 онд анх нэвтрүүлсэн бөгөөд барилга угсралтын шатандаа явж байсан Зайсан Hill Complex-ийн дулаалгад амжилттай турших зах зээлд нэвтрүүлээд байгаа билээ.

*Цахилгаан зуух*

Үнэт цаас гаргагч нь одоо үйлдвэрлэлд хэрэглэж буй коксжсон нүүрсний зуухыг цахилгаан зуухаар солихоор төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр базальт чулууг хайлуулах дамжлагад шинэчлэл хийгдэх юм. Цахилгаан зуух нь нүүрсний зуухтай харьцуулахад түүхий эдийн ашиглалт нэмэгдэж үйлдвэрлэлийн зардлыг бууруулах давуу талтай юм. Нүүрсний зуух нь түүхий эдийг 80-180 мм-ийн хэмжээтэй бэлтгэх шаардлагатай байдаг бөгөөд үүнээс жижиг хэмжээний базальт чулуун үүрмэгийг үйлдвэрлэлд ашиглах боломжгүй байдаг байна. Харин цахилгаан зуухыг суурилуулснаар үйлдвэрлэлд түүхий эдийн ашиглалт нэмэгдэхээс гадна үйлдвэрлэлийн дамжлагад гарсан хаягдлыг дахин боловсруулж үйлдвэрлэлд ашиглах боломжтой болох юм. Ингэснээр хаягдалгүй эко үйлдвэрлэлийг нэвтрүүлэх боломжтой болно. Мөн цахилгаан зуух нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулаад зогсохгүй, базальт хэт нарийн утсаар базальт хөвөн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх юм. Улмаар бүтээгдэхүүний физик шинж чанар сайжирна. Энэхүү цахилгаан зуухыг нэвтрүүлэхэд үнэт цаас гаргагч нь 1,425,000,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд ОХУ-ын "Факел" ХХК-тай байгуулсан цахилгаан зуух худалдан авах, суурилуулах гэрээг байгуулаад байна.

*Бусад үйлдвэрийн шинэчлэл болон өргөтгөл*

Дээрх үйлдвэрийн шинэчлэл болон өргөтгөлөөс гадна үйлдвэрийн механик цех, цавууны цех, хавтан хөргөх хэрчих хаах дамжлагуудад болон лабораторид шинэчлэл хийхэд нийт 525,000,000 төгрөг, үйлдвэрийн автоматжуулалт, центрифуг бул засварын төхөөрөмж, хэсэгчлэн угсрах сэндвич угсрах шугам зэрэг үйлдвэрлэлийн өргөтгөлд нийт 375,000,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

*Үйлдвэрийн шинэчлэлийн бүдүүвч зураг*






*Зураг 51 Үйлдвэрийн шинэчлэлийн бүдүүвч зураг*

## Цахилгааны дэд станц

Үнэт цаас гаргагчийн төлөвлөж буй үйлдвэрийн шинэчлэлд цахилгаан зуух суурилуулахтай холбоотойгоор цахилгааны дэд станц, өөрөөр хэлбэл цахилгаан хүчний хувьсгагч зэрэг дэд бүтцийг заавал хамт бүрдүүлэх шаардлагатай. Иймд 2,500 кВт хүчин чадалтай цахилгааны дэд станцыг (ТМ 2500 КВА 10/03 КВ) шинээр суурилуулахаар төлөвлөж байгаа ба үүнд нийт 1,100,000,000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүнтэй холбоотойгоор "Эгэлмон" ХХК-тай цахилгаан станц бариулах ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

| Д/д | Төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төгрөг) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цахилгааны дэд станц | кВт | 2,500 | 440,000 | **1,100,000,000** |
| | | **НИЙТ ДҮН** | | | **1,100,000,000** |

*Хүснэгт 60 Цахилгаан дэд станцын хөрөнгө оруулалт*

СЗХ ... БҮРТГЭВ №1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

**Үйлдвэрийн барилга**

Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын шинэчлэл болон өргөтгөлөөс гадна үйлдвэрийн барилга болон дагалдах байгууламжуудад шинэчлэлт хийхээр төлөвлөөд байна. Одоогийн үйлдвэрийн барилга нь 1986 онд ашиглалтад орсон 1,944 $м^2$ талбайтай, төмөр бетон суурьтай керамзит панель хавтан хийцтэй бөгөөд барилгын гадаад болон дотоод засварт нийт 75,000,000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна. Үүнд хаалга дээврийн засвар, шал бетондох болон агааржуулалтын систем, гэрэлтүүлгийн систем, дохиоллын системийн шинэчлэлтүүдийг хийж гүйцэтгэх юм. Мөн бэлэн бүтээгдэхүүний агуулах шинээр барих, үүнтэй холбоотой дэд бүтцийг байгуулахад 380,000,000 төгрөг, үйлдвэрийн сургалт хөгжлийн төв байгуулахад 225,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

| Д/д | Үйлдвэрийн барилга | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төгрөг) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хаалга<br>Дээвэр<br>Шал бетондох<br>Агааржуулалтын систем шинэчлэх<br>Гэрэлтүүлгийн систем<br>Дохиоллын систем сайжруулалт | - | - | - | 75,000,000 |
| 2 | Үйлдвэрийн ИТА-н сургалт хөгжлийн төв | м2 | 500 | 450,000 | 225,000,000 |
| 3 | Төлөвлөж буй бэлэн бүтэгдэхүүний агуулах | м2 | 1,000 | 150,000 | 150,000,000 |
| 4 | Бэлэн бүтээгдэхүүн хураах гадагшлуулах стэндүүд | ш | 100 | 800,000 | 80,000,000 |
| 5 | Төлөвлөж буй эд буулгах зам талбай бетондох | м2 | 1,500 | 100,000 | 150,000,000 |
| | **НИЙТ ДҮН** | | | | **680,000,000** |

*Хүснэгт 61 Үйлдвэрийн барилгын хөрөнгө оруулалт*

**Үйлдвэрт ашиглах машин механизм**

Мөн үйлдвэрийн гарцыг нэмэгдүүлэхэд түүхий эдийг зөөж тээвэрлэх машин механизмыг нэмэгдүүлэх шаардлагатай ба үүнд нийт 330,000,000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

| Д/д | Машин механизм | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төгрөг) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Автосамосвал SINOTROK | ш | 1 | 90,000,000 | 90,000,000 |
| 2 | Электроник жин | ком | 2 | 25,000,000 | 50,000,000 |
| 3 | 5тн дизель поо | ш | 2 | 30,000,000 | 60,000,000 |
| 4 | 1.5 тн цахилгаан поо | ком | 3 | 10,000,000 | 30,000,000 |
| 5 | Ковш - 50 | ш | 1 | 50,000,000 | 50,000,000 |
| 6 | Бусад машин техник засварын эд анги | ком | 1 | 50,000,000 | 50,000,000 |
| | **НИЙТ ДҮН** | | | | **330,000,000** |

*Хүснэгт 62 Машин механизмын хөрөнгө оруулалт*

**Базальт карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж**

Үйлдвэрийн гарцыг нэмэгдүүлэхэд мөн түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай болж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагчийн эзэмшлийн базальт чулуун ордын гарцыг нэмэгдүүлэхэд карьерийн аж ахуйн тоног төхөөрөмжид нийт 490,976,700 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

2087103 ПЮН0230
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК ... ДҮРЭМ ... ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ... ДУГААР ... ТУСГААРЛАГЧ

| Д/д | Тоног төхөөрөмж | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төгрөг) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | GZD960x3800 чичиргээт тэжээгч | ком | 1 | 183,481,200 | 183,481,200 |
| 2 | PE600x900 хацарт бутлуур | | | | |
| 3 | B800x8.5m туузан дамжуулагч | | | | |
| 4 | Автомат удирдлагын шить | | | | |
| 5 | Бусад дагалдах төхөөрөмжүүд | | | | |
| 6 | 3YZS1848 чичиргээт шигшүүр | ком | 1 | 260,820,000 | 260,820,000 |
| 7 | CSB75 конусан бутлуур | | | | |
| 8 | B800x7.5m туузан дамжуулагч | | | | |
| 9 | Автомат удирдлагын шить | | | | |
| 10 | Бусад дагалдах төхөөрөмжүүд | | | | |
| 11 | B800x18m туузан дамжуулагч | ш | 1 | 9,797,800 | 9,797,800 |
| 12 | B800x15m туузан дамжуулагч | ш | 2 | 8,164,800 | 16,329,600 |
| 13 | B800x14m туузан дамжуулагч | ш | 1 | 7,620,500 | 7,620,500 |
| 14 | B650x115m туузан дамжуулагч | ш | 2 | 6,463,800 | 12,927,600 |
| **НИЙТ ДҮН** | | | | | **490,976,700** |

*Хүснэгт 63 Карьерийн аж ахуйн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт*

### Базальт карьерийн аж ахуйн машин механизм

Мөн базальт чулуун ордын карьерийн аж ахуйн машин механизмд нийт 210,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байгаа бөгөөд эдгээр машин механизмын худалдах, худалдан авах гэрээнүүдийг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулаад байна.

| Д/д | Машин механизм | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төгрөг) | Дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эксковатор CLG925'D | ш | 1 | 60,000,000 | 60,000,000 |
| 2 | Автосамосвал SINOTROK | ш | 2 | 50,000,000 | 100,000,000 |
| 3 | Өрөмдлөгийн компрессор ВПЗ-20/9УХЛ4/механик | ш | 1 | 50,000,000 | 50,000,000 |
| | **НИЙТ ДҮН** | | | | **210,000,000** |

*Хүснэгт 64 Карьерийн аж ахуйн машин механизмийн хөрөнгө оруулалт*

### Түүхий эдийн нөөц

Үйлдвэрийн шинэчлэл болон базальт карьерийн аж ахуйн хөрөнгө оруулалтаас гадна үйлдвэрийн гарцыг нэмэгдүүлэхэд түүхий эдийн хангалттай нөөц шаардлагатай болно. Үнэт цаас гаргагч нь түүхий эдийн 4 сарын нөөц болон цахилгаан зуухны цахилгааны төлбөр зэрэг эргэлтийн хөрөнгөнд 599,013,800 төгрөгийг төлөвлөж байна.

| Түүхий эдийн нөөц | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Д/д | Төрөл | Орц | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Дүн (төгрөг) |
| 1 | Түүхий эдийн 4 сарын нөөц | Базальт чулуу, шохойн чулуу | Сар | 4 | 599,013,800 |
| **НИЙТ ДҮН** | | | | | **599,013,800** |

*Хүснэгт 65 Түүхий эдийн нөөц*

### Эх үүсвэрийн эргэн төлөлт

Дээрх хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөөс гадна Үнэт цаас гаргагчийн Капитал банкнаас авсан 496.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн эргэн төлөлтөд 496,547,500 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна. Энэхүү зээл нь жилийн 24.0%-ийн хүүтэй бөгөөд төлж барагдуулснаар компанийн эх үүсвэрийн өртөг буурах юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

Үйлдвэрийн барилгын шинэчлэл болон шинэ агуулахын зураг төсөл



Зураг 52 Үйлдвэрийн барилга, гадаад заслын зураг төсөл

2087103
ПЮН0220
БАЗАЛЬТ
ХК

### 2.2.3 Ирээдүйн санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үйлдвэрийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээгдэхүүний чанар, төрөл нэмэгдэж, борлуулалтын хэмжээ өсөх юм. Компанийн төлөвлөгөө болон Андеррайтерийн таамаглал дээр үндэслэн ирээдүйн санхүүгийн төсөөллийг боловсруулав. Энэхүү төсөөлөлд үйлдвэрийн шинэчлэл компанийн төлөвлөгөөний дагуу 2018 онд хийгдэх ба үйлдвэрийн санхүүжилт мөн төлөвлөгөөний дагуу хийгдэнэ гэж үзэв. Мөн үйлдвэрийн шинэчлэлийн дараах хүчин чадлын ашиглалт 2019 онд 18.8%, 2020 онд 32.5%, 2021 онд 52.5% хүрч урт хугацаандаа 80% хүрнэ гэж тооцсон болно.

Санхүүгийн төсөөлөлд ашигласан гол таамаглалууд:

- Үнэт цаас гаргагч зах зээл дээрээс 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсанаар шинэ цахилгаан зуух, цахилгааны дэд станц, болон базальт уурхайн үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг хийснээр үйлдвэрлэлийн хүчин чадал 60% нэмэгдэж жилд 8,000 тонн үйлдвэрлэх боломжтой болно.
- Үйлдвэрийн гол дамжлага болон бүтээгдэхүүн хайлуулах зуухыг цахилгаанжуулснаар бүтээгдэхүүний чанар буюу базальт мяндсын чанар нэмэгдэж, БНХАУ, ОХУ, Япон зэрэг орнуудын стандартад нийцсэнээр экспортын хэмжээ нэмэгдэнэ.
- Экспортын орлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн ашиглалт жил ирэх бүр нэмэгдсэнээр 5 жилийн дотор 60% хүртэл өснө.
- Үйлдвэрийн түүхий эдийг өөрийн эзэмшлийн базальт чулууны ордоос хангаснаар Борлуулсан бүтээгдэхүүний өртөг (ББӨ) нийт борлуулалтын 40 орчим хувьд хадгалагдах боломжтой гэж тооцсон бол үйл ажиллагааны зардал нь нийт орлогын 20-30 хувьд хэлбэлзэх тооцоололтой байна.
- Валютын ханш тогтмол боловч бууралттай байх бол ББӨ болон үйл ажиллагааны зардлын үнийн өсөлт нь инфляцын төвшинтэй уялдан жилийн 2-4 хувиар нэмэгдэнэ гэж тооцоолов.
- Үйлдвэрийн хүчин чадлын ашиглалт нэмэгдэж үйлдвэрлэлийн хэмжээ өсөхтэй уялдан үйл ажиллагааны зардал нэмэгдэх боловч үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнээр нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал буурч ашгийн маржин нэмэгдэнэ гэж таамаглав.

Энэхүү санхүүгийн төсөөлөлд компанийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу байгуулах Евро стандартын шинэ үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг тооцоогүй бөгөөд зөвхөн нээлттэй хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн үр дүнг харуулахыг зорьсон болно.

**Орлогын төсөөлөл**

| (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **2,450.0** | **3,785.3** | **6,757.9** | **11,298.7** | **14,828.7** |
| ББӨ | 953.5 | 1,502.7 | 2,709.1 | 4,529.4 | 5,944.5 |
| **Нийт ашиг** | **1,496.5** | **2,282.6** | **4,048.8** | **6,769.3** | **8,884.2** |
| Борлуулалт, марк. зардал | (171.6) | (151.4) | (156.0) | (161.4) | (167.9) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | (1,177.2) | (1,088.6) | (1,306.6) | (1,575.7) | (1,908.1) |
| Бусад зардал | (64.8) | (37.9) | (39.0) | (40.2) | (41.4) |
| **EBITDA** | **810.5** | **1,004.7** | **2,547.3** | **4,992.0** | **6,766.9** |
| Элэгдэл | 649.7 | 649.7 | 646.3 | 646.3 | 646.3 |
| **EBIT** | **160.7** | **354.9** | **1,901.0** | **4,345.7** | **6,120.6** |
| Хүүгийн зардал | 119.2 | 119.2 | 119.2 | 119.2 | 0.0 |
| **Татварын өмнөх ашиг** | **41.5** | **235.8** | **1,781.8** | **4,226.5** | **6,120.6** |
| Татварын зардал | 4.2 | 23.6 | 178.2 | 606.6 | 1,080.1 |
| **Цэвэр ашиг** | **37.4** | **212.2** | **1,603.6** | **3,619.9** | **5,040.4** |

*Хүснэгт 66 Орлогын төсөөлөл*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

СЗХ
БҮРТГЭВ
№ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## Санхүүгийн байдлын төсөөлөл

| (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | **2,793.8** | **3,935.2** | **6,784.8** | **11,955.7** | **18,345.8** |
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 221.6 | 1,793.3 | 2,953.4 | 5,552.5 | 9,943.2 |
| Бусад авлага | 1,006.8 | 1,555.6 | 2,777.2 | 4,643.3 | 6,094.0 |
| Бараа материал | 1,561.7 | 582.7 | 1,050.5 | 1,756.3 | 2,305.0 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3.7 | 3.7 | 3.7 | 3.7 | 3.7 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **26,780.3** | **26,130.6** | **25,484.2** | **24,837.9** | **24,191.5** |
| Үндсэн хөрөнгө | 23,978.8 | 23,329.0 | 22,682.7 | 22,036.3 | 21,390.0 |
| Биет бус хөрөнгө | 2,801.5 | 2,801.5 | 2,801.5 | 2,801.5 | 2,801.5 |
| Хөрөнгө оруулалт | - | - | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **29,574.2** | **30,065.8** | **32,269.0** | **36,793.6** | **42,537.4** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **942.1** | **1,221.5** | **1,821.1** | **2,725.8** | **3,429.1** |
| Дансны өглөг | 467.4 | 746.9 | 1,346.5 | 2,251.2 | 2,954.5 |
| Татварын өр | 271.2 | 271.2 | 271.2 | 271.2 | 271.2 |
| Богино хугацаат зээл | - | - | - | - | - |
| Урьдчилж орсон орлого | - | - | - | - | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 203.4 | 203.4 | 203.4 | 203.4 | 203.4 |
| **Урт хугацаат өр төлбөр** | **496.5** | **496.5** | **496.5** | **496.5** | **496.5** |
| Урт хугацаат зээл | 496.5 | 496.5 | 496.5 | 496.5 | 496.5 |
| **Нийт өр төлбөр** | **1,438.6** | **1,718.0** | **2,317.7** | **3,222.4** | **3,925.7** |
| **Эздийн өмч** | **28,135.5** | **28,347.7** | **29,951.3** | **33,571.2** | **38,611.7** |
| Хувьцаат капитал | 5,641.7 | 5,641.7 | 5,641.7 | 5,641.7 | 5,641.7 |
| Нэмж төлөгдсөн капитал | 21,842.8 | 21,842.8 | 21,842.8 | 21,842.8 | 21,842.8 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 651.0 | 863.2 | 2,466.8 | 6,086.7 | 11,127.1 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **29,574.2** | **30,065.8** | **32,269.0** | **36,793.6** | **42,537.4** |

*Хүснэгт 67 Санхүүгийн байдлын төсөөлөл*

## Мөнгөн гүйлгээний төсөөлөл

| (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(1,085.6)** | **1,571.6** | **1,160.1** | **2,599.1** | **4,390.7** |
| Цэвэр ашиг | 37.4 | 212.2 | 1,603.6 | 3,619.9 | 5,040.4 |
| Элэгдэлийн зардал | 649.7 | 649.7 | 646.3 | 646.3 | 646.3 |
| Дансны авлагын өөрчлөлт | (676.5) | (548.7) | (1,221.7) | (1,866.1) | (1,450.7) |
| Бараа материалын өөрчлөлт | (1,143.7) | 979.0 | (467.8) | (705.8) | (548.7) |
| Өглөгийн өөрчлөлт | 47.5 | 279.4 | 599.6 | 904.7 | 703.3 |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | **(5,239.6)** | **0.0** | **0.0** | **0.0** | **0.0** |
| Үндсэн хөрөнгө | (5,239.6) | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Санхүүгийн мөнгөн гүйлгээ** | **6,431.5** | **0.0** | **0.0** | **0.0** | **0.0** |
| Хувьцаагаарх ХО | 6,431.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Банкны зээлийн өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Цэвэр мөнгөн гүйлгээ** | **106.4** | **1,571.6** | **1,160.1** | **2,599.1** | **4,390.7** |
| **Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл** | **221.6** | **1,793.3** | **2,953.4** | **5,552.5** | **9,943.2** |

*Хүснэгт 68 Мөнгөн гүйлгээний төсөөлөл*

### 2.2.4 Үнэт цаасны өгөөжийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээгээр компанийн зах зээлийн үнэлгээ 25.2 тэрбум төгрөг буюу нэгж хувьцааны үнэ 639 төгрөг гэж тодорхойлсон бөгөөд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 сарын 19-ний өдрийн 2/19-18 тоот тогтоолоор анхдагч зах зээл дээр компанийн нийт хувьцааны 30%-тай тэнцэх 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гарган олон нийтэд нээлттэй арилжаалах ба олон нийтэд санал болгох хувьцааны нэгж бүрийн үнийг 380 төгрөг байхаар тогтоосон.

Иймд үнэт цаас гаргагч нь шинэ хувьцаа эзэмшигчдэд харьцангуй хямд үнээр өөрийн хувьцаагаа санал болгож байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлж байгаа болно.

2087103
ПЮН0220
BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
ДУГААР ТУСГААРЛАГЧ

| | Хувьцааны тоо | Нийт үнэлгээ (төгрөг) | Нэгж хувьцааны үнэ (төгрөг) |
|---|---|---|---|
| Бизнесийн үнэлгээ | 39,491,900 | 25,241,942,105 | 639 |
| Нэмж гаргах хувьцаа | 16,925,100 | 6,431,538,000 | 380 |
| **НИЙТ** | **56,417,000** | **31,673,480,105** | **561.4** |

*Хүснэгт 69 Бизнесийн үнэлгээ болон нэмж гаргах хувьцааны харьцуулалт*

Дээрх харьцуулалтаас харахад олон нийтэд санал болгож буй нэгж хувьцааны үнэ 380 төгрөг нь үнэт цаасаа нийтэд санал болгохоос өмнөх компанийн бизнесийн үнэлгээнээс тооцсон 639 төгрөгтэй харьцуулахад 40.5% хямдруулсан, үнэт цаасаа 30% нэмж гарган нийтэд санал болгосны дараах нийлбэр дүнгээс тооцсон 561.4 төгрөгтэй харьцуулахад 32.3% хямдруулсан үнэ болох нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл үнэт цаас гаргагчийн санал болгож буй 380 төгрөгөөр анхдагч зах зээл дээрээс худалдан авсан хувьцаа эзэмшигчийн өгөөж нэгж хувьцааны үнэ 561 төгрөг бол +48%, харин 639 төгрөг бол +68% байх тооцоотой байна.

Үнэт цаас гаргагчийн ирээдүйн санхүүгийн төсөөлөлд үндэслэсэн хөрөнгө оруулалтын өгөөжийн таамаглалыг хийвэл дараах үр дүн гарч байна.

| Үзүүлэлт | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Хувьцааны тоо | 56,417,000 | 56,417,000 | 56,417,000 | 56,417,000 | 56,417,000 |
| Цэвэр ашиг (сая ₮) | 37.4 | 212.2 | 1,603.6 | 3,619.9 | 5,040.4 |
| Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (EPS) | 0.66 | 3.76 | 28.42 | 64.16 | 89.34 |
| Эздийн өмч (сая ₮) | 28,135.5 | 28,347.7 | 29,951.3 | 33,571.2 | 38,611.7 |
| Хувьцааны дансны үнэ | 498.71 | 502.47 | 530.89 | 595.06 | 684.40 |
| P/E үнэ | 15.24 | 86.50 | 653.77 | 1,475.75 | 2,054.88 |
| P/B үнэ | 997.41 | 1,004.94 | 1,061.78 | 1,190.11 | 1,368.80 |
| Дундаж үнэ | 506.33 | 545.72 | 857.78 | 1,332.93 | 1,711.84 |
| Жилийн өгөөж | 33% | 8% | 57% | 55% | 28% |
| **IPO өгөөж** | **33%** | **44%** | **126%** | **251%** | **350%** |

*Хүснэгт 70 Хөрөнгө оруулалтын өгөөжийн таамаглал*

Дээрх таамаглалд хувьцааны ханшийн өсөлтийг тооцоолохдоо нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг болон хувьцааны дансны үнийг жишиг P/E, P/B үржүүлэгчээр үржүүлж олсон бөгөөд жишиг P/E, P/B үржүүлэгчийг Монголын хөрөнгийн биржийн 1-р самбарын компаниудын дунджаар авсан болно. Учир нь Монголын хөрөнгийн биржийн 1-р самбарын үнэт цаасны арилжаа харьцангуй идэвхтэй бөгөөд хөрөнгө оруулагчдын оролцоо хамгийн их тул дотоодын хөрөнгийн зах зээлийн жинхэнэ үнэ цэнийг илэрхийлэх хэмжүүр гэж үзлээ. Энэхүү таамаглалаас харвал анхдагч зах зээлээс 380 төгрөгөөр авсан хөрөнгө оруулагч урт хугацаандаа буюу 5 жилд 350%-ийн өгөөж хүртэх боломжтой харагдаж байна.

Монголын Хөрөнгийн Биржийн 1-р самбарын компаниудын үнэлгээ (сүүлийн 6 сарын дундаж):

| | Компанийн нэр | Симбол | Зах зээлийн үнэлгээ (сая төгрөг) | P/E | P/B |
|---|---|---|---|---|---|
| 1 | АПУ ХК | APU | 689,791.8 | 31.4 | 1.5 |
| 2 | Говь ХК | GOV | 176,149.4 | 10.5 | 1.7 |
| 3 | Дархан нэхий ХК | NEH | 23,767.8 | 22.0 | 0.6 |
| 4 | Махимпекс ХК | MMX | 10,634.4 | 28.7 | 4.0 |
| 5 | Мик холдинг ХК | MIK | 207,093.2 | 3.5 | 1.4 |
| 6 | Монгол шуудан ХК | MNP | 53,776.6 | 62.5 | 2.7 |
| 7 | Сүү ХК | SUU | 75,642.2 | 29.5 | 3.1 |
| 8 | Таван толгой ХК | TTL | 501,899.4 | 3.6 | 3.0 |
| 9 | Талх чихэр ХК | TCK | 25,592.6 | 23.2 | 0.6 |
| | **Дундаж** | | | **23.9** | **2.1** |

*Хүснэгт 71 МХБ-ийн 1-р самбарын компаниудын үнэлгээ*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## 2.3 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.3.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2018 оны 2 сарын 19-ний өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2/19-18 тоот тогтоолын дагуу анхдагч зах зээл дээр компанийн нийт хувьцааны 30%-тай тэнцэх 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гарган олон нийтэд нээлттэй арилжаалах ба олон нийтэд санал болгох хувьцааны нэгж бүрийн үнийг 380 төгрөг байхаар тогтоосон бөгөөд МХБ-н Анхдагч зах зээлийн арилжааны Тогтоосон үнийн аргыг ашиглан санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй 16,925,100 ширхэг энгийн хувьцааны худалдан авах захиалгыг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор авах ба 2018 оны 4 сард арилжааг хаахаар төлөвлөж байна. Тодорхой өдрийг МХБ болон СЗХ-оос үнэт цаасыг олон нийтэд санал болгох зөвшөөрөл гарсны дараа олон нийтийн хэрэгслээр зарлах болно.




*Зураг 53 Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө*

1. Бүртгүүлэх - МБХ болон СЗХ-с зөвшөөрөл гарч бүртгүүлэх
2. Roadshow/нийтэд мэдээллэх аян - Бүртгүүлсэн өдрөөс 10-14 хоногийн дотор
3. Захиалга авах/Book building - Бүртгүүлсэн өдрөөс 21 хоногийн дотор
4. Арилжаа - Бүртгүүлсэн өдрөөс 24 хоногийн дотор
5. Төлбөр тооцоо - Арилжааны өдрөөс T+0 горимоор

**Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга**

Монголын Хөрөнгийн Биржийн 2009 оны "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-д зааснаар тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэг нь үнэт цаас гаргагчийн зүгээс үнэт цаасыг тогтоосон тодорхой нэг үнээр олон нийтэд санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тогтоосон үнээс өндөр үнээр худалдан авах захиалга өгч болон эсхүл үнэт цаас гаргагчийн зүгээс зөвхөн нэг үнээр санал болгох хоёр хувилбар байдаг.

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

Үнэт цаас гаргагчийн хувьд зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулна.

**Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар**

Хөрөнгө оруулагч нар үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцох боломжтой.

| 1 Арилжааны данс нээлгэх | 2 Мөнгөө байршуулах | 3 Захиалга | 4 Арилжаа хаагдах |
|---|---|---|---|
| - Хүссэн ҮЦК дээр арилжааны данс нээлгэх;<br>- ҮЦК нь ҮЦТХТ болон Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээр харилцагчийн дансыг нээлгэнэ. | Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээрх өөрийн нэр дээрх дансанд мөнгөө байршуулна. | Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-д үнэт цаас худалдан авах захиалга өгнө. | Анхдагч зах зээлийн арилжаа хаагдаж үнэт цаас хөрөнгө оруулагчийн нэр дээр шилжинэ. |

**Үнэт цаасыг хэн худалдан авч болох вэ?**

- Монгол Улсын болон гадаад Улсын иргэн, хуулийн этгээд бүгд худалдан авах эрхтэй. Энэхүү танилцуулгад үнэт цаасыг худалдан авах эрхтэй бүх этгээдийг хөрөнгө оруулагч гэж ойлгоно.
- Үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авахыг хүссэн хөрөнгө оруулагчид нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй үнэт цаасны компаниар зуучлуулан үнэт цаасны данс, үнэт цаасны төлбөр тооцооны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.
- Үнэт цаасны данс шинээр нээлгэж, шинээр хувьцаа худалдах авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь дараах ажлуудыг гүйцэтгэсэн байх шаардлагатайг анхаарна уу:

| Гүйцэтгэх ажил | Тасалбар болох огноо |
|---|---|
| 1. ҮЦК-аар дамжуулан "ҮЦТХТ" ХХК-д өөрийн нэрийн дансыг нээлгэсэн байх | Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө |
| 2. Хувьцаа худалдан авах захиалгаа өөрийн ҮЦК-д өгсөн байх | Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө |
| 3. Хувьцаа худалдах авах төлбөр буюу мөнгөн хөрөнгөө холбогдох шимтгэл (тухайн ҮЦК-н шимтгэлийн хамт)-ийн хамт "Арилжааны төлбөр тооцоо" ХХК дахь өөрийн нэрийн данс руу шилжүүлсэн байх | Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө |

*Хүснэгт 72 Үнэт цаас худалдан авах дараалал*

**Мөнгөн хөрөнгө байршуулах**

Шинээр хувьцаа худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан "Арилжаа төлбөр тооцоо" ХХК дахь өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулах боломжтой.

"ҮЦТХТ" ХХК болон "Арилжаа төлбөр тооцоо" ХХК-нь хувьцааны мөнгөн төлбөр нь бүрэн байршсан хөрөнгө оруулагчдын дансны мэдээллийг МХБ руу анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө хүргүүлэх ба Андеррайтерийн компани нь МХБ-тэй хамтран тус хөрөнгө оруулагчдын захиалгыг нийлүүлэх ажиллагааг анхдагч зах зээлийн арилжаа хаасны дараа явуулан, холбогдох тайлан мэдээг СЗХ-нд хүргүүлнэ.

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн ҮЦК-д төлөх ба уг шимтгэлд МХБ, Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон ҮЦК-ийн шимтгэлийн нийт дүн багтсан байна. МХБ-ийн гишүүн ҮЦК-уудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

**Валютын ханш**

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

**Нэмэлт мэдээлэл**

- Үнэт цаасны дансыг СЗХ-оос брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа үнэт цаасны компаниар зуучлуулан ҮЦТХТ-д нээлгэнэ. Үнэт цаасны дансанд хөрөнгө оруулагчийн худалдан авсан бүхий л үнэт цаас байршин хадгалагдаж байдаг.
- Үнэт цаасны төлбөр тооцооны дансыг өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанитай хамтран ажилладаг, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах эрх бүхий арилжааны банканд нээлгэнэ. Төлбөр тооцооны дансаар одоогоор хоёрдогч зах зээлийн арилжааны хэлцлүүдийн төлбөр тооцоо T+1 горимоор хийгдэж байна. Төлбөр тооцооны дансаар зөвхөн үнэт цаасны төлбөр тооцоо хийгдэх бөгөөд өөр зориулалтаар ашиглах боломжгүй, хөрөнгө оруулагч үнэт цаасны компани банк гурвын дундын данс юм.
- Анхдагч зах зээлийн арилжааг СЗХ-с амжилттай болсон гэж үзвэл хөрөнгө оруулагчдын захиалгын дагуу нийлүүлэлтийг хийнэ.
- Нийлүүлэлт хийгдсэнээр хөрөнгө оруулагчийн үнэт цаасны дансанд хувьцаа байрших бөгөөд захиалгын биелэлтийн мэдээллийг үнэт цаасны компаниас хөрөнгө оруулагчид мэдээлнэ.
- Хувьцаа дансанд нь байршсанаар хөрөнгө оруулагч хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр арилжих боломжтой болно.
- Хоёрдогч зах зээлийн арилжааг СЗХ-ны зөвшөөрлөөр эхлүүлнэ.

### 2.3.2 Үнэт цаасыг олон нийтэд арилжаалах журам

Үнэт цаас гаргагчийн энэхүү танилцуулгын дагуу олон нийтэд санал болгож буй Үнэт цаасыг анхдагч зах зээл дээр арилжаалахад дараах журмыг мөрдлөг болгоно.

- СЗХ-ны үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий Үнэт цаасны компаниар дамжин МХБ-д ирсэн, дансандаа тухайн захиалгыг хангах бэлэн мөнгөний үлдэгдэл бүхий захиалгыг хүчин төгөлдөрт тооцно.
- Үнэт цаасны захиалгын хуваарилалтыг Андеррайтер зохион байгуулж МХБ хяналт тавин ажиллана.
- Хөрөнгө оруулагч хоёр ба түүнээс дээш ҮЦК-р дамжуулан захиалга оруулах, захиалгыг хэд хэд хуваан байршуулсан тохиолдолд нийт захиалгыг нэгтгэж нийлбэр дүнгээр тооцно

### 2.3.3 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээл дээрээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

## 2.4 ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 2.4.1 Хууль эрх зүйн орчин

Үнэт цаас гарган санхүүжүүлэх үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:

**Компанийн тухай хууль**

УИХ-аар 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуульд заасан дараах эрх, үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулж, хувьцаа нэмж гаргах замаар хөрөнгө оруулалт татаж байгаа болно. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа нэмж гаргах бүрэн эрх /Компанийн тухай хуулийн 62.1.3 дахь заалт/

- Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх мэдэгдэл хүргүүлэх болон хурал зарлах журам /Компанийн тухай хуулийн 38.2, 62.1.3 дахь заалт/
- Нэмж гаргах хувьцааны бүртгэлийн эрх зүйн үндэслэл болон төлбөр төлөх журам /Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйл/

**Үнэт цаасны зах зээлийн тухай хууль**

Улсын Их Хурал 2013 оны 05 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон дараах харилцааг зохицуулдаг. Үүнд:

- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам, заавар, дарааллыг Хороо батлах эрх зүйн үндэслэл
- Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлд худалдах, бүрдүүлэх бичиг баримт, үнэлгээ тайлан, тайлагнах үүрэг
- Үнэт цаасны танилцуулгын талаарх нарийвчилсан зохицуулалт
- Нийтэд санал болгох үнэт цаас гаргах ажиллагаан дахь андеррайтерийн оролцоо
- Үнэт цаас гаргагчийн удирдлагад тавигдах нөхцөл, шаардлагын Хороо тогтоох эрх зүйн үндэслэлийг заасан

Тус хуульд заасныар Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Хороо бүртгэж, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгох бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлснээс хойш үнэт цаасны анхдагч зах зээлийн хэлцлийг буцаахгүй.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хуулиар хориглосон байдаг.

### 2.4.2 Холбогдох журмууд

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь Хорооноос баталсан дараах журмуудын холбогдох хэсгээр зохицуулагдана. Үүнд:

**Үнэт цаасны бүртгэлийн журам**

СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23–ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмаар нийтэд санал болгон шинээр болон нэмж гаргах үнэт цаасыг СЗХ-нд бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах, үнэт цаасны гүйлгээний тайланг СЗХ-нд ирүүлэх зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд хамааралтай харилцааг зохицуулдаг.

**Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам**

СЗХ-ны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмаар үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

**Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам**

СЗХ-ны 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 тоот тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журмаар үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааг зохицуулдаг. Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь Биржээс баталсан дараах журам, зааврудын холбогдох хэсгээр зохицуулагдана.

**Бүртгэлийн журам**
МХБ ТӨХК-н Бүртгэлийн журам нь ТУЗ-ийн 2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд тус журмаар Биржийн бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд шинээр нэмж гаргах үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэх, түүнд өөрчлөлт оруулах, арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах зэрэг биржийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**Үнэт цаасны зах зээлийн анхдагч арилжааны журам**
МХБ-н Үнэт цаасны зах зээлийн анхдагч арилжааны журам нь 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд тус журмаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн шинээр болон нэмж гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилах, арилжих үйл ажиллагааг зохицуулдаг.

**Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар**
МХБ-н Бүртгэлтэй Компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан бөгөөд тус зааврааар Биржид бүртгэлтэй компаниудаас хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг ил тод болгох, компаниудаас ирүүлэх мэдээллийн төрөл, жагсаалтыг тогтоох, түүнийг компаниудаас цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, хянах боловсруулах, хадгалах, олон нийтэд мэдээллийг хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.

"Монгол базальт" ХК-ны 2016 оны 7 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 67 дугаар тогтоолоор компанийн Ногдол ашгийн журмыг баталсан ба уг журамд компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна гэж заасан байна. Мөн энэхүү ногдол ашгийн дүн нь тухайн жилийн цэвэр ашгийн 20 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан байна.

Компанийн ногдол ашгийн журмын дагуу ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн шийдвэрлэх ба тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулна. Тухайн жил тараасан ногдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлэхийг уг журмаар зохицуулсан.

Мөн компани ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар уг журамд заасан байна.

### 2.4.3 Татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.3.1-т заасан "ногдол ашгийн орлого"-ын нийт дүнгээс, 16.8-д заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого"-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан албан татвар төлнө.

# БҮЛЭГ 3

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА






# БҮЛЭГ 3 ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА

## 3.1 АНДЕРРАЙТЕР

**Үндсэн андеррайтерийн танилцуулга**

Андеррайтер, брокер, дилерийн "Бумбат Алтай" ҮЦК ХХК нь 1991 онд үүсгэн байгуулагдаж, хөрөнгийн зах зээл дээр тасралтгүй 27 жилийн турш үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Манай компани нь нийт 80,000 гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй Монголын Хөрөнгийн биржийн анхны гишүүн компани юм. 1991 оноос хойш брокер, дилерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, 2016 онд андеррайтерийн тусгай зөвшөөрлийг авсан.

| | |
|---|---|
| Нэр: | "Бумбат Алтай ҮЦК" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 1611002020 |
| Регистрийн дугаар: | 2087103 |
| Хаяг: | УБ хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, 16-байр, 4 давхар 41 тоот |
| Утас: | +976-70112166, 91005585, 99022166 |
| Факс: | +976-70112166 |
| И-мейл: | bumbataltai_21@yahoo.com |
| Веб хуудас: | www.bumbat.mn |

2017 онд Монголын Үнэт Цаасны Бирж буюу анхны хувийн хөрөнгийн биржийн хамгийн эхний IPO болох "Анд Энерги" ХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон, 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтыг амжилттай татан төвлөрүүлсэн.

2017 оны Монголын Хөрөнгийн Биржийн хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцсон идэвхи, арилжааны үнийн дүнгээр эхний аравт жагсаж байсан бол 2018 оны эхний 2 сарын байдлаар арилжааны оролцсон байдал буюу нийт хийсэн арилжааны үнийн дүнгээр эхний 3-т жагсан улам бүр амжилттаа ахиулан ажиллаж байна.

**Туслах андеррайтерийн танилцуулга**

"Гаүли ҮЦК" ХХК нь 2008 онд байгуулагдаж 2008 оны 8 сард Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр андеррайтер, брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, 2008 оны 10 сард Монголын хөрөнгийн биржийн гишүүн байгууллагын зөвшөөрлийг авсанаар өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

| | |
|---|---|
| Нэр: | "Гаүли ҮЦК" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9019036083 |
| Регистрийн дугаар: | 5217962 |
| Хаяг: | Улаанбаатар хот, Оюутны гудамж, Сонор Плаза Багшийн дээд, 6 давхар, 602 тоот |
| Утас: | +976-70153300 |
| Факс: | +976-70153302 |
| И-мейл: | Gauli2008@yahoo.com |
| Веб хуудас: | www.gauli.mn |

"Гаүли ҮЦК" ХХК-ийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- 2009 онд Ремикон компанийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан.
- 2012 онд "Өв ханын материал" ХК –ийн хяналтын багцыг хөрөнгө оруулагч худалдан авах үйл ажиллагааны андррайтер компаниар ажиллаж компанийн бүртгэлийг сэргээх, компанийн үйл ажиллагааг өөрчлөх, шинэ хяналтын багц эзэмшигчийг зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан нь одоогийн "Глобал Монголиа Холдинг" ХК юм.
- 2012 онд Монгол Шуудан компанийн 34 хувийг хувьчлах олон нийтэд санал болгох үйл ажиллагааны зөвлөх компаниар шалгаран ажиллаж байсан бөгөөд 2016 онд Монгол шуудан компанийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан.
- Монголын хөрөнгийн биржийн арилжааны идэвхээр эхний 10-д ордог компани.

**Туслах андеррайтерийн танилцуулга**

"Стандарт инвестмент ҮЦК" ХХК нь 2011 оны 1-р сарын 25-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн биржийн гишүүн компани юм. Байгуулагдснаасаа хойш "Бид санхүүгийн соёлыг түгээнэ" уриан дор нийт 30 гаруй мянган харилцагчдадаа брокерийн үйлчилгээ үзүүлж, 2018 оны 4-р сарын байдлаар нийт 42 тэрбум гаруй төгрөгийн арилжаа хийж гүйцэтгэсэн. "Стандарт инвестмент ҮЦК" ХХК нь үнэт цаасны зах зээлийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, мэдээллээр хангаж үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд анхааран 2012 онд "Хувьцааны цагаан толгой" номыг олон нийтийн хүртээл болгосон.

| | |
|---|---|
| Нэр: | "Стандарт инвестмент ҮЦК" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9011267116 |
| Регистрийн дугаар: | 5444381 |
| Хаяг: | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Б-8 байр, 2 тоот |
| Утас: | +976-70114433 |
| И-мейл: | broker@standardinvestment.mn |
| Веб хуудас: | www.standardinvestment.mn |

"Стандарт инвестмент ҮЦК" ХХК-ийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- 2014 онд Мерекс ХК-ийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох ажиллагааг зохион байгуулж, нийт 2.6 тэрбум төгрөгийг амжилттай босгосон.
- 2015 онд Баянбогд ХК-д Стандарт проперти групп ХХК-ийг нэгтгэх, 2016-2017 онд Ужимхангай ХК-д Стандарт агрикалчер групп ХХК-ийг нэгтгэх замаар тус тус өөрчлөн байгуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн.
- 2017 онд Айтүүлс ХК-д андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн, дотоодын хөрөнгийн зах зээлээс 1.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхэд гурав дахин их захиалга авч, мянга гаруй хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан амжилт гаргаж ажилласан.

### 3.1.1 Андеррайтертай байгуулсан гэрээний тухай

Үндсэн андеррайтер "Бумбат Алтай ҮЦК" ХХК нь 2016 оны 04 сарын 06-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 120 тоот тогтоолоор авсан 3/41 тоот "Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018 оны 02 сарын 26-ны өдрийн 03 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно. Туслах андеррайтер "Гаүли ҮЦК" ХХК нь Үндсэн андеррайтертай байгуулсан 2018 оны 03

сарын 02-ний өдрийн 18/01 тоот "Синдикатаар хамтран ажиллах гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно. Мөн Туслах андеррайтер "Стандарт инвестмент ҮЦК" ХХК нь Үндсэн андеррайтертай байгуулсан 2018 оны 04 сарын 27-ний өдрийн 21-2 тоот "Синдикатаар хамтран ажиллах гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно.

"Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд үнэт цаас гаргагч хөрөнгийн зах зээлд нээлттэй үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу мэргэжлийн андеррайтерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх, Үнэт цаас гаргагч нь нь гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үнэт цаасны танилцуулга материалыг (Проспектус) бэлтгэх, болон Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг арилжаалах андеррайтерийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дугаар зүйлд заасан дээд зэргийн хүчин чармайлтыг гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд арилжаалагдаагүй үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах баталгааг өгсөн
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь болон баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ
- Компанийн хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр ханган ажиллах
- Гэрээний дагуу компанийн хариуцах бүхий л үүргээ биелүүлэх
- МХБ, СЗХ болон бусад зохицуулалтын байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад үүрэг

## 3.2 ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

"Өмгөөллийн Файнэншил Лоо Консалтинг" ("Эф Эл Си") хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь 2014 онд санхүүгийн чиглэлээр хууль зүйн үйлчилгээ үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан нөхөрлөл бөгөөд 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрх авч Хороонд бүртгэгдсэн байна.

| | |
|---|---|
| Нэр: | "Эф Эл Си" Өмгөөллийн ХХН |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9022001118 |
| Регистрийн дугаар: | 5908183 |
| Хаяг: | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,<br>Экспресс цамхаг, 601 тоот |
| Утас: | +976-70076967 |

Үүсгэн байгуулагдснаас хойш гадаад, дотоодын иргэд, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагуудад дараах чиглэлээр хууль зүйн зөвлөгөө үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Дүрэм, журам, гэрээ болон бусад эрх зүйн баримт бичгүүд боловсруулах, дүгнэлт өгөх үйлчилгээ
- Үйлчлүүлэгчийг шаардлагатай асуудлаар аливаа байгууллага, иргэний өмнө төлөөлөх, түүний эрх ашгийг хамгаалах төлөөллийн үйлчилгээ
- Аливаа асуудлаар хууль эрх зүйн магадлан шинжилгээ хийх үйлчилгээ
- Иргэн, захиргаа, эрүүгийн хэрэг маргаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр өмгөөллийн үйлчилгээ

"Эф Эл Си" ХХН-ийн онцлог нь банк, санхүү болон иргэн, захиргааны эрх зүйн салбарт онол, хэрэглээний өндөр түвшинд бэлтгэгдсэн, арвин туршлагатай, холбогдох салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн өмгөөлөгч, хуульчдаас бүрдсэн байна.

### 3.2.1 Хуулийн зөвлөхтэй байгуулсан гэрээний тухай

"Эф Эл Си" ХХН нь 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос авсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2016 оны 5 дугаар сар 17-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 16/06 дугаартай "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу олон нийтэд анх удаагаа хувьцаагаа санал болгохоор бэлтгэж байгаа "Монгол базальт" ХХК-д хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа болно. Уг гэрээгээр үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргах замаар нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагаанд Үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.2.2 дахь хэсэг заасан асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна. Үүнд:

- Компанийн хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх
- Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал
- Компанийн дүрэм хууль тогтоомжид нийцсэн эсэх
- Компанийн дүрэм Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх
- Компанийн засаглалын журмууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх
- Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх
- Компанийн бусадтай байгуулсан худалдах-худалдан авах гэрээ болон бусад гэрээ хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх
- Сүүлийн 1 жилийн дотор байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх
- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь бодитой
- Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх
- Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх
- Компанийн толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох зэрэг үйл ажиллагаанд дүгнэлт гаргах гэрээ байгуулсан байна.

Энэхүү гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- Үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай үзүүлэх

- Үйлчлүүлэгчийн талаарх нууцыг хадгалах
- Гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар үйлчлүүлэгчид мэдээлэх
- Үйлчилгээ үзүүлэгч гэрээнд заасан ажил үүргээ хэрэгжүүлэхдээ хоёр хүртэл тооны гишүүн болон 1 туслах ажилтан хамтран ажиллах
- Гэрээгээр тохирсон хөлс, хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд гарах зайлшгүй зардал, гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой баримт материалыг үйлчлүүлэгчээс шаардах
- Үйлчлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс болж хугацаа хэтэрсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч тал хариуцлага хүлээхгүй бөгөөд гэрээгээр тохиролцсон төлбөрийг Үйлчлүүлэгчээс шаардах эрхтэй

Үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг, эдлэх эрх:

- Үйлчилгээ үзүүлэгчийг гэрээнд заасан ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт материалаар хугацаа алдахгүй хангах
- Шаардлагатай шийдвэрийг цаг алдалгүй гаргаж Үйлчилгээ үзүүлэгчийг ажиллах нөхцөл, бололцоогоор хангах
- Гэрээнд заасан хөлсийг гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид төлөх
- Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээнд заагдсан ажил үүргийн хэрэгжилт, үйл ажиллагаатай танилцах, санал, хүсэлт өгөх
- Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны талаар тайлан гаргуулах зэрэг эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

## 3.3 АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

"Бэст Фортуна Аудит" ХХК нь 2009 онд байгуулагдан нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж, 2011 оны 1 дүгээр сараас аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч одоо үндсэн аудитор 5, аудиторын туслах 6, менежер 1, нийт 12 ажилтантайгаар, Захирал Ж.Оюунцэцэг компанийг удирдан ажиллаж байна.

| | |
|---|---|
| Нэр: | "Бэст фортуна аудит" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9018001054 |
| Регистрийн дугаар: | 5345847 |
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,<br>"Монгол Эм Импекс Концерн" ХХК-ийн байр, 200 тоот |
| Утас: | +976-11-324338 |
| И-мейл: | fortune_audit@yahoo.com |

Тус компани нь Сангийн яамнаас авсан "Аудитын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл"-өөс гадна Санхүүгийн зохицуулах хорооноос "Даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ", "Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагад аудит хийх эрх" зэргийг авсан болно.

Үйлчилгээний чиглэл, төрөл:
1. Санхүүгийн тайлангийн аудит болон баталгаажуулалт
2. Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ
3. Сургалт:
   - Шинээр төгссөн, компаниудын захиалгаар шинэ нягтлан бодогчдыг дадлагажуулах сургалт
4. Санхүү, татварын тайлан бэлтгэх
5. Бусад үйлчилгээ:
   - Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн дотоод аудитын ажлыг гэрээгээр гүйцэтгэх
   - Эздийн болон хууль хяналтын байгууллагын захиалгаар санхүүгийн баримтын шалгалт хийж дүгнэлт гаргах
   - Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах

Компани Үндэсний аудитын газрын захиалгаар төсвийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудад аудит хийж байгаагаас гадна хувьцаат компаниуд, даатгалын болон даатгалын зуучлагч компаниуд, банк бус санхүүгийн байгууллага, брокер диллерийн компани, ХХК-ууд зэрэг 180 гаруй байгууллагад санхүүгийн зөвлөх болон аудитын үйлчилгээ үзүүлж байна.

### 3.3.1 Аудитын байгууллагатай байгуулсан гэрээний тухай

“Бэст Фортуна Аудит” ХХК нь “Үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагад аудит хийх эрх”-ийн хүрээнд 2016 оны 07 дугаар сар 04-ний өдөр Үнэт цаас гаргагч байгуулсан 68 тоот “Аудитын гэрээ”-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг санал болгох үйл ажиллагаанд аудитын байгууллагын үүргийг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж Үнэт цаасны танилцуулгад заасан санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэх талаар дүгнэлт гаргахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

Үйлчлүүлэгчийн эрх:

- Захиалагчийн гаргаж өгсөн мэдээлэл нь дутуу, бодит байдалтай нийцээгүй, төөрөгдүүлсэн мэдээлэл байснаас хөрөнгө оруулагчдад учруулсан хохирлыг Захиалагч өөрөө бүрэн хариуцна.
- Баталсан хуваарийн дагуу аудит хийхийг Гүйцэтгэгчээс шаардах, аудитороос гаргасан санал, дүгнэлтийн талаар асуух, танилцах, эдгээртэй холбогдсон тайлбар өгөхийг шаардах
- Аудитын санал, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол энэ талаар холбогдох байгууллагад санал, гомдлоо гаргах
- Гэрээний хугацаанд үйлчлүүлэгчид аудитын дүгнэлт, зөвлөмжөө гаргаж өгөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувийн алданги тооцон ажлын хөлснөөс суутгах

Үйлчлүүлэгчийн үүрэг:

- Санхүүгийн тайлангийн аудит хийхэд шаардагдах бичиг баримт, тайлбар болон “Нийтэд санал болгох худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журамд заасан ажиллагааг хэрэгжүүлж, дүгнэлт гаргахад шаардлагатай бодитой мэдээлэл, материалыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.
- Мөнгөн орлого, зарлагын гүйлгээ ба тайланг хуулийн хүчин төгөлдөр байдлаар баримтжуулан, тайлбар тодруулгууд /цаашид санхүүгийн баримт, тайлан гэх/-ыг стандарт, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд нийцүүлэн Монгол улсын хууль болон бусад заавар, журмын дагуу бэлтгэсэн байх
- Аудиторт танилцуулсан санхүүгийн баримт мэдээллийн үнэн зөв, иж бүрэн ба бодитой байдлын хариуцлагыг Үйлчлүүлэгчийн удирдлага хүлээнэ.

Гүйцэтгэгчийн эрх:

- Аудитад шаардагдах санхүүгийн болон бусад баримт, мэдээллийг Үйлчлүүлэгчээс шаардаж авах, шалгалтын явцад гарсан аливаа асуудлаар нэмэлт тайлбар гаргуулах хэрэв өгсөн материал нь бүрэн бодит бус, шаардлага хангахгүй бол түүнийг нэмж гаргуулах, шаардах эрхтэй
- Захиалагчийн гаргаж өгсөн материал нь дутуу, бодит байдалтай нийцээгүй, төөрөгдүүлсэн мэдээлэл байснаас хөрөнгө оруулагчдад учруулсан хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй
- Үйлчлүүлэгч нь аудитад шаардлагатай баримт, тайлбарыг бүрэн хэмжээгээр гаргаж өгөөгүй, санхүүгийн баримт мэдээллүүд нь нягтлан бодлох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн

гаргаж өгөх талаар аудиторын тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд аудит хийхээс татгалзах

- Үйлчлүүлэгч гэрээнд заасан хугацаанд аудитын ажлын хөлсийг төлөөгүй тохиолдолд хоног тутамд үнийн дүнгийн 0.5%-иар алданги тооцож нэхэмжлэх

Гүйцэтгэгчийн үүрэг:

- Аудитын гэрээт ажлыг мэргэжлийн өндөр төвшинд, аудитын тухай Монгол улсын хууль, олон улсын стандартад нийцүүлэн, мөрдөж байгаа эрх зүйн акт, заавар аргачлалуудын дагуу явуулах
- Үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны талаарх нууцыг задруулахгүй байх, аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглахыг хориглох, хуульд зааснаас бусад тохиолдолд гадагш мэдээлэхээс татгалзах

## 3.4 ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Хөрөнгийн үнэлгээний "Мөнх Оргил Трейд" ХХК нь 2013 оны 9 сарын 18-ны өдөр СЗХ-ны 297 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний байгууллагаар бүртгүүлсэн байна.

| | |
|---|---|
| Нэр: | "Мөнх-Оргил трейд" ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9011106018 |
| Регистрийн дугаар: | 2041537 |
| Хаяг: | Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Бага тойруу, МҮЭХ-ны байр, 211 тоот |
| Утас: | +976-99189250 |
| И-мейл: | motecology@yahoo.com |

Тус компани хөрөнгийн үнэлгээ тэр дундаа Газар, барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж, хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бизнесийн үнэлгээ, биет бус хөрөнгийн үнэлгээ, зээлийн барьцааны хөрөнгийн үнэлгээ, татвар, санхүүгийн тайлагналын үнэлгээ зэргийг мэргэжлийн өндөр төвшинд гүйцэтгэдэг байгууллага юм.

Компани мөн байгаль орчны чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ,
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ,
- Ашигт малтмалын нөөцийн эдийн засгийн үнэлгээ,
- Байгаль орчны хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ,
- Нөхөн сэргээлтийн төсөл, хөтөлбөр,
- Байгаль орчны хяналт-шинжилгээний төсөл, хөтөлбөр зэргийн үйлчилгээг үзүүлдэг.

### 3.4.1 Үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний тухай

"Мөнх Оргил Трейд" ХХК нь СЗХ-ны 2013 оны 9 сарын 18-ны өдрийн 297 тоот тогтоолоор олгогдсон "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2016 оны 2 сарын 26-ны өдөр Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн бирж дээрээс хөрөнгө босгох үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээ, бизнесийн үнэлгээ хийж энгийн нэгж хувьцааны үнэ цэнийг тогтоох зорилготой 07-2016 дугаартай Хөрөнгийн болон Бизнесийн үнэлгээний гэрээг байгуулсан байна.

Уг гэрээний зорилго нь үнэлгээчин нь захиалагчийн бүрдүүлж өгсөн болон бусад мэдээлэл дээр тулгуурлан үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ, ханшид аль болох ойртуулан үнэн зөв, үндэслэлтэй дүгнэлтийг гаргаж өгөхөд оршино.

Үнэт цаас гаргагчийн хувьд тус гэрээгээр гүйцэтгэгч байгууллагаас гаргаж өгсөн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний тайлантай танилцах, энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа үл ойлголцол, маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй болвол хуулийн байгууллагад хандаж болно гэж заасан ба үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, хөрөнгийн бодит байдалтай танилцах, хэмжилт хийх боломжийг олгох, компанийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх зэрэг үндсэн үүргүүдийг хүлээж байна.

Үнэлгээчний эрх, үүрэг:

- Үнэлгээчин нь захиалагчийн бүрдүүлж өгсөн болон бусад мэдээлэл дээр тулгуурлан үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг зах зээлийн үнэ, ханшид аль болох ойртуулан үнэн зөв, үндэслэлтэй энэ гэрээнд заасан хугацаанд багтаан явуулна.
- Үнэлгээчин нь үнэлгээний ажлын үр дүнг тайлан хэлбэрээр бэлтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.
- Тайлан нь үнэлгээчний гарын үсэг, компанийн тамгаар баталгаажна.
- Үнэлгээчин нь захиалагч болон бусад талуудын аливаа шахалтгүйгээр чөлөөтэй нөхцөлд үнэлгээг явуулна.
- Үнэлгээчин нь тухайн үнэлгээний ажилд шаардлагатай баримт, мэдээллийг захиалагчаас гаргуулн авч ашиглах эрхтэй
- Үнэлгээчин нь захиалагчийн бизнесийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд бусдад задруулж болохгүй
- Үнэлгээчин нь энэ гэрээний 2.4, 2.5-д заасан нөхцөлүүд хангагдахгүй тохиолдолд үнэлгээний ажлыг цаашид явуулахаас татгалзах эрхтэй.

Захиалагчийн эрх, үүрэг:

- Захиалагч нь үнэлгээнд шаардлагатай бичиг баримт, материал, мэдээллүүдийг үнэлгээчинд үнэн зөв гаргаж өгнө
- Захиалагч нь үнэлгээчинд ямар нэг шахалт, дарамт үзүүлж болохгүй
- Захиалагч нь үнэлгээчний хийсэн тайлантай танилцаад үнэлгээний ажлыг хангалтгүй гэж үзвэл дахин тодруулах, нэмэлт тайлбар гаргуулах эрхтэй.

# БҮЛЭГ 4

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ



# БҮЛЭГ 4 ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ

## 4.1 АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

БУМБАТ АЛТАЙ
БРОКЕР ДИЛЕР, АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

**"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД**

2018 оны 03 сарын 20 ны өдөр
Дугаар № .............................

**"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОЖ БУЙ ХУВЬЦААНД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРЫН ДҮГНЭЛТ**

"**БУМБАТ АЛТАЙ ҮЦК**" ХХК (цаашид "**Андеррайтер**" гэх) нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д заасны дагуу "**МОНГОЛ БАЗАЛЬТ**" ХААЛТТАЙ ХК-тай (цаашид "**Үнэт цаас гаргагч**" гэх) 2018 оны 02 дугээр сарын 26-ний өдөр байгуулсан 03 тоот гэрээний үндсэн дээр Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй нэг бүр нь 380 төгрөгийн худалдах үнэтэй, 16,925,100 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгон нийт 6,431,538,000 (зургаан тэрбум дөрвөн зуун гучин -нэгэн сая таван зуун гучин найман мянга) төгрөгийг татан төвлөрүүлэхээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулагчдад танилцуулах, захиалга авах, анхдагч зах зээлд худалдан борлуулах, анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн хувьцааг худалдан авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Андеррайтер нь анхдагч зах зээлд худалдан борлуулах болон захиалга авах үйл ажиллагааг явуулахдаа туслах андеррайтер "**ГАҮЛИ ҮЦК**" ХХК болон "**СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК**" ХХК-тай гэрээ байгуулж хамтран ажиллаж байгаа болно.

Энэхүү дүгнэлтийг боловсруулахдаа үнэт цаас гаргагчийн бидэнд гарган өгсөн баримт материалд зохих судалгаа хийхийн зэрэгцээ аудит, үнэлгээ болон хууль зүйн хараат бус хөндлөнгийн байгууллагуудын зүгээс өгсөн дүгнэлтүүдийг үндэслэл болгов.

Андеррайтерын үйлчилгээний хүрээнд бид дараах дүгнэлтүүдийг гаргалаа. Үүнд:

**Компанийн өнөөгийн үйл ажиллагаа, ирээдүйн үйл ажиллагааны талаар**

Үнэт цаас гаргагч "Монгол базальт" ХК нь 2007 онд байгуулагдсан гадаад худалдаа, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын анхны бөгөөд цорын ганц базальт чулуун дулаалгын материал үйлдвэрлэдэг компани юм. Үнэт цаас гаргагч нь 2007 онд өөрийн үйлдвэрийг байгуулахдаа бусад улсын туршлагыг судалсны үндсэн дээр өөрсдийн загвараар байгуулсан бөгөөд чулуун хөвөн үйлдвэрлэх технологийн "ноу-хау"-гаараа оюуны өмчийн патент авсан байна. Мөн Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Basaltwool бүтээгдэхүүний гэрчилгээтэйгээр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж байна. Компани нь Төв аймгийн Баяндэлгэр сумын Ногоон уул хэмээх газарт өөрийн 100% эзэмшлийн 2043 он хүртэл ашиглалтын лицензтэй, 32.4 га талбай бүхий ордоос үйлдвэрийнхээ түүхий эдийг нийлүүлж байна.

Базальт чулуун материал нь галд тэсвэртэй, дулаан болон дуу чимээ сайн тусгаарладаг, экологид ээлтэй бүтээгдэхүүн тул зөвхөн дулаалгын материалд ашиглаад зогсохгүй маш олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болгон ашиглах боломжтой юм. Мөн базальтыг базальт утас, базальт арматур, базальт тормосны наклад гэх мэт олон төрөлд ашиглаж болдог тул цаашдаа компанийн хувьд бизнесийн хүрээгээ тэлэх, илүү их боломж байгааг харуулж байна.

"Монгол базальт" ХК нь дотоодын чулуун хөвөн дулаалгын зах зээлийн 60 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг бөгөөд Улаанбаатар хотын А зэрэглэлийн томоохон төслүүдийн үндсэн дулаалгын материалыг хангаж, тэдгээр компаниудад дулаан алдагдал бага, галд тэсвэртэй, дуу чимээ сайн тусгаарладаг бүтээгдэхүүн нийлүүлэн ажилласан. Цаашлаад эдэлгээ чанар сайтай, өндөр зэрэглэлийн бүтээгдэхүүнийг эрэлхийлдэг компаниудад өрсөлдөгч бүтээгдэхүүнтэй үнэ болон чанараар ялгарах замаар бүтээгдэхүүнээ нийлүүлэн ажиллах өргөн боломжтой байна. Мөн Улсын болон Орон нутаг тэр дундаа Нийслэл хотын хүрээнд хэрэгжүүлэх дахин төлөвлөлт болон хуучин барилга байгууламжийн дулаалгын төсөл хөтөлбөрүүдэд оролцон бүтээгдэхүүний борлуулалтаа өсгөх боломжтой компани юм.

Базальт бүтээгдэхүүний шинэ төрөл болох шүршдэг базальт, базальт утас зэргийн үйлдвэрлэлийг хөгжүүлснээр зах зээлийн 40 хувийг эзэлдэг импортын бүтээгдэхүүний орон зайг эзлээд зогсохгүй гадны зах зээл тэр дундаа Япон, ОХУ, БНХАУ-д бүтээгдэхүүнээ борлуулан, худалдаагаа өргөжүүлэх боломжтой юм. Компанийн төлөвлөж буй шинэ үйлдвэр ашиглалтад орсноор гадаадын ижил төрлийн үйлдвэрүүдтэй өртөг болон чанараар өрсөлдөх боломжтой болно гэж үзэж байна.

**Үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдлын талаар**

Монголын барилгын дулаалгын материалын зах зээл сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр өсч, эрэлтийн хэмжээ нэмэгдсэн боловч 2014-2015 оны эдийн засгийн удаашрал, хүмүүсийн худалдан авах чадвартай холбоотойгоор өсөлтийн хурд удааширч байна. 2016 оны байдлаар нийт баригдсан барилгын тоо, эрэлтийн хэмжээнээс давсан байдалтай байгаа нь цаашдаа баригдах барилгын тоонд сөргөөр Монголын барилгын дулаалгын материалын зах зээл сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр өсч, эрэлтийн хэмжээ нэмэгдсэн боловч 2014-2015 оны эдийн засгийн удаашрал, хүмүүсийн худалдан авах чадвартай холбоотойгоор өсөлтийн хурд удааширч байна. 2016 оны байдлаар нийт баригдсан барилгын тоо, эрэлтийн хэмжээнээс давсан байдалтай байгаа нь цаашдаа баригдах барилгын тоонд сөргөөр нөлөөлөх боловч, галд шатдаггүй, дуу чимээ сайн тусгаарладаг, эрүүл мэнд экологид хор нөлөөгүй дулаалгын материалыг сонгох барилгын тоо буурахгүй байх төлөвтэй байна.

Андеррайтерийн тооцооллоор нийт дулаалгын материалын зах зээлийн багтаамж 47.4-52.0 тэрбум төгрөг бөгөөд үнэт цаас гаргагч нь нийт дулаалгын материалын зах зээлийн 2.5%, чулуун хөвөн эзэлж байгаа бөгөөд дотоодын зах зээлийн 60 гаруй хувийг цаашид бүрэн хангах боломжтой юм.

Монгол Улсын Засгийн газраас хүн амыг орон сууцжуулах "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр", "Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөр, "Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хөтөлбөр" зэрэг олон төсөл хөтөлбөр, болон "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-г хэрэгжүүлж байгаа нь барилгын салбарт шаардагдах дулаалгын материалын эрэлтийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болохоор байна.

**Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл, газрын гэрчилгээ, патент, барааны тэмдэгийн талаар**

Үнэт цаас гаргагч нь Улсын бүртгэлийн 9010001085 тоот гэрчилгээний дугаартай, 5112494 тоот регистрийн дугаартай Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд 2007 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. Барилга хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
БҮРТГЭВ
2087103
BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
5112494
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

байгуулалтын яамнаас олгосон БМҮ 118/16 дугаартай Барилгын материал үйлдвэрлэл: Эрдэс /чулуун/ хөвөнгийн үйлдвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг 2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр сунгасан бөгөөд 5 жилийн хугацаатай байна. Ашигт малтмалын газраас олгосон MV-017426 дугаартай Төв аймгийн Баяндэлгэр сумын Ногоон уул гэдэг газар 32.39 гектар талбайд ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн 9010001085 тоот гэрчилгээтэй бөгөөд гэрчилгээний хугацаа 2043 оны 12 дугаар сарын 02-ыг хүртэл хүчинтэй, хүчин төгөлдөр Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байна. Мөн Оюуны Өмчийн газрын 1764 тоот "Базальт чулуун хөвөн үйлдвэрлэх арга", "Базальт чулуун хөвөн мяндсаар арматур үйлдвэрлэх арга" зэрэг тусгай зөвшөөрлүүдтэйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагч нь Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн 2017 оны 3 сарын 28-ны өдрийн 01/748 дугаар тогтоолын дагуу Хаалттай хувьцаат компани болон бүртгэгдсэн.

Компанийн тухай хуулийн 31, 32, 33, 62 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 2 сарын 19-ны өдрийн 2/19-18 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэмж хувьцаа гаргаж байгаа бөгөөд хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж олон нийтэд санал болгох замаар Нээлттэй хувьцаат компани болж байгаа болно.

**Үнэт цаас гаргагч нь II ангилалын шалгуур, шаардлага хангаж буй эсэх талаар**

Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" (цаашид "ҮЦБЖ" гэх)-ын 10 дугаар зүйлийн 2-т "Шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэх, нэгдэж, нийлэх ба хуваах, тусгаарлах замаар үнэт цаас болон компани бүртгүүлэхэд энэ бүлэгт заасан тухайн ангиллын шалгуурыг хангасан байна" гэж заасан байдаг.

МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10 дугаар зүйлийн 5-д заасны дагуу үнэт цаас гаргагч нь ангилал тус бүрт тогтоосон шалгуураас гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.1 Үнэт цаас гаргагч, түүний хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх.</u>

"Монгол Базальт" ХК-ийн хяналтын багцыг эзэмшигч нь Монгол Улсын иргэн Лхагважав овогтой Ариунболд байна. Л.Ариунболд нь хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлын өр төлбөртэй эсэх мэдээлэл:

| № | Нэр | Регистрийн дугаар | Албан тушаал | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт |
|---|---|---|---|---|
| 1 | Пүрэвбанзрагч Батмөнх | ЧЛ74122331 | ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 2 | Лхагважав Ариунболд | ЧР65010678 | ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 3 | Пүрэвбанзрагч Сайнбилэг | ЧР64112065 | ТУЗ-ийн ердийн гишүүн, санхүү эрхэлсэн захирал | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 4 | Ариунболд Энхгэрэл | ЦД88081664 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 5 | Галбадрах Ганзориг | ЕП58042111 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 6 | Түпэв Билэгт | УЕ46061338 | ТУЗ-ийн ердийн гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 7 | Чансаа Зоригтбаатар | УК68040211 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 8 | Шаравсамбуу Энхтөр | ИФ69031515 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |
| 9 | Бадрах Шаравсамбуу | ХБ47111671 | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна. |

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.*

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь бүхэлдээ эсхүл дийлэнх хэсэг нь мөнгөн хөрөнгө болон богино хугацаат үнэт цааснаас бүрдээгүй байх.</u>

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллийн дагуу уг шалгуурыг хангаж байна. Санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.3. Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн санхүүгийн жилийн үеэр санхүүгийн тайлагналын хугацаагаа өөрчлөөгүй байх</u>

“Монгол Базальт” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1 -д зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.” мөн тус хуулийн 10.3-д “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.” гэж заасны дагуу санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь тайлагнадаг байна.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.4. Үнэт цаас гаргагчийн биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх санхүүгийн тайлангийн сүүлийн хугацаа нь 6 сараас ихгүй байх ба заасан хугацаанаас их байгаа тохиолдолд хамгийн сүүлийн улирлын тайланг аудитаар баталгаажуулах эсхүл уг тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл</u>

“Монгол Базальт” ХК-ийн 2015, 2016 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “Бэст Фортуна Аудит ХХК” нь аудит хийсэн байна.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрддөг байх</u>

“Монгол Базальт” ХК-ийн компанийн засаглалын кодексын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Ногдол ашгийн журам”, “Мэдээллийн үйл ажиллагааны журам”, “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам” зэргийг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг байна.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.6. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь үнэнч шударга, ес зүйтэй байх</u>

“Монгол Базальт” ХК-ийн 2018 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн 1903/А-1 тоот албан бичгээр Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид үнэнч шударга, ёс зүйтэй ажиллах амлалтыг өгсөн байна.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.7. Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх</u>

ТУЗ-ийн гишүүд:

| **Албан тушаал:** | **ТУЗ-ын дарга, Ерөнхий удирдлага эрхэлсэн захирал** |
|---|---|
| **Овог нэр** | П. Батмөнх |
| **Мэргэжил** | Эрх зүйч |

| | |
|---|---|
| **Төрсөн огноо** | 1974 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1992-2003 онд "Чин" ХХК-д Ерөнхий менежер<br>▪ 2003-2006 онд "Жи Би Эл" ХХК-д Ерөнхий менежер<br>▪ 2006-"Монгол базальт" ХК-д Ерөнхий удирдлага эрхэлсэн захирал |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н гишүүн, Ерөнхий захирал** |
|---|---|
| **Овог нэр** | Л.Ариунболд |
| **Мэргэжил** | Барилгын технологийн тоног төхөөрөмжийн инженер механик |
| **Төрсөн огноо** | 1965 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1987-1990 онд БЦУГ-ын Засвар механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер<br>▪ 1990-1993 онд Автомашины салхины шилний Төслийн удирдагч, тус төслийн үр дүнд Автомашины салхины шилний үйлдвэр "Чин" ХХК байгуулагдсан.<br>▪ 1995-1999 онд Монгаз төслийг санаачлагч, төслийн удирдагчаар ажиллаж, "НИК ГАЗ" ХХК компани байгуулагдсан.<br>▪ 1999-2012 онд "Монголшил" төслийн удирдагч, төслийн үр дүнд шилэн лонхны үйлдвэрийн төсөл хийгдэж байна.<br>▪ 2005 оноос чулуун хөвөн чулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, төслийн удирдагч, "Монгол базальт", BASALTWOOL, ROCKWOOL компанийн Ерөнхий захирал, ТУЗ-н даргаар ажиллаж байна. |
| **Шагнал:** | ▪ Тэргүүний барилгачин<br>▪ Үйлдвэр худалдааны тэргүүний ажилтан<br>▪ "Шинийг санаачлагч" цол тэмдэг<br>▪ Барилгын материалын үйлдвэрийн тэргүүний ажилтан<br>▪ Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль<br>▪ Монгол Улсын Шилдэг Зохион Бүтээгч Инженер |

| **Албан тушаал:** | **ТУЗ-ын гишүүн, Санхүү эрхэлсэн захирал** |
|---|---|
| **Овог нэр** | П. Сайнбилэг |
| **Мэргэжил** | Банк, Санхүүч |
| **Төрсөн огноо** | 1964 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1997-2001 онд Сайн Сан ХХК-д Захирал<br>▪ 2001-2005 онд Жи Ви Эл ХХК-д гүйцэтгэх захирал<br>▪ 2005- "Монгол базальт" компанид санхүү эрхэлсэн захирал |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н хараат бус гишүүн** |
|---|---|
| **Овог нэр** | Б. Шаравсамбуу |
| **Мэргэжил** | Эдийн засагч |
| **Төрсөн огноо** | 1947 |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1965-1970 онд Толгойт Төв бараа бааз тооцооны, ахлах, орлогч ня-бо<br>▪ 1975-1979 онд Худалдаа, бэлтгэлийн яамны ахлах мэргэжилтэн,газрын дарга,<br>▪ 1979-1984 онд тус яамны орлогч сайд,<br>▪ 1984-1990 онд Худалдаа, бэлтгэлийн яамны сайд,<br>▪ 1990 онд Сайд нарын зөвлөлийн орлогч дарга,<br>▪ 1991-1994 онд Москвад суугаа ЭСЯ ны нэгдүгээр нарийн бичгийн дарга,<br>▪ 1994-1996 онд Гаалийн ерөнхий газрын дарга,<br>▪ 1996-1998 онд Улаанбаатар импекс компани ТӨ ҮҮГ –н ерөнхий захирал, |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
СЗХ БҮРТГЭВ
BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

| | |
|---|---|
| | ▪ 1996-2000 онд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль маркетингийн тэнхимийн эрхлэгч,<br>▪ 2000-2004 онд Улсын их хурлын гишүүн,<br>▪ 2005-2011 онд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга |
| **Шагнал:** | ▪ Монгол улсын Гавъяат эдийн засагч,<br>▪ Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон,<br>▪ Ардын хувьсгалын 60,70,80,90 жилийн ойн медаль,<br>▪ Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль,<br>▪ Худалдаа, Санхүү, Банк, Статистикийн тэргүүний ажилтан |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н хараат бус гишүүн** |
|---|---|
| **Овог нэр** | Ч. Зоригтбаатар |
| **Мэргэжил** | Хууль зүйн магистр, Банк санхүүгийн эдийн засгийн бакалавр |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1996-1997 онд Төрийн өмчийн хороо, Хуулийн зөвлөх<br>▪ 1997-1998 онд Хууль зүйн дунд сургууль хичээлийн эрхлэгч,<br>▪ 1998-2007 онд Монголбанк Хуулийн хэлтсийн мэргэжилтэн,<br>▪ 2007-2008 онд Зоос банк Эрх зүйн газрын захирал,<br>▪ 2008 оноос "Лекс коунсел" ХХК-ийн Гүйцэтгэх захирал,<br>▪ 2009 оноос Өмгөөлөгч |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н хараат бус гишүүн** |
|---|---|
| **Овог нэр** | Ш. Энхтөр |
| **Мэргэжил** | Өмгөөлөгч |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1997-2009 ХХБ-нд хуульч, ахлах хуульч, газар хэлтсийн дарга<br>▪ 2009-2013 Хадгаламж банк Газрын захирал<br>▪ 2013- Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо Өмгөөлөгч |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н гишүүн** |
|---|---|
| **Овог нэр** | А. Энхгэрэл |
| **Мэргэжил** | Бизнесийн үйл ажиллагааны менежмент бакалавр |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 2011-2012 Мянганы Сорилтын сангийн Худалдан авах газрын менежер<br>▪ 2012- Юнимат Эдюкэйшн ХХК-д гүйцэтгэх захирал |

| **Албан тушаал:** | **ТУЗ-н гишүүн** |
|---|---|
| **Овог нэр** | Г. Ганзориг |
| **Мэргэжил** | Цэргийн команд |
| **Иргэншил** | Монгол |
| **Боловсрол** | Дээд |
| **Ажилласан туршлага:** | ▪ 1980-1984 Салааны захирагч Ардын армийн 138 анги<br>▪ 1984-1988 ЗАБ-н ахлах офицер<br>▪ 1988-2011 онуудад Дайчилгаа эрхэлсэн штабын офицер, Шуурхай албаны офицер, Тоо бүртгэлийн офицер<br>▪ 2008-2011 Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан офицер, Нийслэлийн ЗДТГ-н цэргийн штаб<br>▪ 2011-2013 Цэргийн штабын орлогч дарга Нийслэлийн ЗДТГ-н цэргийн штаб<br>▪ 2016- Монгол базальт ХК, Термобазальт компани |

2087103
ПЮН0220
BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭР
1117245378
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

| Албан тушаал: | ТУЗ-н гишүүн |
|---|---|
| Овог нэр | Т. Билэгт |
| Мэргэжил | Математикч, Улс төр судлаач |
| Иргэншил | Монгол |
| Боловсрол | Дээд |
| Ажилласан туршлага: | ▪ 1971-1976 Ховд 10 жилийн сургуульд багш<br>▪ 1976-1981 Налайх захиргаа, намын хороо<br>▪ 1981-1996 онуудад Хэнтий Налайх Улаанбаатар хотын намын байгууллага<br>▪ 1992-1996 Хан Уул дүүргийн засаг дарга<br>▪ 1996-2005 Улаанбаатар хотын ХШХороо, НИТХ-д дарга<br>▪ 2005-2008 Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга<br>▪ 2008-2010 НЗД бөгөөд УБ хотын дарга<br>▪ 2010-2012 Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга<br>▪ 2016-Термо-базальт ХХК-д зөвлөх |

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 10.5.8. Компанийн удирдлага болон хяналтын багц эзэмшигчид бүртгэгдсэнээс хойш 6 -аас доошгүй сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх.</u>

“Монгол Базальт” ХХК нь 2018 оны 3 дугаар сарын 19-нпа өдрийн 0319/А-2 тоот албан бичигтээр Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д Монгол Базальт” ХК - ийн хувьцаа эзэмшигч Л. Ариунболд, П.Сайнбилэг, А.Энхгэрэл, А.Энхмаа, болон А.Энхжин нар нь 6 сарын хугацаагаар өөрсдийн эзэмшлийн хувьцааг худалдахгүй болох тухай мэдэгдлийг хүргүүлсэн байна.

**МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 12 дугаар зүйл. Хувьцааны бүртгэлийн II ангилалын шалгуур**

**Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:**

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.1. Өргөдөл гаргахаас өмнө 2-оос доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;</u>

“Монгол Базальт” ХК нь 2007 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн 01 тоот шийдвэрээр 2007 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр 901001085 улсын бүртгэлийн дугаартай, 5112494 регистрийн дугаартай, гадаад худалдаа, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулахаар байгуулагдсан байна. Тус компани нь 2007 оноос хойш 11 жилийн туршид үйл ажиллагааг эрхлэн явуулж ирсэн байна.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.2. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна.</u>

“Монгол Базальт” ХК-ийн 2016 болон 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “Бэст Фортуна Аудит ХХК” нь аудит хийсэн байна.

Аудитын дүгнэлтээр:

Бидний дүгнэлтээр “Монгол Базальт” ХК-ийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх хавсаргасан санхүүгийн тайлангууд (санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын

тушаалаар батлагдсан журам, заавар, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна.

Бидний дүгнэлтээр "Монгол Базальт" ХК-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх хавсаргасан санхүүгийн тайлангууд (санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний) нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, заавар, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна.

2015, 2016 болон 2017 оны аудитын тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.3.Компани бүртгэгдснээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капитал /эргэлтийн хөрөнгөөс богино хугацаат өр төлбөрийг хассан дүн/-тай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан байх.</u>

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллийн дагуу уг шалгуурыг хангаж байна. Санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.1.4. Дотоод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, хэрэв мөрддөггүй бол тайлбар гаргах</u>

"Монгол Базальт" ХК нь компанийн засаглалын кодексын дагуу дараах журмыг батлан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг байна. Үүнд:

- "Монгол Базальт" ХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 62 тоот тогтоолоор "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг батласан байна.
- "Монгол Базальт" ХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 68 тоот тогтоолоор "Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батласан байна.
- "Монгол Базальт" ХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 67 тоот тогтоолоор "Ногдол ашгийн журам"-ыг батласан байна.
- "Монгол Базальт" ХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 69 тоот тогтолоор "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна.
- "Монгол Базальт" ХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 70 тоот тогтолоор "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ыг баталсан байна.

**Хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:**

<u>МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.1. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно.</u>

"Монгол Базальт" ХК-ийн үүсгэн байгуулагч, одоогийн хувьцаа эзэмшигч нар нийтдээ 39,491,900 ширхэг хувьцаа эзэмших бөгөөд 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох бөгөөд тус компанийн нийт гаргасан хувьцаа тоо 56,417,000 ширхэг бөгөөд нэмж гаргаж буй худалдах үнэ 380 төгрөг байна. Иймд тус компанийн зах зээлийн үнэлгээ 21,438,460,000 төгрөг болохоор байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.2. Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалах

“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 084 тоот тогтоолоор 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 39,491,900 ширхэг энгийн хувьцааг нийт хувьцааны 70 хувиар тооцож, үлдэх 30 хувьтай тэнцэх буюу 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн байна. Мөн 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2/19-18 тоот тогтоолоор нийт компанийн 30%-тай тэнцэх 16,925,100 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, нээлттэй хүрээнд, олон нийтэд санал болгон, МХБ -ээр дамжуулан арилжаалахаар шийдвэрлэсэн байна. “Монгол Базальт” ХК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжин худалдан авах эрх эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байна. Иймд компанийн 30 хувийн хувьцааг олон нийт эзэмшихээр байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаандаа хэвээр хадгалах

“Монгол Базальт” ХК нь одоо 5 хувьцаа эзэмшигчтэй. Нэмж гаргаж буй 16,925,100 ширхэг хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авахгүй бөгөөд МХБ-ээр дамжуулан олон нийтэд, нээлттэй худалдан борлуулна. Иймд компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас доошгүй байна гэж үзэж байна.

МХБ-ийн ҮЦБЖ-ийн 12.2.4.Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд альваа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2018 оны 3 сарын 19-ний өдрийн 01/606 албан бичигт “Монгол Базальт” ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигч Л.Ариунболд, П.Сайнбилэг, А.Энхгэрэл, А.Энхмаа, А. Энхжин нарын эзэмшигч буй 39,491,900 ширхэг хувьцаа нь зээлийн барьцаа болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгаарлагдаагүй байна.

“Монгол Базальт” ХК-ийн нэмж гаргаж буй 16,925,100 ширхэг хувьцаа нь барьцаалагдаагүй, үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжиж, арилжаалагдах боломжтой.

**“Монгол Базальт” ХК нь МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.5.1-10.5.8 шаардлагууд, хувьцааны бүртгэлийн II ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагчийн шалгуур 12.1.1-12.1.4 хангаж байна. Мөн үнэт цаасны шалгуурын 12.2.1- 12.2.4 тус тус хангаж байна.**

**Эрх бүхийн байгууллагын шийдвэр**

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 084 тоот тогтоолоор хаалттай хувьцаат компанийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, нэмж хувьцаа гарган, олон нийтэд санал болгон арилжаалахтай холбоотой асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 084 тоот тогтоолоор дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

- "Монгол Базальт" хаалттай ХК –ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах, "Монгол Базальт" ХК-ийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 39,491,900 ширхэг энгийн хувьцааг нийт хувьцааны 70 хувиар тооцож, үлдэх 30 хувьтай тэнцэх буюу 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гаргах, нэмж гаргаж буй хувьцааны худалдах үнийг 380 төгрөгөөр тогтоож, нэг бүр нь 380 төгрөгийн худалдах үнэтэй, 16,925,100 ширхэг хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгон арилжаалж нийт 6,431,538,000 төгрөгийг санхүүжилтыг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэнг, нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эсэх, энэ нь их хэмжээний хэлцэлд тооцогдохыг дурьдаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.
- Мөн Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хавсралт №1 -ээр, нэмж хувьцаа гарган татан төвлөрүүлэх хөрөнгийг зарцуулалтын төлөвлөгөөг хавралт №2 -оор тус тус баталсан байна.

"Монгол Базальт" ХК-ийн ХЭХ-ийн 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын 2/19-18 тоот тогтоолоор дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

- "Монгол Базальт" хаалттай ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах, компанид нэмэлтээр 16,925,100 ширхэг энгийн хувьцаа буюу компанийн нийт хувьцааны 30% тай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргаж, нэмж гаргаж буй нэгж хувьцааны худалдах үнийг 380 төгрөгөөр тогтоон Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалахаар,
- Олон нийтээс татан төвлөрүүлэх нийт 6,431,538,000 /зургаан тэрбум дөрвөн зуун гучин нэг сая таван зуун гучин найман мянган/ төгрөгийг Хавсралт 1-д заасны дагуу компанид шинэ тоног төхөөрөмж худалдан авах, базальт ордын шинэчлэл, зээлийн эх үүсвэрийг бууруулах болон эртгэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор зарцуулахаар,
- Компанийн нээлттэй хувьцаат компани болгон өөрчилсөнтэй холбогдуулан компанийн дүрмийг нээлттэй хувьцаат компант болгон өөрчилж, дүрмийн төслийг нэмж гаргаж буй хувьцаа арилжаалагдсны дараа шинэ хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр, анхдугаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр,
- Олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж буй хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1-д заасны дагуу тогтоосон үнийн аргаар санал болгохоор,
- Нэмж гаргаж байгаатай холбогдуулан одоогийн энгийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцаатай хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд хувьцааг худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар тус тус шийдвэрлэсэн байна.

**Нэмж гаргаж буй хувьцааны үнэлгээ**

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээгээр компанийн зах зээлийн үнэлгээ 25.2 тэрбум төгрөг буюу нэгж хувьцааны үнэ 639 төгрөг гэж тодорхойлсон бөгөөд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 сарын 19-ний өдрийн 2/19-18 тоот тогтоолоор нэмж гарган олон нийтэд нээлттэй арилжаалах ба олон нийтэд санал болгох хувьцааны нэгж бүрийн үнийг 380 төгрөг байхаар тогтоосон. Үнэт цаасаа нийтэд санал болгохоос өмнөх компанийн бизнесийн үнэлгээ болох 639 төгрөгтэй харьцуулахад 40.5% хямдруулсан, үнэт цаасаа 30% нэмж гарган нийтэд санал болгосны дараах нийлбэр дүнгээс тооцсон 561.4 төгрөгтэй харьцуулахад 32.3% хямдруулсан үнээр санал болгож байна.

Иймд үнэт цаас гаргагч нь шинэ хувьцаа эзэмшигчдэд харьцангуй хямд үнээр өөрийн хувьцаагаа санал болгож байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлж байна.

**ДҮГНЭЛТ**

"Бумбат Алтай ҮЦК" ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа, шинжилгээ, тооцоолол, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн "Монгол базальт" ХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой гэж үзсэн байна.

Хувьцааны анхдагч зах зээлийн нэг бүрийн үнийг 380 төгрөгөөр, нийт 16,925,100 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон 6,431,538,000 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.
Энэхүү дүгнэлт нь ашигласан тооцоолол болон компанийн ирээдүйн төсөөлөл нь бодит биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд компанийн хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны үнэлгээнд нөлөөлж болох гадаад дотоод эрсдэлийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

Бид үнэт цаас гаргагчын хөрөнгийн үнэлгээ, бизнесийн үнэлгээнээс хямдруулж олон нийтэд санал болгож байгаа учраас хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлөөр Монгол Базальт ХК-н хувьцаа эзэмшигч болох боломжтой гэж үзлээ..

Компаний засаглалыг сайжруулан нээлттэй ид тод, хөрөнгө оруулагч нарт ойлгомжтой болгох үүднээс андеррайтерийн компанийн саналын дагуу "Монгол базальт" ХК нь нийцүүлэгч болон засаглалын зөвлөх үйлчилгээг олон нийтэд нээлттэй шалгаруулан өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр болсон билээ. Бид уг шийдвэрийг Монголын хөрөнгийн зах зээлд үлгэр жишээ болохуйц шийдвэр гэж үзэж байна.

**Дүгнэлтийг гаргасан:**

Б.Амарбаясгалан
Хөрөнгө оруулалтын ахлах менежер

Ц.Наран-Учрал
Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал

**Хянаж баталгаажуулсан:**

Ш.Энхмэнд
Гүйцэтгэх Захирал

Ш.Батжаргал
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

## 4.2 ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

ФLC САНХҮҮГИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ НӨХӨРГӨЛ

**"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ҮНЭН ЗӨВ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:** “МОНГОЛ БАЗАЛЬТ” Хаалттай ХК
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,Энхтайвны өргөн чөлөө, 10-3 тоот
Утас: +976-11-331058

**ДҮГНЭЛТ БИЧСЭН:** "ӨМГӨӨЛЛИЙН ФАЙНЭНШИЛ ЛОО КОНСАЛТИНГ" ХХН
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг ,
Экспресс цамхаг, 601 тоот
Утас: 70006967

Улаанбаатар хот 2018 он

**Нэг. Хууль зүйн дүгнэлтийн үндэслэл**

"Өмгөөллийн Файнэншил Лоо Консалтинг" ХХН нь 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрх авч Хороонд бүртгэгдсэн (*Хавсралт: Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гэрчилгээний хуулбар*) ба энэхүү бүртгэлийг үндэслэн олон нийтэд анх удаагаа хувьцаагаа санал болгохоор бэлтгэж байгаа "Монгол базальт" Хаалттай ХК-д хууль зүйн үйлчилгээ үзүүлэх 16/16 тоот гэрээг 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан.

Энэхүү дүгнэлтийг хийхдээ Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Компанийн засаглалын кодекс", Улсын бүртгэлийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын тодорхойлолт, Нийгмийн даатгалын лавлагаа, банкны тодорхойлолт (*Хавсралт: Төрийн байгууллагууд болон банкнаас ирүүлсэн тодорхойлолт, лавлагаа*) зэргийг ашиглан "Монгол базальт" Хаалттай ХК-ийн компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, Компанийн дүрэм, засаглалын болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны журмууд, компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой дотоод журмууд болон үнэт цаасны танилцуулгад тусгагдсан гэрээ хэлцэлүүд, үнэт цаас гаргах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, манай дүгнэлтэд шаардлагатай гэж үзсэн бусад материалуудыг судлан хууль зүйн дүгнэлт хийсэн болно.

“Монгол базальт” Хаалттай ХК нь Компанийн тухай хуулийн 3.7 (”Нээлттэй хувьцаат компани” гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ), 4 (Хувьцаат компани), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 (Үнэт цаас), 6 (Үнэт цаас гаргах), 7 (Үнэт цаас гаргагч), 11 (Үнэт цаасыг нийтэд санал болгох) дүгээр зүйлүүдэд заасны дагуу нээлттэй Хувьцаат компани хэлбэртэй болж нийтэд хувьцаагаа санал болгох эрх зүйн үндэслэлтэй ба ийнхүү хувьцаагаа нийтэд санал болгохын тулд Компанийн тухай хуулийн 9.1-д “Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Хороо бүртгэж, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгоно.” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр Үнэт цаасны танилцуулга болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж байгаа болно.

"Өмгөөллийн Файнэншил Лоо Консалтинг" ХХН нь энэхүү хууль зүйн дүгнэлтийг хийхдээ “Бумбат алтай ҮЦК” ХХК-ийн боловсруулсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан бичиг баримт нь бодит үнэн, бичиг баримтад гарын үсэг зурсан этгээд нь гарын үсэг зурах эрх бүхий, бичиг баримтад дарсан тамга тэмдэг болон ирүүлсэн хуулбар хувиуд нь эх хувьтайгаа бүрэн нийцэж байгаа учраас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв болохыг нотолж дараах 12 асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

### Хоёр. Хууль зүйн дүгнэлт

**2.1. Компани хуулийн дагуу байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх:**

Улсын бүртгэлийн 9010001085 тоот гэрчилгээний дугаартай, 5112494 тоот регистрийн дугаартай Монгол Улсын хуулийн этгээд "Монгол базальт" Хаалттай ХК нь /цаашид "компани" гэх/ 2007 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. 2008 онд нийтэд санал болгон хувьцаа гаргахаар Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авч компанийг Хувьцаат компани хэлбэртэйгээр 2008 онд улсын бүртгэлд бүртгүүлсэн хэдий ч хувьцаагаа нийтэд санал болгоогүй тул 2015 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 15/01 тоот тогтоолоор дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд Хаалттай ХК хэлбэрээр бүртгүүлсэн. Гэвч Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 8-р сарын 14-ний өдөр баталсан “Хаалттай хувьцаат компанийн тухай журам”, 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-д заасны дагуу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хувьцаагаа бүртгүүлээгүй байж байгаад 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Хаалттай ХК хэлбэрээр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлсэн байна. (*Хавсралт: Хуулийн этгээдийн гэрчилгээ, Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн албан бичгийн хуулбар*)

Үнэт цаас гаргагч нь Нэг үүсгэн байгуулагчтай бөгөөд үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, компанийн гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч Л.Ариунболд болно. Компани нь Лхагважавын Ариунболд, Пүрэвбанзрагчийн Сайнбилэг, Ариунболдын Энхгэрэл, Ариунболдын Энхмаа, Ариунболдын Энхжин гэсэн 5 хувьцаа эзэмшигчтэй.

Компани нийтдээ 3 949 190 000 /гурван тэрбум есөн зуун дөчин есөн сая нэг зуун ерэн мянган/ төгрөгийн өөрийн хөрөнгөтэй компани юм.

Компани нь гадаад худалдаа, барилгын материалын үйлдвэрлэл /код: 51100/ эрхэлдэг аж ахуйн нэгж бөгөөд компанийн оршин байгаа газрын хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Flamingo tower-ын 7 давхар Утас: 331058, 91118808.

“Монгол базальт” хаалттай ХК нь Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон татварын хэлтэс дээр бүртгэлтэй бөгөөд татварын болон нийгмийн даатгалын зөрчилгүй байгаа болно.

“Монгол базальт” Хаалттай ХК нь Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна.

Буянт Алтай 2087103 ПЮН0238

BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР 5112494 ДУЛААН ТУСГААРЛАГЧ

**2.2 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага, туршлагын байдал:**

**Компанийн төлөөлөн удирдах зөвлөл:**

Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь Компанийн дүрмийн 6.17-д заасны дагуу 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 2016 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг томилсон байна.

**1. Пүрэвбанзрагчийн Батмөнх** /ТУЗ-ын дарга/

Бизнесийн менежмент, хуульч мэргэжилтэй. 2007 оноос хойш "Монгол базальт" Хаалттай ХК-д ажиллаж байгаа бөгөөд компанид Ерөнхий удирдлага эрхэлсэн, үйлдвэрлэл эрхэлсэн, судалгаа хөгжил, инноваци эрхэлсэн захирлын албан тушаалуудыг гүйцэтгэдэг болно. П.Батмөнх нь Компанийн засаглалын үндэсний төвөөс зохион байгуулдаг компанийн засаглалын сургалтанд 2013 оны 5 дугаар сард хамрагдаж 09300036 тоот гэрчилгээтэй байна.

**2. Пүрэвбанзрагчийн Сайнбилэг** /ТУЗ-ын гишүүн/

Санхүү, нягтлан бодогч мэргэжилтэй. 2007 оноос хойш "Монгол базальт" Хаалттай ХК-д ажиллаж байгаа бөгөөд компанид Санхүү эрхэлсэн захирлын албан тушаал хашдаг бөгөөд Компанийн засаглалын сургалтад 2017 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн сургалтад хамрагдаж 0730934 дугаартай гэрчилгээ авсан.

**3. Лхагважавын Ариунболд** /ТУЗ-ын гишүүн/

Барилгын технологийн тоног төхөөрөмжийн инженер механик мэргэжилтэй. Мэргэжлээрээ 26 дахь жилдээ ажиллаж байгаа. 2005 онд чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн ба "Монгол базальт" компанийн үүсгэн байгуулагч бөгөөд компанид гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлдэг. Л.Ариунболд нь Компанийн засаглалын үндэсний төвөөс зохион байгуулдаг компанийн засаглалын сургалтанд 2013 оны 5 дугаар сард хамрагдаж 09300023 тоот гэрчилгээ авсан байна.

**4. Ариунболдын Энхгэрэл** /ТУЗ-ын гишүүн/

Бизнесийн үйл ажиллагааны менежмент, санхүүгийн менежер мэргэжилтэй. 2012 оноос хойш “Монгол базальт” Хаалттай ХК-д төсөл хариуцсан захирлаар ажилладаг. Компанийн засаглалын сургалтад 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн сургалтаар 0230188 гэрчилгээ авсан байна

**5. Түдэвийн Билэгт** /ТУЗ-ын гишүүн/

Математикч, улс төр судлаач мэргэжилтэй. 31 жил төр, захиргааны байгууллагад ажилласан. Улаанбаатар хотын засаг дарга, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын алба хашиж байсан туршлагатай. Компанийн засаглалын сургалтад сууж сертифкат аваагүй аваагүй байна.

**6. Галбадрахын Ганзориг** /ТУЗ-ын гишүүн/

Цэргийн команд мэргэжилтэй. Төрийн захиргааны болон тусгай албанд 33 жил ажилласан. 2016 оноос эхлэн “Монгол базальт” Хаалттай ХК, термо-базальт компанид ажиллаж байгаа. Компанийн засаглалын сургалтад 2017 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн сургалтад хамрагдаж 0730913 гэрчилгээ авсан.

**7. Бадрахын Шаравсамбуу** /ТУЗ-ын бус гишүүн/

Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй. 46 жил улсад ажилласан. Худалдаа, бэлтгэлийн яамны сайд, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дэд даргаар ажиллаж байсан. Компанид хараат бус ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа. Компанийн засаглалын сургалтад 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 0130844 гэрчилгээтэй байна.

**8. Чансаагийн Зоригтбаатар** /ТУЗ-ын хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Банк, санхүүгийн эдийн засагч, хуульч мэргэжилтэй. Банк, санхүүгийн системд 16 жил, өмгөөлөгчөөр 18 жил ажилласан туршлагатай. Компанийн ТУЗ-ын хараат бус гишүүнээр ажилладаг. Компанийн засаглалын үндэсний төвөөс зохион байгуулдаг компанийн засаглалын сургалтанд 2013 оны 5 дугаар сард хамрагдаж 09300020 тоот гэрчилгээтэй байна.

**9. Шаравсамбуугийн Энхтөр** /ТУЗ-ын хараат бус гишүүн/

Эрх зүйч, банкны удирдлага мэргэжилтэй. Банк санхүүгийн салбарт 16 жил ажилласан. Компанийн ТУЗ-ын хараат бус гишүүнээр ажилладаг. Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс зохион байгуулдаг Компанийн засаглалын сургалтанд 2013 хамрагдаж Компанийн засаглалын 0220043 тоот гэрчилгээ эзэмшдэг болно.

Компанийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 75.4, Компанийн засаглалын кодексийн 5.2.2, 5.2.3, 5.2.4-д заасан шаардлагуудыг хангаж 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ-тэй, тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.

Компанийн тухай хуулийн 75.8, Компанийн засаглалын кодексийн 5.2.1-д заасан компанийн засаглалын гэрчилгээг ТУЗ-ийн гишүүдийн 8 гишүүн авсан байгаа бол 1 гишүүн нь аваагүй байна. Мөн 2 гишүүн нь Компанийн засаглалын кодекст заасан мэргэжлийн шаардлага хангахгүй байна. ТУЗ-ийн гишүүд нь удирдах ур чадвар, дадлага туршлага хангалттай гэж үзэж байна.

ТУЗ нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа болно.

**Компанийн гүйцэтгэх удирдлага:**

“Монгол базальт” хаалттай ХК-ийн гүйцэтгэх захирлаар Л.Ариунболд ажилладаг бөгөөд 2005 онд чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн ба "Монгол базальт" компанийн үүсгэн байгуулагч юм. Тэрээр базальт үйлдвэрлэлийн асуудлаар мэргэшсэн бөгөөд энэхүү компанийг үүсгэн байгуулж удирдаж яваа ажлын туршлагатай бөгөөд компанийг удирдах чадвар дадлага, туршлага хангалттай гэж үзэж байна.

**Бусад эрх бүхий албан тушаалтан:**

Ерөнхий удирдлагын хэлтэс, Үйлдвэрийн хэлтэс, Судалгаа хөгжил, инновацийн хэлтсүүдийн захирлаар П.Батмөнх ажилладаг ба эдгээрээс гадна ТУЗ-ийн даргын үүргийг гүйцэтгэдэг болно. Тэрээр бизнесийн менежмент, хуульч мэргэжилтэй. 2007 оноос хойш "Монгол базальт" ХХК-д ажиллаж байна. Компанийн тухай хуулийн давхар эрхэлж болохгүй албан тушаалтай зөрчилдөөгүй, мэргэжил, туршлага ур чадварын хувьд базальт үйлдвэрлэлийн салбарт тогтвортой ажилласан, мэргэшсэн учраас мэргэжил, туршлагын хувьд хуулийн болон Компанийн засаглалын кодексийн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна. Гэхдээ нээлттэй хувьцаат компани

болсоны дараагаар П.Батмөнхийн гүйцэтгэх удирдлагын 3 хэлтэс болон ТУЗ-ийн даргаар зэрэг ажиллаж байгаа байдалд анхаарах шаардлагатай.

Санхүү эрхэлсэн хэлтсийн захирал П.Сайнбилэг нь Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд компанийн 19 хувийг эзэмшдэг. Компанийг үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн компанийн санхүүгийн асуудлыг хариуцан ажилласан ба хийж байгаа ажил нь Компанийн тухай хуулийн давхар эрхэлж болохгүй албан тушаалтай зөрчилдөөгүй, мэргэжил, туршлага ур чадварын хувьд базальт үйлдвэрлэлийн салбарт тогтвортой ажилласан, мэргэшсэн учраас мэргэжил, туршлагын хувьд хуулийн болон Компанийн засаглалын кодексийн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Худалдаа эрхэлсэн захирлаар Д.Сайнбаатар нь инженер эдийн засагч мэргэжилтэй, тус компанийг байгуулагдсан цагаас хойш инженер, эдийн засагч, төсөл хариуцсан захирлаар ажилласан ба хийж байгаа ажил нь Компанийн тухай хуулийн давхар эрхэлж болохгүй албан тушаалтай зөрчилдөөгүй, мэргэжил, туршлага ур чадварын хувьд базальт үйлдвэрлэлийн салбарт тогтвортой ажилласан, мэргэшсэн учраас мэргэжил, туршлагын хувьд хуулийн болон Компанийн засаглалын кодексийн шаардлагыг хангаж байна гэж үзэж байна.

Эрх бүхий албан тушаалтнууд болох П.Батмөнх, П.Сайнбилэг, Д.Сайнбаатар нар нь ажлын хангалттай туршлагатай, базальт үйлдвэрлэлийн асуудлаар мэргэшсэн ба Компанийн тухай хуулийн 84.3-т заасан хязгаарлалтад хамаарахгүй байгаа тул хууль, компанийн засаглалын кодекст заасан чадвар, дадлага туршлага хангаж байна.

**2.3. Компанийн дүрэм нь Компанийн тухай хуульд нийцсэн эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Компанийн тухай хуулийн 10.1-д заасан шаардлагыг хангаж Компанийн дүрмийн 1.1, 1.3-т "Монгол базальт" хаалттай ХК гэж компанийн нэр, хэлбэрийн ялгах байдлыг зааж өгсөн байна.

Компанийн тухай хуулийн 10.3-т заасан шаардлагын дагуу дүрмийн 1.8-д "Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэж нэрлэх/ баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байна." гэж, түүнчлэн Компанийн тухай хуулийн 10.4-т заасан шаардлагын дагуу компанийн дүрмийн 1.4-д "Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Flamingo tower-ын 7 давхар" гэж компанийн оршин байгаа газрыг зааж хуулийн шаардлага хангасан байна.

**Хоёр. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл**

Компанийн тухай хуулийн 8.1-д заасны дагуу дүрмийн 2.1-д "барилгын материалын үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа, төсөл хөтөлбөр, сургалт судалгаа"-ны үйл ажиллагаа эрхлэхээр, Компанийн тухай хуулийн 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15, 14.6-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын БМҮ 090/13 тоот "Эрдэс /чулуун/ хөвөнгийн үйлдвэрлэл эрхлэх" тусгай зөвшөөрлийг 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 3 жилийн хугацаатай авсан байна. Компанийн дүрэмд заасан "гадаад дотоод худалдаа, төсөл хөтөлбөр, сургалт судалгаа"-ны үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй ба барилгын материалын үйлдвэрлэлийн зөвшөөрөл авсан нь Компанийн тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцэж байна.

**Гурав. Хувь нийлүүлсэн хөрөнгө**

Компанийн дүрмийн 3.1-д "Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 3 949 190 000 /Гурван тэрбум есөн зуун дөчин есөн сая нэг зуун ерэн мянган/ төгрөгийн үнийн дүн бүхий 39 491 900 ширхэг хувьцаа байна.", 3.3-д "Компанийн давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай" хуульд заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зохицуулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрт заасан байна." гэж заасан нь Компанийн тухай хуулийн 32.3-т заасан хуулийн зохицуулалттай нийцэж байгаа бөгөөд одоогоор давуу эрхийн хувьцаа гаргаагүй байна.

**Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага**

Компанийн дүрмийн 4.1-д Компанийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, нийт хувьцаанд эзлэх хувийг заасан, 4.2-т хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бүх саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх, татан буугдах үед үлдсэн эд хөрөнгө худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх, хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах зэргийг зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 34, 37, 38 дугаар зүйлүүдэд заасан хуулийн шаардлагыг хангасан байна.

**Тав. Компанийн үнэт цаасыг гаргах худалдах, эргүүлэн худалдан авах**

Компанийн дүрмийн тавдугаар бүлэгт заасан үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн худалдан авах зохицуулалтууд нь Компанийн тухай хуулийн Долдугаар бүлгийн зохицуулалттай таарч хуулийн шаардлагыг хангаж байна.

**Зургаа. Компанийн удирдлага**

"Монгол базальт" хаалттай ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн А, Б, В заалтуудаар Компанийн удирдлагыг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага гэж заасан ба энэ нь Компанийн тухай хуулийн Есдүгээр бүлгийн 59, 75, 83 дугаар зүйлүүдэд заасан компанийн удирдлагуудын талаар заасан зохицуулалттай нийцэж хуулийн шаардлага хангаж байна.

Гэвч дүрмийн 6.19.9-д "ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлыг гадаадад томилолтоор ажиллах удирдамж төсвийг батална. ТУЗ-ийн хурлаар томилолтын үр дүнг хэлэлцэнэ", 6.19.17-д "Эрх бүхий албан тушаалтнаас компанид учруулсан хохирлын нэхэмжлэл гаргах", 6.19.19-д "Компаний ажилтан нарын нийгмийн асуудалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх" зэрэг зохицуулалт нь "ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулна." гэсэн дүрмийн заалтыг биелүүлэхэд хүндрэлтэй буюу ойр ойрхон хуралдуулах, зарим талаараа гүйцэтгэх удирдлагад олгож болох эрх хэмжээг ТУЗ дээр хадгалсан буюу хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зохицуулалттай байна.

Дүрмийн 6.19.21-д "Компанийн дотоод аудитын газрын дарга, ажилтнуудыг томилох, цалин, хөлсний хэмжээг тогтоох, ажиллах журмыг батлах" зэрэг зохицуулалт нь дэвшилттэй зохицуулалт болсон байна.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэд Аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодыг хуулийн шаардлагад нийцүүлэн 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба үүнд хөндлөнгийн 2 гишүүнийг томилсон байна.

**Долоо. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага**

Компанийн дүрмийн 7.1-7.4-т Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон тэдгээрийн хүлээх хариуцлагыг заасан байна. 7.1-д "ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын баг гишүүд, ерөнхий нягтлан бодогч, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно." гэж заасан нь Компанийн тухай хуулийн 84.1-д нийцэж хуулийн шаардлага хангасан байна.

**Найм. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, ногдол ашгийн хуваарилалт**

Компанийн дүрмийн 8 дугаар бүлгийн А хэсгээр Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлангийн асуудлыг Б хэсгээр санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг ямар хугацаанд гаргах, санхүүгийн тайлангийн бүрдэл хэсгүүдийн тухай зохицуулсан ба энэхүү зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 95, 96 дугаар зүйлд заасан зохицуулалтыг тусгасан хэдий ч 96.4-т заасан Удирдах зөвлөлд хүргүүлэх тайланд тусгах асуудлуудыг нарийвчлан тусгаагүй байна. 8 дугаар бүлгийн В хэсгээр зохицуулсан ногдол ашгийн хуваарилалтын зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлүүдэд зохицуулсантай нийцэж хуулийн шаардлага бүрэн хангаж байна.

**Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт**

Компаийн тухай хуулийн 94.7-д заасан шаардлагын дагуу дүрмийн 9.6-д “Ээлжит бус шалгалтыг Төлөөлөн удирдах зөвлөл, түүний аудитын хороо, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардсанаар хэдийд ч хийж болно.” гэж заасан нь хуулийн шаардлагыг бүрэн хангасан байна.

**Арав. Нэгдмэл сонирхолтой этгээд, компанийг татан буулгах**

Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлд заасан компанийг татан буулгах тохиолдол болон татан буулгахад баримтлах зохицуулалтыг дүрмийн 11 дүгээр бүлгээр зохицуулсан бол Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлээр нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон ба эдгээр бүлгүүд нь хуулийн шаардлагыг бүрэн хангаж байна.

"Монгол базальт" хаалттай ХК-ийн дүрэм нь нягт нямбай боловсрогдсон, хуулийн шаардлагыг бүрэн хангасан дүрэм байна. Гэвч компанийн дүрэмд их хэмжээний хэлцэл болон сонирхолын зөрчилтэй хэлцэлийн зохицуулалт тусгагдаагүй байгааг нээлттэй хувьцаат компани болсны дараагаар нэмж оруулах шаардлагатай.

**2.4. Компанийн дүрэм нь Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

Компанийн дүрэм нь Компанийн засаглалын кодексийн 2 дугаар бүлгийн Хувьцаа эзэмшигчдийн эрхийн зохицуулалт, 4 дүгээр бүлгийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн зохицуулалт, 6 дугаар бүлгийн Гүйцэтгэх удирдлагын зохицуулалт, 7 дугаар бүлгийн санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлын зохицуулалтын хүрээнд боловсрогдож батлагдсан байгаа тул “Монгол базальт” хаалттай ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодексд нийцэж байна.

**2.5 Компанийн засаглалын журмууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

"Монгол базальт" хаалттай ХК нь 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 62 дугаар тогтоолоор “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам”, 67 дугаар тогтоолоор “Ногдол ашгийн журам”, 68 дугаар тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, 69 дүгээр тогтоолоор “Мэдээллийн үйл ажиллагааны журам” 70 дугаар тогтоолоор “Дотоод хяналтын журам”-уудыг шинээр баталсан бөгөөд эдгээр засаглалын журмууд нь Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон холбогдох журам, дүрмүүдэд бүрэн нийцэж байгаа бөгөөд хууль зүйн хүчин төгөлдөр журмууд байгаа болно.

**2.6 Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

"Монгол базальт" ХХК нь 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдөр компанийн "Хөдөлмөрийн дотоод журам"-аа шинэчлэн баталсан бөгөөд үүнээс гадна "Касс дахь бэлэн мөнгөний ажиллагааны бүртгэлийн журам", "Бэлэн бус төлбөр тооцооны журам", "Авлагын бүртгэлийн журам", "Дараа тайлангийн бүртгэлийн журам", "Өр төлбөрийн бүртгэлийн журам", "Бараа материалын бүртгэлийн журам", "Үндсэн хөрөнгө бэлтгэх журам", "Орлогын бүртгэлийн журам", "Зардлын бүртгэлийн журам", "Албан томилолтын зардлын бүртгэлийн журам", "Бүртгэлийн дотоод хяналтын журам", "Хөрөнгийн тооллого явуулах, эд хариуцагчийн тооцоо бодох журам"-ууд нь Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт зэрэгт бүрэн нийцэж байгаа бөгөөд нягтлан бодох бүртгэлийн журмуудыг нарийвчлан баталсан нь давуу талтай байна. Компанийн дотооод үйл ажиллагааны журмууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст бүрэн нийцсэн байна.

**2.7 Компанийн бусадтай байгуулсан худалдах-худалдан авах гэрээ болон бусад гэрээ хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

"Монгол базальт" хаалттай ХК нь Улаанбаатар хотод барилга барьж, зах зээлд нийлүүлдэг "Цаст констракшн" ХХК, "Топгласс" ХХК, "Тэдмэнт" ХХК, "Royal style" ХХК, "Түрүү гарав" ХХК, "Говийн дигваранз" ХХК, "Гарнет бриллиант" ХХК, "Хан Ён И Эм Си" ХХК, "NCD групп" ХХК, "Жигүүр гранд групп" ХХК, "Эм Си Эс Пропертийз" ХХК зэрэг компаниудад базальтвүүл чулуун хөвөн хавтанг Худалдах-худалдан авах гэрээний үндсэн дээр сүүлийн 3 жилийн хугацаанд худалдсан бөгөөд энэхүү гэрээнүүд нь Иргэний хуулийн худалдах-худалдан авах гэрээний зохицуулалт болон Иргэний хуулийн ерөнхий зарчмыг баримтлан хийгдсэн байна.

"Соёмбо даатгал" ХХК-тай 1 жилийн хугацаатай Автотээврийн хэрэгсэлийн даатгал, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, Хүнд болон тусгай зориулалтын машин механизм, Гэнэтийн ослын даатгал гэсэн 4 төрлийн 28С150031 тоот Даатгалын гэрээ байгуулсан байна. Энэхүү багц даатгалын гэрээ Даатгалын тухай хууль, Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль зэрэгт нийцсэн гэрээ болсон байна.

**2.8 Сүүлийн 1 жилийн дотор байгуулсан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

"Монгол базальт" хаалттай ХК нь "Цаст констракшн" ХХК-тай 2015 оны 08-р сарын 08-ны өдөр 44 485 100 төгрөгийн худалдах худалдан авах гэрээ, 2016 оны 02-р сарын 17-ны өдөр 444 846 050 төгрөгийн худалдах-худалдан авах гэрээг тус тус байгуулж бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, төлбөрийг авсан. "Топгласс" ХХК-тай 2015 оны 09-р сарын 21-ний өдөр 50 668 028 төгрөгийн худалдах-худалдан авах гэрээг, 2015 оны 11-р сарын 09-ний өдөр 49 116 000 төгрөгийн худалдах-худалдан авах гэрээг тус тус хийж барааг нийлүүлэн, төлбөрийг авсан. "Тэдмэнт" ХХК-тай 2015 оны 11-р сарын 06-ны өдөр 4 226 288 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээ хийж бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, төлбөрийг авсан. "Royal style" ХХК-тай 2015 оны 10-р сарын 13-ны өдөр гэрээ байгуулж 1 091 700 төгрөгийн бараа нийлүүлсэн. "Түрүү гарав" ХХК-тай 2015 оны 09-р сарын 19-нд гэрээ 43 367 907 төгрөгийн гэрээ байгуулж, бараа нийлүүлсэн. "Говийн дигваранз" ХХК-тай 2015 оны 09-р 18-ны өдөр 32 016 000 төгрөгийн гэрээ байгуулж, бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн. "Гарнет бриллиант" ХХК-тай 2015 оны 09-р сарын 09-ний өдөр 80 877 600 төгрөгийн гэрээ байгуулж, бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн. "Хан Ён И Эм Си" ХХК-тай 2015 оны 08-р сарын 20-ны өдөр 5 568 000 төгрөгийн, 2015 оны 07-р сарын 07-ны өдөр 28 552 500 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээг тус тус хийж, бараа нийлүүлсэн байна. "NCD групп" ХХК-тай 2015 оны 01-р

сарын 18-ны өдөр 14 007 490 төгрөгийн, 2015 оны 06-р сарын 15-ны өдөр 72 438 734 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээг тус тус хийж бараа бүтээгдэхүүнийг нийлүүлсэн байна. “Эм Си Эс Пропертийз” ХХК-тай 2016 оны 10-р сарын 10-ны өдөр 666 821 650 төгрөгийн гэрээ хийж, бараа нийлүүлсэн, “Дашваанжил” ХХК-тай 2016 оны 11 сарын 21-ний өдөр 10 646 625 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээ байгуулж, бараа нийлүүлсэн. “ДЦС-4” ТӨХК-тай 2016 оны 09-р сарын 30-ны өдөр 104 000 000 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээ хийсэн, “Жи Ай Пи” ХХК-тай 2016 оны 12 сарын 13-ны өдөр 72 053 630 төгрөгийн гэрээ байгуулж, бараа нийлүүлсэн, “Оюу толгойн гүний уурхайн чухал барилга байгууламжийн төсөл”-тэй 2016 оны 11 сарын 24-ний өдөр 16 275 600 төгрөгийн Худалдах-худалдан авах гэрээ, “Принзес Озеро” ХХК-тай 2016 оны 10-р сарын 16-ны өдөр 30 537 450 төгрөгийн гэрээ байгуулсан байна.

"Соёмбо даатгал" ХХК-тай 2017 оны 09-р сарын 29-ний өдрөөс 1 жилийн хугацаатай Автотээврийн хэрэгсэлийн даатгал, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, Хүнд болон тусгай зориулалтын машин механизм гэсэн 3 төрлийн 28С170002 тоот Даатгалын гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр 297 700 000 төгрөгийн үнэлгээтэй Автотээврийн хэрэгсэл, 47 736 000 төгрөгийн үнэлгээтэй хүнд болон тусгай зориулалтын машин механизм, 45 000 000 төгрөгийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, нийтдээ 390 439 000 төгрөгийн үнэлгээтэй даатгалыг хийлгэсэн ба даатгалын хураамжид 4 520 181 төгрөг төлсөн байна. Энэхүү багц даатгалын гэрээ Даатгалын тухай хууль, Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль зэрэгт нийцсэн гэрээ болсон байна.

Түүнчлэн 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Капитал банкнаас 720,500,000 төгрөгийн зээл авсан бөгөөд энэхүү зээл хэвийн ангилалд байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан компанийн активын 25 хувь буюу түүнээс дээш хэмжээний буюу их хэмжээний хэлцэл хийгээгүй, түүнчлэн Компанийн тухай хуулийн 89.1-д заасан Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байгаа болно.

**2.9 Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

"Монгол базальт" хаалттай ХК нь Барилга хот байгуулалтын яамнаас олгосон БМҮ 118/16 дугаартай Барилгын материал үйлдвэрлэл: Эрдэс /чулуун/ хөвөнгийн үйлдвэр эрхлэх тусгай зөвшөөрлийг 2016 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр авсан ба энэхүү тусгай зөвшөөрөл нь 5 жилийн хугацаатай ба 2021 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл хүчинтэй байна. (*Хавсралт: Барилга, хот байгуулалтын яамнаас олгосон Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл, гэрээний хуулбар*)

Компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага Л.Ариунболд нь Дэлхийн оюуны өмчийн байгууллагын 957445 тоот Basaltwool бүтээгдэхүүний гэрчилгээ, Монгол Улсын хууль зүйн яамны 9872 дугаартай “Rockwool” барааны тэмдэгийн гэрчилгээ, базальт чулуун мяндсаар арматур үйлдвэрлэх арга 2132 ашигтай загварын гэрчилгээ, 6783 тоот Basaltwool барааны тэмдэгийн гэрчилгээ, 6810 дугаартай “Эрдэс чулуун хөвөн” барааны тэмдэгийн гэрчилгээг эзэмшдэг ба эдгээрийн хугацаа 2027 оны 11-р сарын 12-ны өдрийг хүртэл сунгасан байна. Дээрх барааны тэмдгүүд нь компанийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал Л.Ариунболдын нэр дээр байгаа бөгөөд Патент, барааны тэмдэгтийн эрхийг шилжүүлэн ашиглуулах гэрээг 2018 оны 01 дүгээр

сарын 08-ны өдөр байгуулж "Монгол базальт" ХК нь хугацаагүйгээр шилжүүлсэн байна. Компанийн тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдэгээр аливаа төрлийн үүргийн гүйцэтгэл хангуулах тухай хийсэн хэлцэл байхгүй байна. (*Хавсралт: Барааны тэмдэг, ашигтай загварын гэрчилгээний хуулбар*)

Компанийн тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдэгээр аливаа төрлийн үүргийн гүйцэтгэл хангуулах тухай хийсэн хэлцэл байхгүй байна.

**2.10 Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэхэд өгөх хууль зүйн дүгнэлт:**

Тус компани нь Ашигт малтмалын газраас олгосон MV-017426 дугаартай Төв аймгийн Баяндэлгэр сумын Ногоон уул гэдэг газар 32.39 гектар талбайд ашигт малтмал ашиглахыг зөвшөөрсөн 9010001085 тоот гэрчилгээтэй бөгөөд гэрчилгээний хугацаа 2043 оны 12 дугаар сарын 02-ыг хүртэл хүчинтэй, хүчин төгөлдөр Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байна. (*Хавсралт: Ашигт малтмал, ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар*)

Үнэт цаасны танилцуулгад компани нь 16 барилга, байгууламж, 22 тоног төхөөрөмж, 14 тээврийн хэрэгсэлтэй гэж заасан байгаа боловч улсын бүртгэлт бүртгүүлж гэрчилгээ авсан барилга байгууламж 1 ширхэг, 7 ширхэг тээврийн хэрэгсэлийн гэрчилгээ бүрэн байна. Улсын бүртгэлд бүртгүүлээгүй, техникийн паспорт дутуу байгаа нь хууль зөрчсөн зүйл байхгүй хэдий ч цаашдаа улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх, баталгаажуулах шаардлагатай болно. (*Хавсралт: Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ*)

Түүнчлэн компани нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Моннаба ХХК-ийн зүүн урд талд 0293323 дугаартай Агуулахын зориулалттай 4203 метр квадрат газрыг 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 5 жилийн хугацаатай эзэмшдэг бөгөөд газар эзэмших гэрээ, гэрчилгээ хүчин төгөлдөр байна. Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэгт 000300476 дугаартай 10000 метр квадрат Үйлдвэрийн зориулалттай газар эзэмшдэг бөгөөд 2014 оны 04 сарын 14-ний өдрөөс 8 жилийн хугацаатай эзэмшиж байгаа ба газар эзэмших гэрээ, гэрчилгээ хүчин төгөлдөр, хуулийн дагуу байна. Мөн Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороонд Агуулах, аж ахуйн зориулалттай 9462 метр квадрат 0232516 тоот гэрчилгээний дугаартай газрын 5 жилийн хугацаагаар эзэмшиж байна. Энэхүү газар эзэмших эрхийн хугацаа 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр дуусгавар болсон байна. Гэвч газар эзэмшүүлэх гэрээний 5.5 дахь заалтын дагуу хугацаа дуусгавар болсноос хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй гэж заасан учир энэхүү эрх нь хүчинтэй байна. Энэхүү газар эзэмших хүсэлтээ үргэлжлүүлэн сунгах тухай хүсэлтээ холбогдох газрын албанд хүргүүлсэн ба газар эзэмших гэрчилгээг сунгахгүй байх нөхцөл үүсээгүй, хуулийн дагуу эзэмшиж байна. (*Хавсралт: Газар эзэмших эрхийн гэрчилгээ*)

Эдгээрээс Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Үйлдвэрийн тойруу, 132 тоот хаягт байрлах үйлдвэрийн зориулалттай 1944 метр квадрат талбайтай, 153 автомашины гражийг Капитал банкны зээлийн барьцаанд 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр барьцаалсан ба зээлийн гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа учраас зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх болон бусад эд хөрөнгө хууль зүйн асуудалгүй байна.

Компани өөрийн нэрээр болон дээрх хөрөнгөтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өмнө ямарваа нэгэн үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, Шударга, өрсөлдөөн

хэрэглэгчийн төлөө газраас лавлагаа, тодорхойлолт авсан ба эдгээрээс тус компанийг шүүхээс тогтоосон өр төлбөргүй, Өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчөөгүй, гаалийн болон татварын өргүй гэсэн тодорхойлолт ирсэн байна. (*Хавсралт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэгчлэгчийн төлөө газар,*)

Компанийн үл хөдлөх хөрөнгө болон бусад эд хөрөнгө нь хүчин төгөлдөр бичиг баримтаар батлагдаж байгаа бөгөөд Капитал банктай байгуулсан гэрээний дагуу нэг үл хөдлөх хөрөнгө зээлийн барьцаанд байна.

**2.11 Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх**

“Монгол базальт” хаалттай ХК нь чулуун хөвөн үйлдвэрлэлийг илүү боловсронгуй болгох, олон улсад экспортлох чанарын шаардлага хангасан нарийн ширхэг бүхий хөвөн үйлдвэрлэхээр зорьж техник, технологийн шинэчлэл хийж цахилгаан зуух, шүршдэг базальт технологийн үйлдвэр, дэд цахилгаан станц, үйлдвэрт ажиллах машин механизм, базальт чулуу карьерийн тоног төхөөрөмж, машин механизмийг худалдаж авахаар төлөвлөсөн байгаа бөгөөд богино хугацаанд хийхээр төлөвлөж, татан төвлөрүүлэх хөрөнгийн 2,751,675,500 /хоёр тэрбум долоон зуун тавин нэгэн сая зургаан зуун далан таван мянга таван зуун/ төгрөгийн гэрээ байгуулсан байгаа бөгөөд эдгээр гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ байна. Дээрх худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглаж дотоодын өсч буй хэрэгцээг хангахаас гадна дунд хугацаандаа ОХУ, Хятад, Япон зэрэг улсуудад бүтээгдэхүүнээ экспортлох зорилгоор шинэ тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад 6.4 тэрбум төгрөг шаардлагатай байна. Тус компани нь нээлттэй ХК болсноор Монголын хөрөнгийн биржээс 6,431,538,000 /зургаан тэрбум дөрвөн зуун гучин нэгэн сая таван зуун гучин найман мянган/ төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна. Монголын хөрөнгийн бирж дээр 16,925,100 ширхэг хувьцааг гаргахаар үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ба нэгж хувьцааны үнэ 380 төгрөг байхаар байна.

Компанийн тухай хуулийн 59-69 дүгээр зүйлд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийг хурлыг зохион байгуулж Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 02-р сарын 19-ний өдрийн 2/19-18 тоот тогтоолоор компанийг нээлттэй хувьцаат компани болгохоор шийдвэрлэж, Монголын хөрөнгийн биржид 16,925,100 ширхэг хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн байна. Компанийн хувьцаа эзэмшигчийн хурал хүчин төгөлдөр, хууль ёсны дагуу болсон байна. (*Хавсралт: Компанийн 2018 оны 02-р сарын 19-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол*)

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах зорилгоор Япон улсын Марубени Интекс компанитай чулуун хөвөн бүтээгдэхүүнийг Япон улсын зах зээлд таниулах, худалдааны суваг олох, зах зээлд бүтээгдэхүүн борлуулах мэдээлэлээр хангах зорилготой хамтран ажиллах санамж бичиг, Хятад улсын Бойси-хаусын технологи нэртэй компанитай 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдөр МВ1027/2015 тоот гэрээ байгуулж 1,500,000 долларын бүтээгдэхүүнийг Хятадын зах зээлд борлуулах гэрээ, ОХУ-д бүтээгдэхүүнээ борлуулах зорилготой 2015 оны 8 дугаар сарын 25-нд МБ08252015 тоот гэрээнүүд нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр хэлцэл бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн нийцэж байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа болно.

**2.12 Компанийн толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох.**

Тус компанийн 19 хувийг эзэмшдэг П.Сайнбилэг нь “Термобазальт” ХХК-ийн 100 хувийг дангаараа эзэмшдэг, компанийн 51 хувийг эзэмшдэг Л.Ариунболд нь “Юнимат-Эдюкэйшн” ХХК-ийн 50 хувийг эзэмшдэг бөгөөд эдгээр компаниуд нь Компанийн тухай хуулийн 6.15-д заасны дагуу “Монгол базальт” хаалттай ХК-ийн зэргэлдээ компаниуд юм.

“Монгол базальт” хаалттай ХК нь хараат болон охин компанигүй бөгөөд хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаагаар компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Л.Аруинболд, түүний гэргий П.Сайнбилэг болон тэдгээрийн охидууд А.Энхгэрэл, А.Энхмаа, А.Энхжин нар болно.

**Дүгнэлт**

**“Монгол базальт” хаалттай ХК-ийн Үнэт цаас гаргах танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хуульд нийцсэн байна.**

ДҮГНЭЛТ БИЧСЭН: Б.БАЯРАА

Б.БАТХҮЛЭГ

## 4.3 АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

**БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК**

**“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН**

**2017 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2018 ОН**

БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,
"Монгол эмимпекс концерн" ХХК-ийн байр, 200 тоот
Утас: 324338, 89116465,
98056465, 98006465
И-мэйл: fortune_audit@yahoo.com

2018.03.07 № 42

танай ______________-ны № ______________-т

**"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД**

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

***Зөрчилгүй санал дүгнэлт***

Бид **"Монгол базальт" ХК**-ийн 2017 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр **"Монгол базальт" ХК**-ийн 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх хавсаргасан санхүүгийн тайлангууд (санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ) -нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, заавар, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна.

***Санал дүгнэлтийн үндэслэл***

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

***Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага***

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай

Бүрэн Алтай
2087103
ПЮН02

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭР
1117245378
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

***Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Бидний хүлээх үүрэг хариуцлага бол өөрсдийн гүйцэтгэсэн аудитад тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт өгөх явдал юм. Бид АОУС-ын дагуу аудитаа хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэстэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлангууд дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлангууд дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг сонгохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон тооцоололын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт тодруулгыг үнэлдэг.

**Тайлангийн хэрэглээ**

Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Монгол базальт" ХК-ийн хувь нийлүүлэгчид болон хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд эдгээрээс өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

BEST FORTUNE AUDIT Co.,Ltd
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТ30577 ☎ 5345847

**ЗАХИРАЛ** **Ж. ОЮУНЦЭЦЭГ**

2087103
ПЮН023

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР
5112494
ДУЛААН ТУ... АРЛАГЧ

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК**
*Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,*
*"Монгол эмимпекс концерн" ХХК-ийн байр, 200 тоот*
Утас: 324338, 89116465,
98056465, 98006465
И-мэйл: fortune_audit@yahoo.com

2018.03.07 № 01/18

танай ____________-ны № ____________-т

**"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД**

**УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ**

Бид "Монгол базальт" ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд гэрээний дагуу аудит хийж гүйцэтгэлээ.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, бодлого, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчимд Санхүүгийн Тайлагналын Олон улсын Стандарт болон Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн алдаа, зөрчил бодитой оршин байвал түүнийг материаллаг сул талууд гэж үздэг.

Бид толилуулсан санхүүгийн тайлан, баримт, нөлөө бүхий голлох данс, үзүүлэлтүүдийн талаар аудитын явцад олж мэдсэн зүйл хийгээд хянан тогтоосон мэдээллүүдээ ашиглан, нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагаатай холбоотой асуудалд мэргэжлийн санал /зөвлөмж/-ыг бүртгэл, голлох данс болон тайлангийн агуулгын хүрээнд боловсрууллаа.

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын явцад хамтран ажилласан компанийн удирдлага болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

BEST FORTUNE AUDIT Co.,Ltd
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТ30577 5345847

**ЗАХИРАЛ** **Ж. ОЮУНЦЭЦЭГ**

Бүрэгт Алтай
2087103
ПЮН0220

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МАТЕРИАЛЫН
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
ҮЙЛДВЭР
1117245378
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК

## 2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

(мянган төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2017-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 115,260.0 | 115,260.0 |
| Дансны авлага | 330,337.2 | 330,337.2 |
| Татвар, НДШ-ийн авлага | | - |
| Бусад авлага | | - |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | - |
| Бараа материал | 418,024.4 | 418,024.4 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3,662.4 | 3,662.4 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | - |
| ***Эргэлтийн хөрөнгийн дүн*** | ***867,284.0*** | ***867,284.0*** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 19,388,943.8 | 19,388,943.8 |
| Биет бус хөрөнгө | 2,801,530.7 | 2,801,530.7 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | - |
| ***Эргэлтийн бус хөрөнгийн дүн*** | ***22,190,474.5*** | ***22,190,474.5*** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **23,057,758.5** | **23,057,758.5** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 419,972.3 | 419,972.3 |
| Цалингийн өглөг | | - |
| Татварын өглөг | 271,236.0 | 271,236.0 |
| ЭМ, НДШ-ийн өглөг | | - |
| Богино хугацаат зээл | | - |
| Хүүгийн өглөг | | - |
| Ногдол ашгийн өглөг | | - |
| Урьдчилж орсон орлого | | - |
Тус "Монгол базальт" ХК-ний эзэмшилд байгаа 3 төрлийн эзэмшил газрыг "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон Олон улсын үнэлгээний стандартад заасны дагуу үнэлж өнөөгийн зах зээлийн үнэ, цэнийг тодорхойлов. Үнэлгээний үр дүнг доорхи хүснэгтэд оруулж нэгдсэн дүнг гаргав.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК ДУЛААН ТУСГААРЛАГЧ

*Хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК*

**Үнэлгээний арга, хандлагуудаар тодорхойлогдсон үнэ цэнүүдийн нэгтгэл**

сая төг-өөр

| Газрын байршил | Газрын талбай, м² | Ашигласан үнэлгээний арга | Үнэлгээний дүн |
|---|---|---|---|
| 1. БГД, 20-р хороо | 9462.0 | Зах зээлийн жишиг үнийн “Сонгодог арга” | **4404.7** |
| 2. БГД, 20-р хороо, Моннаб ХХК-ний зүүн урд | 4203.0 | | **1956.6** |
| 3. Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг | 10000.0 | Нормативын арга | **267.0** |
| **Нийт дүн** | - | - | **6628.3** |

### 4.7. Үнэлгээний нэгтгэл, нэгдсэн дүгнэлт

Тус “Монгол базальт” ХК-ний балансад байгаа 7 төрлийн (барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө, эзэмшил газар, базальтын орд г.м) үндсэн хөрөнгийг “Хөрөнгийн үнэлгээний тухай” хууль болон Олон улсын үнэлгээний стандартад заасны дагуу үнэлж өнөөгийн зах зээлийн үнэ, цэнийг тодорхойлов. Үнэлгээний үр дүнг доорхи хүснэгтэд оруулж нэгдсэн дүнг гаргав.

**Үнэлгээний арга, хандлагуудаар тодорхойлогдсон үнэ цэнүүдийн нэгтгэл**

сая төг-өөр

| Хөрөнгийн бүлэг | Хөрөнгийн нэр | Эцсийн үнэлгээ | Тайлбар |
|---|---|---|---|
| А. Барилга, байгууламж /16 нэрийн/ | 1. Барилга | **3452.5** | Энэ тайланд тусгагдсан |
| | 2. Байгууламж | | |
| Б. Тоног төхөөрөмж /32 нэрийн/ | 3. Тоног төхөөрөмж | **9051.3** | |
| В. Тээврийн хэрэгсэл, машин, механизм /14 нэрийн/ | 4. Тээврийн хэрэгсэл | **177.1** | |
| Г. Тавилга, эд хогшил | | **31.7** | |
| Д. Биет бус хөрөнгө | 5. Биет бус хөрөнгө | **2.0** | |
| Е. Эзэмшил газар /3/ | 6. Эзэмшил газрын эзэмших эрх | **6628.3** | |
| Ё. Базальтын орд | 7. Ордын нөөц | **3066.9** | 62-02 тоот тайланд тусгагдсан |
| **Нийт дүн** | | **22409.8** | |

Ингэж үнэлснээр уг барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, машин, механизм, бусад үндсэн хөрөнгө, газар эзэмших эрх, ордын нөөцийн өнөөдрийн зах зээлийн нийт үнэ, цэнийг **22409.8 сая төг (хорин хоёр тэрбум дөрвөн зуун есөн сая найман зуун мянган төг)**-өөр тогтоов.

**Тав. Нийцэлтийн мэдэгдэл**

5.1. Үнэлгээчин энэхүү үнэлгээг хийхдээ ҮОУС-ийн “Дүрэм”-ийн дагуу мэргэжлийн болон ёсзүйн шаардлагуудыг мөрдсөн гэдгээ баталж байна.

- Тайланд тусгагдсан баримт мэдээлэл нь үнэлгээчний мэдэж байгаагаар үнэн зөв;



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
BASALTWOOL УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ БАЗАЛЬТ ХК ДУЛААН ТУСГААРЛАГЧ
2087103

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр



- Шинжилгээ ба дүгнэлт нь тайлагнасан таамаглал, нөхцөл байдлаар хязгаарлагдсан;
- Үнэлгээчин нь хөрөнгөө үнэлүүлж буй байгууллагатай ашиг сонирхлын ямар нэгэн холбоогүй;
- Үнэлгээний ажлын хөлс тайлангийн аль нэг хэсгээс хамааралгүй;
- Үнэлгээчин мэргэжлийн боловсролын шаардлагыг хангасан;
- Үнэлгээчин үнэлж буй хөрөнгийн төрөл, зүйлийн талаар туршлагатай;
- Тайланд тусгайлан дурьдсанаас бусад ямар ч этгээд тухайн тайланг бэлтгэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлээгүй болохыг баталж байна.

5.2. Үнэлгээг Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол улсын холбогдох хуулиуд, Засгийн газрын тогтоол, салбарын яамдын журам зэргийг удирдлага болгон үйлчлүүлэгчийн танилцуулсан албан ёсны баримт бичиг, бусад материалуудад тулгуурлан хийсэн.

5.3. Энэхүү тайланд тусгагдсан үнэлгээний аливаа тооцооллууд нь зөвхөн энэ үнэлгээнд хамрагдаж, түүний салшгүй хэсэг байхын зэрэгцээ тэдгээрийг тайлангийн агуулгаас гадуур ашиглаж үл болно. Энэ үнэлгээний ажил нь зөвхөн энэхүү тайлангийн зорилгуудын хувьд хүчин төгөлдөр болно.

5.4. Тайланд үнэлгээний өдрөөрх хүчин төгөлдөр баримт, материалуудыг ашигласан бөгөөд энэ өдрөөс хойш бий болох өөрчлөлт, аливаа нөхцөл байдал нь үнэлгээний үр дүнд нөлөөлөхгүй болно.

5.5. Үнэлгээг Сангийн сайдын 2017 оны 01-р сарын 11-ний өдрийн 07 тоот тушаалаар олгогдсон хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 07120004 тоот гэрчилгээтэй үнэлгээчин Б.Эрдэнэбаатараар ахлуусан баг гүйцэтгэсэн болно. Энэхүү үнэлгээний ажилд туслах үнэлгээчин Б.Мягмарсүрэн, Э.Мөнх-Уянга нар оролцож ажиллав.

5.6. Үнэлгээний явцад ашигласан мэдээллийн нууцлал, гэрээнд заагдсан холбогдох бусад асуудлыг гүйцэтгэгч хариуцна.

5.7. Үнэлгээний тайланг 2017 оны 12-р сарын 28-наар дуусгавар болгон бичив.

Энэхүү тайланд үнэлсэн хөрөнгийн фото-зургуудыг 1-р хавсралтад оруулав.

**Үнэлгээг гүйцэтгэж, тайлан бичсэн,**

**Хөрөнгийн үнэлгээчин:** **Б.Эрдэнэбаатар**



BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
1117245378

62-01 тоот хөрөнгийн үнэлгээний тайлангийн 1-р хавсралт

## Үнэлгээнд хамрагдсан барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмжүүдийн фото-зургууд

### 1. Барилга, байгууламж



Ерөнхий байдал, урд талаас



Конторын барилга, хойд талаас





Конторын барилга, 1-р давхар



Конторын барилга, 1-р давхар



Конторын барилга, 2-р давхар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

**Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК**



Бэлэн бүтээгдэхүүний агуулах болон хөөсөнцрийн үйлдвэрийн барилга



Хөөсөнцрийн үйлдвэрийн барилга



Хөөсөнцрийн үйлдвэрийн барилга, зүүн талаас



ББ-ний складын барилга, дотор тал



Хөөсөнцерийн үйлдвэрийн барилга,дотор тал



Үйлдвэрийн барилга, зүүн талаас



Үйлдвэрийн барилга, зүүн талаас



BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**_Хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК_**







Вагранк зуухны барилга, хойд талаас



Вагранк зуухны барилгын дотор тал












Үйлдвэрийн барилга, дотор тал



2087103
ПЮН0230

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МАТЕРИАЛЫН
МОНГОЛ
БАЗАЛЬТ
ХК
ҮЙЛДВЭР
ДУЛААН ТУСГААРЛАГЧ

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*


Цавууны цехийн барилга, зүүн урд талаас


Цавууны цехийн барилга, хойд талаас


Цавууны цехийн барилгын дотор тал


Химийн бодисын агуулах, баруун хойд талаас


Ажилчдын цайны газарын барилга, урд талаас


Ажилчдын цайны газар, баруун урд талаас



Конторын өрөө

### Хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК



Цайны газрын заал



Гал тогоо



Халаалтын өрөө



Цилиндр шугам хоолойн үйлдвэрийн барилга



Цилиндр шугам хоолойн үйлдвэрийн зуух



Дотор тал





Цилиндр шугам хоолойн үйлдвэрийн барилгын дотор тал

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
...... он .... сар .... өдөр
01

***Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК***





Цилиндр шугам хоолойн үйлдвэрийн зуухны дотор тал



630 кВа-ын Трансформатор



Бетонон хашаа

**2. Тоног төхөөрөмжүүд**

**2.1. Суурилуулсан тоног төхөөрөмж**



Дизель зуухны байгууламж



Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж



2087103
ПЮН0...30
BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР
1117245378
ДУГААР ТУСГААРЛАГЧ

**Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК**




Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж




Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж




Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

***Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК***




Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж

**2.2. Үйлдвэрийн бусад тоног төхөөрөмжүүд**




Чулуун хөвөн үйлдвэрийн тоног төхөөрөмж



Бутлуур



Шигшүүр

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
ДУГААР ... ГАРЛАГЧ

**Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК**

Компрессор

Электрон жин, жижиг



Компрессор



Компрессор



Суурин өрөм

**3. Тээврийн хэрэгслүүд**

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*



Синотрак, 20тн /73-36 УБВ/



Форд микро /57-79 УБВ/



Экскеватор Hyundai Robex 2200 LC-3



Ковш 30 маркийн



Ландкрузер-105



Маяти, 12-12 УНУ



Лодор



Маз чиргүүл



BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*



Портер



Пад трактор

Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК



Портер



Пад трактор

# БҮЛЭГ 5

## ХАВСРАЛТ









# БҮЛЭГ 5 ХАВСРАЛТ

## Хавсралт 1 Үнэт цаас гаргагчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ



МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2007.01.22

9010001085

5112494

Монголбазальт Хувьцаат компани

Дүрэм

Шийдвэр 01 2007.01.22

511000 Гадаад худалдаа

269500 Барилгын материалын үйлдвэрлэл

Хугацаагүй 5 3.949.190,0

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, [illegible] тайван ерөнх чөлөө, 10 - 3 тоот. утас1:331056, утас2:91118508, факс:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН АЛБАУлсын бүртгэлийн алба

Гэрчилгээ [illegible] 2009 он 04 сар [illegible]

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**Хавсралт 1 үргэлжлэл**

### Харилцах банкны бүртгэл:

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн | |
|---|---|---|---|---|
| | | | Огноо | Ажилтан, тэмдэг |
| ХХБ СБД 4х 809-р ТТ | Төгрөгийн | 409012093 | 2007.01.22 | Ж.Төмөрсүх |

### Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тэмдэг |
| | Энэ хуулийн этгээдэд 2007.01.22 өдөр олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, гэрчилгээг дахин олгосон болно. | 2009.04.15 | М.Баяржаргалант |
| 1 | Капитал банк банкны 2000020249 тоот төгрөгийн дансыг бүртгэв | 2011.11.[illegible] | М.Баяржаргалант |
| 2 | Голомт төв банк банкны 2010001351 тоот төгрөгийн дансыг бүртгэв | 2011.12.21 | Д.Чулуунтуяа |
| 3 | Голомт төв банк банкны 2010001352 тоот валютын дансыг бүртгэв. | 2011.12.21 | Д.Чулуунтуяа |
| 4. | Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэв. | 2015.05.29 | Ж.Нямдорж |
| 5. | Дүрэм шинэчилснийг бүртгэв. | 2016.09.08 | Д.Лхасо |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Булган Алтай
2087102
ПЮН02

BASALTWOOL
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР
1117245378
ДУНД ТУСГААРЛАГЧ

**Хавсралт 2 Үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 19 -ны өдөр | № 2/19-18. | Улаанбаатар хот

"Монгол Базальт" хаалттай хувьцаат компанийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, нэмж хувьцаа гаргах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн, 62.1.2, 62.1.3 болон 62.1.8 Компанийн дүрмийн 4-р бүлэг, 6-р бүлгийн, 6.5.2, 6.5.6, 6.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол Базальт" хаалттай ХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсугай.
2. Компанид нэмэлтээр 16,925,100 ширхэг энгийн хувьцаа буюу компанийн нийт хувьцааны 30% хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргасугай.
3. Нэмж гаргаж буй нэгж хувьцааны худалдах үнийг 380 төгрөгөөр тогтоон Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалсугай.
3. Олон нийтээс татан төвлөрүүлэх нийт 6,431,538,000 /зургаан тэрбум дөрвөн зуун гучин нэг сая таван зуун гучин найман мянган/ төгрөгийг Хавсралт 1-д заасны дагуу компанид шинэ тоног төхөөрөмж худалдан авах, базальт ордын шинэчлэл, ээлийн эх үүсвэрийг бууруулах болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор зарцуулсугай.
4. Компанийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчилсөнтэй холбогдуулан компанийн дүрмийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчилж, дүрмийн төсөлд дараах байдлаар өөрчлөн найруулж, нэмж гаргаж буй хувьцаа арилжаалагдсны дараа шинэ хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр, анхдугаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсугай.
   4.1. Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56,417,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна.
   4.2. Компани нь нийт 5,641,700,000 /таван тэрбум зургаан зуун дөчин нэгэн сая долоон зуун мянган/ төгрөгийн үнийн дүн бүхий нийт 56,417,000 ширхэг хувьцаатай байна. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.

**Хавсралт 2 үргэлжлэл**

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

5. Компанийг нээлттэй Хувьцаат компани болгохтой холбоотой ажлыг удирдан зохион байгуулахыг Ерөнхий захирал (Л.Ариунболд)-д, үнэт цаас гаргахтай холбогдуулан гарсан зардлыг тооцож үнэт цаас гаргахад оролцогч талуудтай байгуулсан гэрээний дагуу зарцуулахыг Санхүү эрхэлсэн захирал (П.Сайнбилэг)-д, бусад холбогдох материалыг бүрдүүлэхийг Судалгаа хөгжил эрхэлсэн захирал (П.Батмөнх) нарт тус тус даалгасугай.

6. Олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж буй хувьцааг Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1-н дагуу тогтоосон үнийн аргаар санал болгосугай.

7. Нэмж хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан энгийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцаатай хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд хувьцааг худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

8. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга (П.Батмөнх), ТУЗ-н нарийн бичиг (Ч.Зоригтбаатар)-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Л.АРИУНБОЛД

"Монгол базальт" ХК-йн Хувьцаа эзэмшигчдийн 2018
оны ..... дүгээр сарын ....-ны өдрийн хурлын
...... тоот тогтоолоор батлав.

# "МОНГОЛ БАЗАЛЬТ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 "Монгол Базальт" компани нь Монгол Улсад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани /цаашид "компани" гэж нэрлэнэ/ болно.

1.2 Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Компанийн оноосон албан ёсны нэр:

- Монголоор: "Монгол Базальт" хувьцаат компани (цаашид "Монгол Базальт" ХК гэж товчилно.)
- Англиар: "Mongol Basalt" Joint Stock Company гэнэ.

1.4 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Фламинго Тауэрын 7 давхар

1.5 Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.6 Компани нь ТУЗ-ийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компани байгуулж болно.

1.7 Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас тэмдэгтэй байна.

1.8 Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэж нэрлэх/ баталж, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байна.

1.9 Компанийн бэлгэдэл, барааны тэмдгийг хэрэглэх эрхийг зөвхөн "Монгол Базальт" ХК эдэлнэ.

1.10 Компани нь удирдлага, компанийн засаглал сайтай, ил тод, нээлттэй, нийгмийн болон хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хариуцлага хүлээсэн компани байна.

## Хоёр. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1 Компани нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- Барилгын материалын үйлдвэрлэл;
- Гадаад дотоод худалдаа;
- Төсөл хөтөлбөр;
- Сургалт судалгаа;

## Гурав. Хувь нийлүүлсэн хөрөнгө

3.1 Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56,417,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна.

3.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 5 641 700 000 /таван тэрбум зургаан зуун дөчин нэгэн сая долоон зуун мянган/ төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.

3.3 Компанийн давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай" хуульд заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх,

тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрт заасан байна.

3.4 Шинээр давуу эрхийн хувьцаа гаргах болон энгийн хувьцаа нэмж гаргасан тохиолдолд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

3.5 Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө болон хувьцааны тэнцлийн /дансны/ үнэ нэмэгдэнэ. Хувьцааны тоо өөрчлөгдөхгүй. Компанийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан өөрийн хөрөнгийн дүнг нийт гаргасан хувьцааны тоонд хувааж хувьцааны тэнцэлийн үнийг тодорхойлно.

3.6 Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийг өөрийн хөрөнгөгүй ба хувьцаны тэнцлийн үнэ буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

3.7 Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлсэн тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны тэнцлийн үнэ нэмэгдэж, хорогдоно.

**Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага**

4.1 Хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

4.1.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

4.1.2 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хулийн 26 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

4.1.3 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ хангана.

4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахдаа эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндсэлэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй. Үүнд:

4.2.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компаний болгон өөрчлөх;

4.2.2 Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;

4.2.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

4.3 Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчид нь жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс өмнө хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д гишүүн нэр дэвшүүлэх эрхтэй.

4.4 Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрмийн 4.5-д заасан эрхээ эдлэх баталгаа болно.

4.5 Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 болон 96 дугаар зүйлийн 96.1-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.

4.6 Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

4.7 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

4.8 Хувьцаа эзэмшигчийн компанид орулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно.

**Тав. Компанийн үнэт цаасыг гаргах**
**худалдах, эргүүлэн авах**

5.1 Компани нь энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах опцион зэрэг үнэт цаас гаргаж болно.

5.2 Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн үед Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

5.3 Зарласан хувьцаанаас нэмж гаргах асуудлыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.

5.4 Нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд хувьцаа худалдаж авах эрхийн бичиг гаргана. Энэ эрхийн бичгээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлнэ.

5.5 Компани өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

5.6 Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

Опцион худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо, нэгж опцион эзэмшигчдийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционыг санал болгох үнэ зэргийг заасан байна.

5.7 Хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.

5.8 Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн болон эрхийн хэлбэрээр хийж болно.

5.9 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

**Зургаа. Компанийн удирдлага**

6.1. Хувьцаа эзэмшигчийн хурал:

6.1.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

6.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

6.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор ТУЗ зарлан хуралдуулна.

6.1.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

6.1.5. Дор дурдагдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

6.1.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;

6.1.5.2. Нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

6.1.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих;

6.1.5.4. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

6.1.5.5. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

6.1.5.6. Зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх;

6.1.5.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

6.1.5.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;

6.1.5.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт болон Хянан шалгах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах;
6.1.5.10. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор шийдвэрлэх;
6.1.5.11. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
6.1.5.12. Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;
6.1.5.13. Төлөөлөн удирдах зөвлөл төсвийг батлах;
6.1.5.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
6.1.5.15. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасан бусад;
6.1.5.16. ТУЗ-өөс Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

6.1.6. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тогтоохдоо тухайн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүдийн тоогоор үржүүлэх замаар кумулятив[19] аргаар тооцно.
6.1.7. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
6.1.8. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшгчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
6.1.9. Саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.
6.1.10. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Харин ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигч заавал биечлэн буюу итгэмжлэлээр оролцоно.
6.1.11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнхи олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
6.1.12. Хуралд биечлэн оролцох хувьцаа эзэмшигч, мөн хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдөр хүртэл бүртгэнэ.
6.1.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхдээ хамаарах асуудлыг эчнээ санал хураалтаар шийдвэрлэж болно. Энэ заалт нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хамаарахгүй. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтэн гаргах тооллогын комиссын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох эрхтэй.
6.1.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон дарга баталгажуулан гарын үсэг зурна.

6.2. Төлөөлөн удирдах зөвлөл:
6.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.
6.2.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна.
6.2.3. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.
6.2.4. ТУЗ нь гишүүд дотроос Зөвлөлийн даргыг сонгоно.

[19] СЗХ-ны "Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам"-ыг хэрэглэнэ.

6.2.5. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.5.1. Энэ дүрэмд заасан үнэт цаас гаргах шийдвэр гаргах;

6.2.5.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн бүтэц, зохион байгуулалт, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох буюу компанийн урт, дунд хугацааны стратеги болон жил бүрийн бизнес төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

6.2.5.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

6.2.5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

6.2.5.5. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээний талаар санал оруулах;

6.2.5.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

6.2.5.7. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийг өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, компанийн гүйцэтгэх захирал болон компанийн үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг хэрэгжүүлэх;

6.2.5.8. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хүргэх түвшин, өртөг зардал, ашиг зэрэг асуудлуудыг тусгах;

6.2.5.9. ТУЗ-ийн дарга гүйцэтгэх захирлыг гадаадад томилолтоор ажиллах удирдамж төсвийг батална. ТУЗ-ийн Хурлаар томилолтын үр дүнг хэлэлцэнэ.

6.2.5.10. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;

6.2.5.11. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

6.2.5.12. Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;

6.2.5.13. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

6.2.5.14. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.2.5.15. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

6.2.5.16. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

6.2.5.17. Эрх бүхий албан тушаалтнаас компанид учруулсан хохирлыг нэхэмжлэл гаргах;

6.2.5.18. Гадаад, дотоодын байгууллага, банктай хамтран ажиллах, хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах, компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр компанийн хөрөнгө барьцаалах, баталгаа гаргах;

6.2.5.19. Компанийн ажилтан нарын нийгмийн асуудалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;

6.2.5.20. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал;

6.2.5.21. Компанийн дотоод аудитын газрын дарга, ажилтнуудыг томилох, цалин, хөлсний хэмжээг тогтоох, ажиллах журмыг батлах;

6.2.5.22. Орон нутагт салбар зөвлөл, мэргэжлийн болон бизнесийн зөвлөл зэргийг байгуулан, үйл ажиллагааных нь журмыг тогтоож, төсвийг батлах;

6.2.5.23. Хуульд заасан бусад.

6.2.6. ТУЗ-ийн хурлыг улирлал нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд дарга гарын үсэг зурна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.

6.2.7. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал /гүйцэтгэх удирдлага/ болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

6.2.8. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-өөс томилно. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж протокол хөтөлж хадгална. Хурлын тухай зар, материалыг хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн гишүүдэд хүргэнэ.

6.2.9. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана. ТУЗ-ийн дарга оролцох боломжгүй тохиолдолд түүний итгэмжлэгдсн ТУЗ-ийн гишүүн хурлыг удирдана.

6.2.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

6.2.11. Тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.

6.2.12. ТУЗ-ийн гишүүн 6 сараас дээш хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал хэлэлцэх Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэлх хугацаанд ТУЗ-өөс тухайн гишүүнийг орлох этгээдийг томилно.

6.2.13. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүд 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

6.2.14. ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

6.2.15. ТУЗ-ийн өөрийн дэргэд үйл ажиллагаагаа үр өгөөжтэй байлгахын тулд байнгын болон түр хороог байгуулж болно. Харин аудитийн, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог заавал байгуулах бөгөөд хууль, компанийн засаглал, ил тод байдлын болон хөрөнгө оруулалт-санхүү, эрсдэлийн дэд хороодтой байж болно. Тэдгээрийн чиг үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

6.2.16. ТУЗ-ийн гишүүдийн хууль бус үйл ажиллагаанаас компанид хохирол учруулсан бол ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

6.3. Гүйцэтгэх удирдлага:

6.3.1. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон контрактаар ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

6.3.2. ТУЗ компанийн гүйцэтгэх захирлыг томилж, түүнтэй контракт байгуулна. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гэрээний үндсэн дээр багаар хэрэгжүүлж болно.

6.3.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирлаар давхар ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх зэрэг Монгол улсын Компанийн тухай хууль болон энэ дүрэмд заасан эрх эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

6.3.3.1. Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулж ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.3.3.2. Хараат /охин/ компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулан батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн гэрээ болон контракт гэрээг байгуулах;

6.3.3.3. Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна.

6.3.3.4. Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмыг батлах;

6.3.3.5. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал, шийдвэр гаргах;

6.3.3.6. Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-өөс олгосон эрхийн хүрээнд гэрээ хэлцэл, хэлэлцээр байгуулах;

6.3.3.7. Энэ дүрэм, ТУЗ-өөс олгосон эрхийн хүрээнд компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

6.3.3.8. Монгол Улсын хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан тогтоол, ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

6.3.3.9. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;

6.3.3.10. Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана.

6.3.3.11. ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар ажлаа хариуцан тайлагнана.

6.3.3.12. Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлсөн буюу тэрээр чөлөөлөгдөх хүсэлт тавьсан тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

6.3.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн даргад гаргаж болно.

6.3.5. Гүйцэтгэх захирал нь томилогдсоноосоо хойш 15 хоногийн дотор гарын үсгийн хэвийг бүртгэх байгууллагад тэмдэглүүлнэ.

**Долоо. Компанийн эрх бүхий албан**
**тушаалтны хүлээх хариуцлага**

7.1. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багын гишүүд, ерөнхий нягтлан бодогч, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, ТУЗ-өөс гаргасан тогтоол, дүрэм, журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирлын төлөө ашиглахыг хориглоно.

7.3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хуриуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг түүнтэй байгуулсан хөдөлмөрийн болон контракт гэрээ, компанийн дотоод дүрэм, журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ. Хариуцлагыг Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасны дагуу хүлээлгэнэ.

**Найм. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа,**
**бүртгэл тайлан, ногдол ашгийн хуваарилалт**

8.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан:

8.1.1. Компани Монгол Улсын хуулиар тогтоосон журам болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөн сар, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

8.1.2. Компанийн санхүүгийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна.

8.1.3. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлага нь компанийн хувьцаа эзэмшигч нараас дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй, зориулалт ёсоор компанийн үндсэн зорилго, зорилтын дагуу зарцуулна.

8.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан:

8.2.1. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтөлнө:

8.2.2. Үнэт цаас, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг компани хариуцна. Үнэт цаасны бүртгэлийг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулан хөтлүүлнэ.

8.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон хурлын шийдвэрийн бүртгэл, хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр, саналын хуудас, тооллогын комиссын шийдвэр;

8.2.4. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрийн бүртгэл, энэ бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

8.2.5. Аудитын хорооны хурлын тэмдэглэл, шийдвэрийн бүртгэл, энэ бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

8.2.6. Компанийн дүрэм, журам, бусад этгээдтэй байгуулсан бүх гэрээ хэлцэл, хэлэлцээр;

8.2.7. Ирсэн, явсан албан бичиг түүний бүртгэл;

8.2.8. Хууль болон эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар тогтоосон заавал хөтлөх бүртгэл;

8.3. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:

8.3.1. баланс;

8.3.2. орлого, үр дүнгийн тайлан;

8.3.3. мөнгөн гүйлгээний тайлан;

8.3.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;

8.3.5. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий хэлцэлийн жагсаалт, төрөл, үнийн дүн, хэлцэлд оролцогч талуудын мэдээлэл;

8.3.6. нэмэлт, тайлбар, тодруулга;

8.3.7. бусад.

8.4. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзэлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

8.5. Санхүүгийн жилийн тайланг хөндлөнгийн аудитаар хянуулаж, үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хурал танилцуулна.

8.6. Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын болон Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайдын баталсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт, аргачлал мөрдөнө.

8.7. Компани Монгол улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон гадаад валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани гадаадын банкинд гадаад валютын данс нээх болон ТУЗ-өөс зөвшөөрөл авна.

8.8. Ногдол ашгийн хуваарилалт:

8.8.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргана. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

8.8.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон компанийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

8.8.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

8.8.3.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

8.8.3.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

8.8.3.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

8.9. Ногдол ашиг, хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд өөрийн ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

8.10. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно.
Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

## Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт

9.1. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулна.
9.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.
9.3. Аудитын хороо аудитортой байгуулах гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
9.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
9.5. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
9.6. Ээлжит бус шалгалтыг төлөөлөн удирдах зөвлөл, түүний аудитийн хороо, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар хэдийд ч хийж болно.
9.7. Аудитын байгууллагын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлнө.
9.8. Шалгалтын явцад компаний эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.
9.9. Компаний эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
9.10. Компанийн тухай хуулийн 94.10-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны буруугаас аудитын байгууллагын буюу аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
9.11. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
9.12. Дор дурдсан этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:
   9.12.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
   9.12.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;
   9.12.3. аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанитай хэлцэл хийсэн этгээд бол.
9.13. Компанийн тухай хуулийн 94.13-т заасныг зөрчиж аудиторыг сонгосон бол түүний аудитын дүгнэлтийг хүчингүйд тооцно.
9.14. Аудитын байгууллагын гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан олгох хөлсний хэмжээ тогтоохыг хориглоно.
9.15. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт /баримтын шалгалт/-ын дүнг үндэслэн компанийн аудитор нь дараах мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:
   9.15.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;
   9.15.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлох;
   9.15.3. шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жгасаалт, уг хэлцлийг журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;
   9.15.4. хувьцаат компанийн хувьд үнэт цасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл;
   9.15.5. компанийн дүрэм болон аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тодорхойлсон бусад мэдээлэл.

9.16. Аудитын байгууллага нь өөрийн хийсэн аудитын дүгнэлтээс үүссэн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

**Арав. Нэгдмэл сонирхолтой этгээд**

10.1. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан, компанийн хувьцааны 5 дээш хувийг эзэмшигч этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ. Үүнд:

10.1.1. тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр;
10.1.2. тэдгээрийн эцэг, эх, хүүхдүүд, ач зээ болон бусад төрөл, садан;
10.1.3. тэдгээр нь өөрсдийн ажиллаж буй болон хувьцаа эзэмшидэг компанитай хийгдэж буй хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар хүртэж буй тохиолдолд уг гэрээг хийгч этгээд;
10.1.4. нэг гэр бүлийн гишүүд, эхнэр нөхөр, эцэг эх, хүүхдүүд, ач зээ нар ах дүүс, бусад төрөл садан;
10.1.5. нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид;
10.1.6. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани;
10.1.7. уг этгээд ажил олгогч бол, түүний ажилтнууд.

**Арван нэг. Компанийг татан буулгах**

11.1. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, Компаний тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

11.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана:

11.2.1. дор дурдсан нөхцөл байдал бий болсон, эсхүл удаан хугацаагаар үргэлжилж байгааг харгалзан хувьцаа эзэмшигч аль нэгэн талын гаргасан саналыг авч хэлэлцээд санал нэгтэй шийдвэр гаргасан;
-Компанийн үйл ажиллагаа алдагдалтай, цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
-Компанийг татан буулгахыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи зөвөөрсөн;
-Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэл;
-Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи нь компанийг хуваах өөр компанид нэгдэх шийдвэр гарсан.

11.2.2. Монгол Улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:
-Дампуурсан;
-Нэг ч гишүүн үлдээгүй;
-Хуульд заасан бусад үндэслэл.

11.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хурал оролцогчдын саналын дийлэнх олохиор шийдвэрлүүлнэ.

11.4. Татан буулгах комисс томилсноор тус компанийн гүйцэтгэх захирал буюу гүйцэтгэх удирдлгын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно. Татан буулгах комисс дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

11.4.1. компанийг татан буулгах шийдвэрийг нийтэд мэдээлэх;
11.4.2. дуусгалтын баланс, тайлан гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
11.4.3. өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулах;
11.4.4. үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилах;
11.4.5. татан буулагх ажиллагаа дууссаныг татварын албанд мэдэгдэх.

11.5. Татан буулгах комисс үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасны дагуу хариуцна.

